

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2025



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2025

Төрийн аудитын тухай хуульд заасан нээлттэй, ил тод байх зарчмын дагуу Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэв.

Энэхүү тайлантай холбоотой санал, хүсэлт, тодруулах зүйлээ Үндэсний аудитын газрын цахим шуудан (info@audit.gov.mn)-д ирүүлэх боломжтой.

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг Та бүхэнд өргөн барьж байна.

Төрийн аудитын үйл ажиллагаа улсын төсөв, нийгэм, эдийн засгийн орчны өөрчлөлт, төрийн санхүүгийн сахилга бат, хариуцлагад тавих хүлээлт нэмэгдсэн цаг үед хэрэгжлээ.

Тайлант хугацаанд төрийн аудитын байгууллага Монгол Улсын төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагнал, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, сангуудын удирдлага, дотоод хяналтын тогтолцоо зэрэг төрийн санхүүгийн удирдлагын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг богино хугацаанд бүхэлд нь хамруулахыг зорьсон бөгөөд аудитын цар хүрээ, хамрагдалт, хувьд чанар, агуулгын түвшинд тэлж, бодлогын ач холбогдол бүхий асуудлуудад анхаарал хандуулахыг чухалчиллаа.

Бид төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, 2025 онд санхүүгийн тайлангийн 3,677, гүйцэтгэлийн 94, нийцлийн 183, нийт 3,954 аудитыг хийж гүйцэтгэсэн байна. Аудитын дүнд 57.4 тэрбум төгрөгийн 3,014 төлбөрийн акт тогтоож, 14.4 их наяд төгрөгийн 7,424 албан шаардлага, 5.4 их наяд төгрөгийн 11,998 зөвлөмж, 437.9 тэрбум төгрөгийн 296 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, 55.8 тэрбум төгрөгийн 51 асуудлыг хууль хяналтын байгууллагад тус тус шилжүүлсэн байна. Нийт мөнгөн дүнгээр авч үзвэл 20.3 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар 10.9 их наяд төгрөгийн алдааг залруулжээ.

Тайлант хугацааны төрийн аудитын дүнд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн үр дүнд улс, орон нутгийн төсөвт нийт 62.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

2025 онд Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагааны зохион байгуулалт, чанар, хариуцлагыг сайжруулах, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын шинэлэг өөрчлөлтүүдийг бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч, стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийг гаргаж хэрэгжүүлжээ.

Төрийн аудитыг мэргэшсэн, олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд олон улсын төрийн аудитын суурь хэд хэдэн стандартыг баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, “АДБОУС 140 АДБ-ын чанарын удирдлага” болон “АДБОУС 150 Аудиторын чадамж” стандартыг баталж, “Аудитын чанарын удирдлагын тогтолцоо”, “Аудитын нөлөөллийн төлөвлөлт”, “Аудитын нөлөөлөл тооцох, мөрөөр хяналт тавих найдвартай тогтолцоог бий болгох нь” гарын авлага, “Гүйцэтгэлийн аудит дахь материаллаг байдал”, “Гүйцэтгэлийн аудит дахь залилангийн эрсдэлийн үнэлгээ”, “Гүйцэтгэлийн аудит дахь баримтжуулалт” зэрэг судлан шинжлэх баримт бичгийг Стандартын хороогоор хэлэлцэн дэмжсэнийг нэвтрүүлж эхэллээ.





Цахим шилжилтийг хурдасгах, төрийн аудитын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор орон тооны бус “Мэдээлэл, технологийн удирдах хороо”, “Мэдээлэл, технологийн хэрэглэгчийн хороо”-г улс, орнуудын АДБ-уудын сайн туршлагад нийцүүлэн байгуулж ажиллуулаад байна.

Бид энэхүү тайландаа Төрийн аудитын байгууллагын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэсэн болон бодлогын сэдвээр аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын гүйцэтгэсэн асуудлуудыг нэгтгэн танилцуулж байна.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааг Танд танилцуулж, төрийн аудитын үр нөлөөг үнэн зөвөөр үнэлэх, бидний хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх цаашдын үйл ажиллагаанд ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Бидний зүгээс 2026 оныг “Аудитын нөлөөллийг тооцох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлэх” жил болгон зарлаж, төрийн аудитын бодлого, үйл ажиллагааг засаглалын ил тод байдал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралд эерэг өөрчлөлтийг бий болгоход чиглүүлж, аудитын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн итгэл, хүлээлтэд нийцсэн хараат бус аудитын байгууллага байх зорилгоо тууштай хэрэгжүүлж ажиллах болно.

A handwritten signature in black ink, consisting of stylized, flowing characters.

Монгол Улсын Ерөнхий аудитор
Сандагийн МАГНАЙСҮРЭН



- 10 Онцлох үйл явдал-2025 он
- 12 Товчилсон үгийн тайлбар

16 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

- 18 ■ Тайлангийн зорилго, хамрах хүрээ
- 19 ■ Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин-Чиг үүрэг ба Хариуцлага
- 21 ■ Бүтэц, зохион байгуулалт
- 24 ■ Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны зорилт, хэрэгжилт

30 ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН АУДИТЫН 2025 ОНЫ АУДИТЫН ДҮН

- 32 ■ Аудитын төрөл, хамрах хүрээ
 - Санхүүгийн тайлангийн аудит
 - Гүйцэтгэлийн аудит
 - Нийцлийн аудит
- 33 ■ Аудитын илрүүлэлтийн хураангуй
- 36 ■ Аудитын шийдвэр, түүний хэрэгжилт
- 43 ■ Аудитын үр өгөөж
- 46 ■ Аудитын дүн

84 ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН АУДИТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 86 ■ Чанарын удирдлагын тогтолцоо
- 88 ■ Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянах тогтолцооны шинэчлэл
- 90 ■ Дотоод аудитын үр дүн
- 91 ■ Дижитал шийдэл, өгөгдөл ашиглалт
- 92 ■ Дижитал аудитын хэрэгцээ, ирээдүйн чиг хандлага
- 94 ■ Харилцагч талуудтай харилцах харилцаа
- 97 ■ Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
- 100 ■ Ил тод байдал
- 102 ■ Хүний нөөц, чадавхын хөгжил
- 105 ■ Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал

108 ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

ДҮГНЭЛТ

- 110 ■ Төрийн аудитын байгууллага-2025 он
- 111 ■ Төрийн аудитын байгууллага-2026 оны бодлого, чиг хандлага

112 ТАВДУГААР БҮЛЭГ.

ХАВСРАЛТ

- 114 ■ Хараат бус аудиторын дүгнэлт
- 116 ■ Үйл явдлын товчоон-2025 он
- 118 ■ Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилт
- 121 ■ Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэсэн аудит
- 122 ■ АНТАГ-ын тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлэлт

124 СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол-Лаосын Төрийн аудитын байгууллагын хамтын ажиллагааг эхлүүлэв.



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 2 дугаар сард БНАЛАУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд хоёр улсын Төрийн аудитын байгууллага АДБОУБ болон АДБАБ-ын зорилго, зарчимд нийцүүлэн хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Энэхүү баримт бичиг нь аудитын арга зүй, хүний нөөц, хамтарсан санаачилгыг хөгжүүлэх урт хугацааны хамтын ажиллагааны суурь болов.

E-Mongolia-аар дамжуулан аудитын сэдэвт иргэдийн санал авах үйлчилгээг нэвтрүүлэв.



Төрийн аудитын байгууллага төрийн мэдээллийн нэгдсэн систем E-Mongolia платформуор "Аудитын сэдэвт санал авах" үйлчилгээг нэвтрүүлж, тухайн жилд гүйцэтгэх аудитын сэдвийг иргэд, олон нийтийн оролцоонд суурилан тодорхойлох боломжийг бүрдүүлэв. Ингэснээр аудитын сэдэв сонголт илүү нээлттэй, ил тод болж, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцэх нөхцөл сайжирсан.

Аймаг дахь Төрийн аудитын газар УИХ-ын Төсвийн байнгын хороонд аудитын дүн танилцуулав.




Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын удирдаж гүйцэтгэсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт" сэдэвт аудитын дүнг хэлэлцүүлэв.

"Улаанбаатар төмөр зам" ХНН-д Монгол-Оросын хамтарсан аудит хийв.



Монгол Улсын Төрийн аудитын байгууллага ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн 2021-2023 оны үйл ажиллагаанд хамтарсан аудит хийж, менежмент, хөрөнгө оруулалт, үр ашигт цогц үнэлгээ өглөө. Сүүлийн 10 жилд хийгдээгүй олон улсын хамтарсан аудит хэрэгжсэн нь ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

АДБОУБ-ын Их өгөгдлийн ажлын хэсгийн IX чуулганд оролцов.



БНХАУ-ын Харбин хотод зохион байгуулагдсан АДБОУБ-ын Их өгөгдлийн ажлын хэсгийн IX чуулганд Монгол Улс бүрэн эрхт гишүүнээр оролцов. Уг арга хэмжээ нь их өгөгдөл, хиймэл оюун ухааныг аудитад ашиглах олон улсын чиг хандлагыг судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бүрдүүлэв.

Цахим аудит, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ТИКА-тай хамтын ажиллагааг эхлүүлэхээр хэлэлцэв.



Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн БНТУ-ын ТИКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж, хиймэл оюун ухаанд суурилсан цахим аудит нэвтрүүлэх, албан хаагчдыг сургах чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов. Энэхүү хамтын ажиллагаа нь аудитын дижитал шилжилтийг хурдасгах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Монгол-Киргизийн Аудитын дээд байгууллагууд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



БНКУ-ын Тооцооны танхимын даргын айлчлалын үеэр Монгол, Киргизийн Аудитын дээд байгууллагууд харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Уг санамж бичиг нь хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, олон улсын стандарт нэвтрүүлэх, хамтарсан аудитын санаачилгыг хөгжүүлэх урт хугацааны хамтын ажиллагааны эхлэл боллоо.

АДБОБ-ын XXV Конгресст (Египет) Монгол Улсын төлөөлөгчид оролцов (2025 оны 11 дүгээр сар)



Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын төлөөлөгчид Египет Улсад зохион байгуулагдсан АДБОУБ-ын XXV Конгресст (INCOSAI) оролцож, аудитын чанар, дижитал шилжилт, хиймэл оюун ухааныг аудитад ашиглах олон улсын шинэ чиг хандлагын талаарх хэлэлцүүлэгт оролцов. Энэхүү оролцоо нь Төрийн аудитын байгууллагын стратегийн шинэчлэл, өгөгдөл, болон инновацад суурилсан арга хандлагыг үндэсний түвшинд нутагшуулахад чиглэсэн бодлогын суурийг бэхжүүлэх ач холбогдолтой байв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБ	Аудитын Дээд байгууллага
АДБАБ	Аудитын Дээд Байгууллагуудын Азийн байгууллага
АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АХЭ	Аудитын хуулийн этгээд
АШХГ	Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар
БНКУ	Бүгд Найрамдах Киргиз Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НАГ	Нийцлийн аудитын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТИКА	Турк Улсын Хамтын ажиллагаа зохицуулах агентлаг
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТАГ	Төрийн аудитын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЧҮАГ	Тусгай чиг үүргийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
УИХ	Монгол Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь Төрийн аудитын байгууллага байна.



ТӨРИЙН АУДИТЫН ҮНДСЭН ЗОРИЛТ

Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ (2025–2030)



АЛСЫН ХАРАА

Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар манлайлагч Аудитын дээд байгууллага болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, аудитын үр дүнгээр иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС



**ХАРААТ БУС,
БИЕ ДААСАН БАЙХ;**



**ХАРИУЦЛАГАТАЙ, ИЛ
ТОД, НАЙДВАРТАЙ БАЙХ;**



**ЁС ЗҮЙ, ШУДАРГА
БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХ.**

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1

Төрийн аудитад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, төрийн аудитын үр нөлөөг дээшлүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2

Төрийн аудитыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, төрийн үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн хариуцлагатай, ил тод, шударга байдлыг бэхжүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3

Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй Аудитын дээд байгууллага байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ҮР ДҮН

3,954

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ



3,677

САНХҮҮГИЙН АУДИТ

94

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

183

НИЙЦЛИЙН АУДИТ



10,979.8
тэрбум төгрөг
Залруулсан алдаа

илэрсэн зөрчил
20,277.4
тэрбум төгрөг



11,998
Зөвлөмж

1,521.1
тэрбум төгрөг
Хүлээн зөвшөөрүүлсэн
үр өгөөж



7,424
Албан шаардлага

62.8 тэрбум төгрөг
Улс, орон нутгийн төсөвт
төвлөрүүлсэн орлого



3,014
Төлбөрийн акт

32.1 төгрөг
Нэг төгрөгт ногдох
санхүүгийн үр өгөөж



51
Хуулийн байгууллагад
шилжүүлсэн асуудал

541
Нийт албан хаагч



сахилгын шийтгэл ногдуулах



296
албан шаардлага

105
Сургалтын багц



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



- Тайлангийн зорилго, хамрах хүрээ
- Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин-чиг үүрэг ба хариуцлага
- Бүтэц, зохион байгуулалт
- Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны үйл ажиллагааны зорилт, хэрэгжилт



2025 ОНЫ ЗОРИЛТ

"ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ"



ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

ЗОРИЛГО:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлсэн аудитын үйл ажиллагааны үр дүн, аудитын шийдвэрийн хэрэгжилт, төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийн удирдлага, хяналтад тавьсан аудитын үр дүнг Улсын Их Хурал, Засгийн газар, олон нийт болон харилцагч талуудад ил тод мэдээлж, төрийн аудитыг сайжруулах бодит үндэслэл бүхий шийдвэр гаргалтыг дэмжихэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан нь үндсэн чиг үүрэг, тэдгээрийн гүйцэтгэл, үр дүнг хамарна. Үүнд төрийн аудитын үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн болон тусгай чиг үүргийн аудит, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн хяналт болон бодлого, төлөвлөлт, мэдээллийн технологи, чанарын удирдлага, дотоод аудит зэрэг дэмжих нэгжүүдийн гүйцэтгэл, байгууллагын цаашдын бодлого, чиглэлийг хамарсан.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН-ЧИГ ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА

Чиг үүрэг:

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт болон Төрийн аудитын тухай хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд улсын төсөв, төрийн санхүүгийн үйл ажиллагаа, нийтийн өмчийн ашиглалт, төрийн байгууллагын гүйцэтгэлд хараат бус хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Төрийн аудитын тухай хуулийн:

- **6 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх**-Төрийн аудитын байгууллага нь улсын төсөв, санхүү, улсын болон орон нутгийн өмч, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд аудит хийх бүрэн эрхтэй.
- **7 дугаар зүйл. Төрийн аудитын төрөл, хэлбэр**-Төрийн аудит нь санхүүгийн тайлангийн аудит, нийцлийн аудит, гүйцэтгэлийн аудит болон бусад хэлбэрээр хэрэгжинэ.
- **11 дүгээр зүйл. Аудитын төлөвлөлт**-Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг хуульд заасны дагуу болон төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудит гэж ангилан Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- **20 дугаар зүйл. Төрийн аудитын тайлан**-Аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана. Аудитын тайланг шалгагдагч этгээд, Улсын Их Хурал, шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.
 - **Зөвлөмж өгөх**-Бодлого, удирдлагын чанар, үр нөлөө, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах, хэмнэлттэй, үр ашигтай үйл ажиллагааг дэмжих зорилгоор мэргэжлийн зөвлөмж өгнө.
- **21 дүгээр зүйл. Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох**
 - **Албан шаардлага өгөх**-Илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор шалгагдагч байгууллагад заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавина.
 - **Төлбөрийн акт тогтоох**-Төрийн аудитын байгууллага нь шалгагдагч байгууллага, албан тушаалтны хууль бус, үндэслэлгүй, үр ашиггүй үйлдэл, шийдвэрийн улмаас учруулсан санхүүгийн хохирлыг тогтоон төлбөрийн акт гаргах эрхтэй. Төлбөрийн акт нь хууль зөрчсөн санхүүгийн гүйлгээ, буруутай үйл ажиллагааг засаж залруулах, нийтийн өмчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үндсэн механизм юм.

- **35 дугаар зүйл. Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах**-Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудитор хариу мэдэгдэнэ.

Хуулиар тодорхойлсон дээрх зохицуулалт нь төрийн аудитын байгууллага илрүүлсэн алдаа, зөрчлийг засаж залруулах, нийтийн өмчийн хамгаалалт, төсвийн сахилга, бодлогын хэрэгжилтийн тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн үндэс болдог.

Төрийн аудитын байгууллага нь аудитын дүн, дүгнэлтийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, холбогдох асуудлыг хянан шийдвэрлүүлэх хуулийн үүрэгтэй бөгөөд энэхүү тайлагнал нь төрийн санхүүгийн хариуцлага, ажил үйлчилгээнд тавих парламентын хяналтын үндсэн механизм болдог.

Хариуцлага: Төрийн аудитын байгууллага нь аудитын үйл ажиллагааг хараат бус, бие даасан зарчмаар хэрэгжүүлж, дүгнэлт, илрүүлэлтээ нотолгоонд суурилсан, бодитой байлгах, аудитын шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, хууль зөрчсөн үйлдэлд зохих арга хэмжээ авах зэрэг хуулиар тогтоосон хариуцлагыг хүлээлгэдэг.

АДБОУБ-ын батлан гаргасан Лимагийн тунхаглал, Мексикийн тунхаглал нь төрийн аудитын хараат бус байдлын олон улсын суурь зарчим юм. Үндэсний аудитын газар эдгээр зарчмууд болон АДБОУБ-ын мэргэжлийн стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд гишүүн орны хувьд ил тод байдал, хариуцлагатай, стандартад суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд улс орнуудын аудитын байгууллагууд ижил түвшний хэмжээнд олон улсын өмнө хариуцлага хүлээдэг бөгөөд Үндэсний аудитын газар энэхүү үүргийн хүрээнд төрийн бодлого, хөтөлбөрийн ТХЗ-тай уялдаа, үр нөлөө, хэрэгжилтийн ахиц дэвшлийг үнэлэх хяналт-шинжилгээг хэрэгжүүлж байна.

Мөн 2025 онд зохион байгуулагдсан АДБОУБ-ын XXV Их хурлаас баталсан "Шарм эль Шейхийн тунхаглал" нь улс, орнуудын төрийн аудитын байгууллагуудын ил тод байдал, нийгмийн хариуцлага, ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг өргөжүүлж, аудитын дээд байгууллагуудын олон улсын өмнө хүлээх хариуцлагыг шинэ түвшинд тогтоосон байна.


Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, чиг үүрэг, хариуцлагыг хураангуйлан тусгасан нь олон улсын сайн туршлага болон АДБОУБ-ын мэргэжлийн стандартын шаардлагад нийцэж, төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, бүрэн эрх, хяналтын ач холбогдлыг уншигчдад хүргэх зорилготой юм.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг 595 байхаар шинэчлэн баталсан. Үүний дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр А/51 дүгээр тушаалаар баталсныг 2025 оны эхний хагас жил хүртэл мөрдсөн.




Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, 2024–2025 он



Төрийн аудитын байгууллагын хууль, эрх зүйн орчин, Монгол Улсын Их Хурлын гишүүдээс бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар хэлсэн саналууд, албан хаагчдаас авсан судалгаа, тайлан, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын сайн туршлагыг үндэслэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн МУЕА-ын тушаалаар 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/63 дугаар тушаалаар батлав.

Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, 2025 он



Шинэчлэлийн гол зорилго нь Төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, хүний нөөц, үйл ажиллагааны зохион байгуулалтыг хууль, стратеги, олон улсын стандарттай уялдуулан оновчтой болгож, чадамжид суурилсан, үр ашигтай, ил тод, цахим орчинд тулгуурласан, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэхэд оршиж байна.

Төрийн аудитын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд Үндэсний аудитын газар нь аймаг, нийслэл дэх 22 Төрийн аудитын газрыг зохион байгуулалтын нэгдсэн бодлого, удирдлагаар ханган ажилладаг.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, удирдлага, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, бүтцийн шинэчлэлийг бодит ажил хэрэг болгох, хүний нөөц, дэмжих болон захиргааны чиг үүргийг аудитын үндсэн үйл ажиллагаатай уялдуулж баталгаажуулах замаар байгууллагын нэгдсэн удирдлага, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглүүлж ажиллав.


Гүйцэтгэлийн аудитын газар нь 2025 оны эхний хагас жилд "Гүйцэтгэлийн аудитын газар" гэсэн зохион байгуулалттайгаар ажиллаж байсан бол шинэчилсэн бүтцийн дагуу гүйцэтгэлийн аудитын чиглэлээр дагнан чиг үүргийг хэрэгжүүлэхээр, мөн Нийцлийн аудитын газрыг шинээр зохион байгуулав.

Төрийн аудитын байгууллагаас төрийн тусгай байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийх, төлөвлөгөөт бус аудитыг хийх, эдийн засаг, нийгэмд ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, төсвийн тооцоолол, гэрээ хэлцэлд урьдчилсан аудит хийх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр Тусгай чиг үүргийн аудитын газрыг шинээр байгуулав.

Мөн шинэчлэлийн хүрээнд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянах тогтолцоог боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралд эерэг нөлөөллийг бий болгох, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, аудитын чиг үүрэг бүхий нэгжид дэмжлэг үзүүлэх чиглэлээр Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрыг шинээр зохион байгууллаа.

Нийслэл дэх Төрийн аудитын газар 4 алба, 61 албан хаагчтай, 21 аймаг дахь Төрийн аудитын газар 321 албан хаагчтай байхаар тус тус зохион байгуулсан.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, 2025 он



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ, ХЭРЭГЖИЛТ



Удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт: Төрийн аудитын байгууллага 2025 оны үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 02 дугаар сард зохион байгуулж, өмнөх оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, тайлант хугацааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, 2025–2030 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэв.

Зөвлөгөөний хүрээнд стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн бодлого, аудитын чанар, гүйцэтгэл, нийцлийн аудитын чадавх, "Аудитын дээд байгууллагын чанарын удирдлага-АДБОУС 140" стандартыг нэвтрүүлэх, АНТАГ-ын сайн туршлага зэрэг чухал ач холбогдолтой асуудлуудыг хэлэлцсэн нь 2025 оны үйл ажиллагааны нэгдмэл удирдлагаар хангах суурь болж өгсөн.

Төрийн аудитын байгууллагын 2025 оны стратеги, бодлогын чиглэл, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүрээнд дараах асуудлыг зөвлөгөөний үр дүнд толилуулсан байна.

- Оны зорилт болох чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлж хэрэгжүүлэхэд анхаарах;
- Гүйцэтгэл, нийцлийн аудитын чадавхыг бэхжүүлэх;
- Аудитын тайланг стандартад нийцүүлэх;
- 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв, нэгдсэн удирдамжтай аудитыг гүйцэтгэхэд анхаарах асуудал;
- Чанарын удирдлагын тогтолцооны өнөөгийн байдал, "АДБОУС 140" стандартыг нэвтрүүлж, төлөвшүүлэх;
- АНТАГ-ын сайн туршлага, үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл, бэрхшээл.

Стратегийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилт:

Төрийн аудитын байгууллагын 2025 оны зорилтыг "Чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх" хэмээн тодорхойлж 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан.

Ажлын хэсэг төлөвлөгөө боловсруулан ажилласан бөгөөд хүний нөөцийн чадамжийг сайжруулахад бодлого, зохион байгуулалтын урт хугацааны тогтвортой тогтолцоо, нэмэлт дэмжлэг шаардагдаж, төлөвлөсөн зарим арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, аудитын чанарын удирдлага, дижитал шилжилт, ил тод байдлын зорилтот арга хэмжээтэй уялдуулан үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.



Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд удирдлага, зохион байгуулалт, аудитын чанар, дижитал шилжилт, ил тод байдал, оролцоог бэхжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэв. Үүнд:

- "Төрийн аудитын байгууллагын 2025–2030 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө"-г 2025 оны 1 дүгээр сард баталж, 12 дугаар сард А/176 дугаар тушаалаар тодотгол хийж, уг стратегийг шинэчлэлийг баталж, дунд хугацаанд баримтлах зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бодит нөхцөлтэй уялдуулав;
- Төрийн аудитын байгууллагын стратегийн шинэчлэлийн хүрээнд аудитын үйл ажиллагааг төрийн бодлого, хэрэгжилтийг амжилтад хүргэхэд идэвхтэй оролцогч, гол төлөөлөгчийн үүрэгтэй байхаар зорилтыг тодорхойлж, стратегид нэмэлт чиглэлүүдийг тусгалаа. Үүнд аудитын чанарын удирдлагын хүрээнд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах замаар зөвхөн одоогоор тооцож буй санхүүгийн болон үйл ажиллагааны үр өгөөжөөр хязгаарлахгүй, харин "аудитын нөлөөлөл"-ийг бодитой нэмэгдүүлэх шалгуураар үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлэх шинэ хандлагыг төлөвшүүлэхийг зорьсон;
- Шалгагдагч байгууллага болон хамрагдагч талуудын эрсдэлийг хянах, удирдах, түүнчлэн инновац, шинэ шийдлээр аудитын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийг дунд хугацаанд бодлогын түвшинд шийдвэрлэх боломж, гарцыг тодорхойлох замаар төрийн аудитын үнэ цэнэ, бодит нөлөөллийг нэмэгдүүлэх стратегийн шинэчлэлийг хэрэгжүүлэхээр тусгасан;
- МУЕА-ын 2025 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар "Гүйцэтгэлийн аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ" батлагдаж, аудитын хүний нөөцийн чадавхыг бодлогын түвшинд тодорхойлов;

- Аудитын шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 2025 онд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, холбогдох журам, зааврыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж "Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам", "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах тогтолцоог төлөвшүүлэхэд ашиглах заавар"-ыг тус тус батлан мөрдүүллээ;
- "Аудитын дээд байгууллагын чанарын удирдлага-АДБОУС 140" стандартыг МУЕА-ын 2025 оны А/50 дугаар тушаалаар баталж, уг стандартыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагын үнэлгээний удирдамжийг боловсруулсан бөгөөд А/148 дугаар тушаалаар "Чанарын удирдлагын бодлого", "Чанарын зорилгыг 2026–2030 онд хэрэгжүүлэх чанарын зорилтын арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийн бэлтгэлийг хангав;
- Дижитал шилжилт, мэдээллийн технологийн засаглалыг бэхжүүлэх чиглэлээр 2025 оны 10 дугаар сард Төрийн аудитын байгууллагын Мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийг (2026–2030) баталж, мэдээллийн технологийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор "Мэдээллийн технологийн удирдах хороо" болон "Мэдээлэл, технологийн хэрэглэгчийн хороо"-г тус тус байгуулан, ажлыг эхлүүлээд байна;
- Стратегийн хэрэгжилт, ил тод байдлыг хангах гол баримт бичиг болох "Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцоог хангах бодлогын баримт бичиг (2026–2030)"-ийг 2025 оны 12 дугаар сард А/177 дугаар тушаалаар шинэчлэн баталж, оролцоонд суурилсан аудитын тогтолцоог төлөвшүүлэх эрх зүйн суурь үндсийг бүрдүүллээ.



Ил тод байдал, олон нийтийн оролцоо: 2025 онд хийж гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн аудитын жилийн төлөвлөгөөг батлан тушаалыг тус тус audit.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн. 2025 онд аудитын сэдвийн саналыг topic.audit.mn болон E-Mongolia системээр хүлээн авч, төрийн хяналтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж ажиллав.

"Төрийн аудитын байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний хүрээнд Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

2025 онд санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд төрийн бодлогын хэрэгжилт, үр нөлөө, санхүүгийн сахилга батад хяналт тавих чиглэлээр дүн шинжилгээ, үнэлгээг гүнзгийрүүлж, УИХ болон салбар тэргүүлсэн төрийн байгууллагуудад аудитын дүгнэлт, зөвлөмжийг танилцууллаа.

Аудитын бодлого, төлөвлөлт, арга зүйн дэмжлэг: "Төрийн аудитын байгууллагын 2025–2030 оны стратеги төлөвлөгөө"-ний дагуу бодлого, төлөвлөлт, аудитын арга зүйн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын чанарыг сайжруулахад анхааран нийт албан хаагчдад сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн аудитын бодлого, стандарт, заавар аргачлалыг шинэчлэн мөрдүүлэх, аудитын сэдэв сонголт, нөөцийн хуваарилалтыг эрсдэлд суурилсан байдлаар сайжруулах, олон улсын чиг хандлагад нийцсэн арга зүйн дэмжлэгийг аудитын нэгжүүдэд үзүүлэх ажлыг төвлөрүүлэн зохион байгуулсан байна. Тухайлбал, "Төрийн аудитын байгууллагаас 2025–2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудит, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийг боловсруулж, 2025 оны 10 дугаар сард батлан мөрдүүлсэн нь аудитын төлөвлөлт, хэрэгжилтийг бодлогын түвшинд нэгтгэх чухал алхам болов.

Санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийг боловсруулахдаа сүүлийн 5 жилийн статистик мэдээлэл, хэвлэл мэдээллийн 49 мэдээ, мэдээлэлд хийсэн шинжилгээ, төсвийн ерөнхийлөн захирагчдын 2022–2025 оны төсөв, гүйцэтгэлийн өгөгдөлд тулгуурласан дүн шинжилгээг ашигласан.

Power BI программ ашиглан төсвийн гүйцэтгэл, зардлын бүтэц, эрсдэлийг тодорхойлон харуулсан цахим самбар бэлтгэж, аудитын төлөвлөлт, ерөнхий чиглэлд ашигласан нь өгөгдөлд суурилсан аудитын арга зүйг бодит хэрэгцээнд нийцүүлэх суурь болж байна.

Аудитын арга зүйн дэмжлэгийг бэхжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээнд суурилсан сургалтын хөтөлбөр, шалгалтын материал боловсруулах, аудитын хуулийн этгээдэд зориулсан арга зүйн сургалт зохион байгуулах, аудитын мөрөөр хяналт тавих тогтолцоог сайжруулах гарын авлагыг боловсруулах ажлуудыг хэрэгжүүлснээр аудитын үр нөлөө, бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чиглэж, стратегийн зорилтыг хангахад үзүүлсэн бодитой дэмжлэг болж чадсан.

Шинэ санаачилгад суурилсан бодлого, арга зүйн шинэчлэл: АДБОУБ-ын XXV чуулганы хүрээнд хэлэлцэгдсэн "Хосолсон аудит" буюу мэргэжлийн дүгнэлт болон технологид (өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан) суурилсан шинжилгээг хослуулах хандлагыг судалж, бодлогын түвшинд дасан зохицуулах зорилтыг тавин ажиллаж байна.

Энэ хүрээнд рICTure хөтөлбөр, АДБОУБ-ын Их өгөгдөл (WGBD), Шинжлэх ухаан, технологийн аудит (WGISTA) зэрэг ажлын хэсгүүдэд оролцож, технологид суурилсан аудитын олон улсын чиг хандлагыг Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын арга зүйд нэвтрүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээрх бодлогын суурийг бэхжүүллээ.

Дэлхийн банк болон холбогдох бусад олон улсын байгууллагаас 2025–2026 оны дэлхийн эдийн засгийн төлөв байдлын хүлээлт, таамаглал, Монгол Улсын 2025 оны хагас жилийн макро эдийн засгийн үзүүлэлт, Засгийн газрын санхүү, төсвийн үйл ажиллагаанд өрнөсөн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ерөнхий чиглэлд тусгасан байна.

Аудитын төлөвлөгөөний хэрэгжилт: Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх 42 сэдвийг баталснаас хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх 18, Төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх 24 сэдэв байсан бол Төсвийн байнгын хорооны 2025 оны 26 дугаар тогтоолоор 3 сэдэв хасагдаж 21 сэдвээр аудит гүйцэтгэсэн.



Хүснэгт 1. Төрийн аудитын байгууллагын 2025 оны аудитын төлөвлөгөөний хэрэгжилт

Аудитын сэдэв	Сэдвийн тоо	Үүнээс		
		Тайлан баталгаажиж, холбогдох байгууллагад хүргэгдсэн	Аудит гүйцэтгэх боломжгүй	2026 онд үргэлжлэн гүйцэтгэх
Хуулийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв	18	17	1	
Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв	21	19		2
Нийт	39	36	1	2

2025 онд 36 сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч буюу эрх бүхий албан тушаалтан, холбогдох байгууллага болон УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлж, 1 аудит гадаад томилолтын зардал төсвийн тодотголоор хасагдсаны улмаас гүйцэтгэх боломжгүй, 2 аудит төлөвлөсөн хугацааны дагуу 2026 онд үргэлжилж байна. (Тогтоолын хэрэгжилтийг 2 дугаар хавсралтад харуулав)

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/107 дугаар "Аудитын сэдэв батлах тухай" тушаалаар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх 25 аудитын сэдвийг баталсан. Үүнээс 2 аудитыг АНТАГ-ын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэж, 23 аудитыг АНТАГ-ын санаачилгаар орон нутагтаа хийж гүйцэтгэсэн. (Тушаалын хэрэгжилтийг 3 дугаар хавсралтад харуулав)

Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт: Төрийн аудитын байгууллага нь аудитын үр нөлөөг нэмэгдүүлэх, нийгэмд чиглэсэн үр өгөөжийг бий болгоход анхаарч, 15 зорилтын хүрээнд 144 арга хэмжээг тусган Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчилсэнтэй холбогдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэх шаардлага үүссэн тул А/82 дугаар тушаалаар 13 зорилт, 152 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг тодотгон баталсан.

Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 152 арга хэмжээний гүйцэтгэл 90.8 хувиар үнэлэгдэж, үндсэн чиг үүргийн хүрээнд хүлээсэн аудитын үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт дутуу, удаашралтай гэж үнэлэгдсэн арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, залгамж чанартайгаар үргэлжлүүлэн хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.

Хүснэгт 2. ТАБ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ (тоо, хувь)

Чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэл (дундаж хувь, тоо)			Үнэлгээ	
			Дундаж	100	80.0		50.0
Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	6	94	92.6	58	33	-	3
Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	4	25	79.6	11	5	8	1
Үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	3	33	94.3	27	4	2	-
Нийт	13	152	90.8	96	42	10	4

Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, төлөвлөлт, аудитын арга зүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний шинэчлэл нь аудитын төлөвлөлт, хэрэгжилтийг уламжлалт хандлагаас өгөгдөл, эрсдэл, нөлөөлөлд суурилсан түвшинд шилжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлэв. Үүний зэрэгцээ аудитын үр дүнг зөвхөн гүйцэтгэлээр бус "аудитын нөлөөлөл"-өөр үнэлэх стратегийн шинэ хандлагыг төлөвшүүлэх суурь нөхцөл бүрдсэн нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны чанар, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.


Энэхүү шинэ санаачилга, арга зүйн өөрчлөлт нь дараагийн тайлант жилүүдэд хэрэгжих бодлого, төлөвлөлт, аудитын үйл ажиллагааг залгамж чанартайгаар хөгжүүлэх үндсэн суурь болох юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН АУДИТЫН

2025 ОНЫ АУДИТЫН ДҮН

- Төрийн аудитын төрөл, хэлбэр, хамрах хүрээ
- Аудитын илрүүлэлтийн хураангуй
- Аудитын шийдвэр, түүний хэрэгжилт
- Аудитын үр өгөөж
- Аудитын дүн





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулна.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргана.



НИЙЦЛИЙН АУДИТ

Шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргана.

ТӨРИЙН АУДИТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХАМРАХ ХҮРЭЭ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудит нь байгууллагын санхүүгийн мэдээллийг холбогдох санхүүгийн тайлагнал, зохицуулалтын үзэл баримтлалд нийцүүлэн толилуулсан эсэхийг тогтооход чиглэнэ. Үүний тулд санхүүгийн мэдээллийг залилан, алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэсэн эсэхэд санал дүгнэлт гаргах боломжийг аудиторт олгох зорилгоор аудитын хангалттай ба зохистой нотлох зүйл олж бүрдүүлнэ.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудит нь төрийн бодлого, түүний дотор аливаа тогтолцоо, үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, зохион байгуулалт хэмнэлттэй, үр ашигтай ба үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэхэд дүгнэлт өгч, эдгээрийг сайжруулах боломж байгаа эсэхэд чиглэдэг.

Гүйцэтгэлийн аудит нь зохистой шалгуур үзүүлэлт болон уг шалгуураас гажсан тохиолдлыг шалтгаантай харьцуулж шалгахын зэрэгцээ бусад асуудалд дүн шинжилгээ хийнэ. Энэ нь аудитын үндсэн асуултад хариулт өгөх ба нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмж өгөхийг зорьдог.



НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудит нь шалгаж буй зүйл эрх бүхий этгээдийн тогтоосон шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхэд чиглэдэг. Нийцлийн аудитыг үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ, мэдээлэл шалгагдагч этгээдийн мөрдөх эрх бүхий этгээдийн хууль тогтоомжид материаллаг талаараа нийцсэн эсэхийг үнэлэх замаар хийнэ.

Эдгээр хууль тогтоомжид улсын секторын санхүүгийн удирдлага, төрийн албан хаагчдын ёс зүйг зохицуулсан ерөнхий зарчим, хууль эрх зүйн акт, төсвийн тогтоол бодлого, зөвшилцсөн хэм хэмжээ зэрэг багтана.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУРААНГУЙ

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын сэдэв батлах тухай" А/107 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн нийт 3,954 аудитыг гүйцэтгэж тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитад бүх шатны төсөв захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд бие даасан 3,677 дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн 94, нийцлийн 183 аудит тус тус гүйцэтгэсэн байна.


Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит, (Аудитын төрөл)



Гүйцэтгэл, нийцлийн 277 аудитыг хийж гүйцэтгэсэнээс хуульд заасны дагуу 127, бодлогоор 141, төлөвлөгөөт бус 9 аудитыг хийж, 9,045 байгууллага, хуулийн этгээдийг хамруулсан байна.

Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6,974 байгууллагын санхүүгийн тайланг хамруулан 3,677 санал дүгнэлт гаргаж, 3297 байгууллагад үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэжээ.

Дүрслэл 2. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, (Дүгнэлтийн төрөл)



Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаас гадна санхүүгийн тайлангийн аудитаар 3,676* байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 78.9 хувь буюу 2,899 өөрчлөлтгүй, 19.9 хувь буюу 732 хязгаарлалттай, 0.7 хувь буюу 24 сөрөг, 0.6 хувь буюу 21 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Өөрчлөлтгүй
Хязгаарлалттай
Татгалзсан
Сөрөг

* Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хамтатган тооцов.

Төрийн аудитын байгууллага нь аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийг дараах байдлаар авч үздэг. Үүнд:

- Аудитын явцад математик тооцоолол алдсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн, мэдээллийг тусгаагүй эсвэл буруу тусгаж илэрхийлсэнтэй холбоотой алдааг аудитын явцад залруулж байна.
- Зөрчлийн шинж байдлаас хамааран зөвлөмж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох, сахилгын шийтгэл ногдуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч байна.

Дүрслэл 1. Аудитын илрүүлэлт, (ангилал)




Залруулсан алдаа¹: Аудитын дүнд математик тооцоолол алдсан, НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн, мэдээллийг тусгаагүй, мөн буруу тусгаж илэрхийлсэн зэрэг нийт 10,979.8 тэрбум төгрөгийн алдааг илрүүлэн, илрүүлэлттэй холбоотойгоор шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд залруулга хийсэн байна². Аудитын явцад шалгагдсан этгээдийн санхүүгийн тайланд дундаж түвшнээс өндөр буюу 20 хувиас дээш хэмжээтэй алдаа нь нийтлэг бүртгэлийн мэдээллийг тусгахгүй орхигдуулсан, буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой байна.

¹ Санхүүгийн тайлан дахь ямар нэгэн дүн, тодруулгыг орхигдуулах, буруу тусган илэрхийлсэн алдаатай илэрхийллийг санхүүгийн тайланд зөв дүнгээр илэрхийлж, орхигдуулсан дүн, тодруулгыг буцаан оруулж залруулсан бол залруулсан алдаа гэж үздэг.

² Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэрэгжилт, тодруулгатай холбоотой үүсдэг. Үүнийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа гэж үздэг бол НББ-ийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг зөрчилд тооцож байна.

Дүрслэл 2. Залруулсан алдаа, (ангилал, тэрбум төгрөг)




Илэрсэн зөрчил: 2025 онд гүйцэтгэсэн аудитын дүнд нийт 20,277.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

<p>3,014 төлбөрийн акт тогтоож, 57.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцсон.</p>	<p>7,424 албан шаардлага хүргүүлж, 14,369.3 тэрбум төгрөгийн зөрчилд арга хэмжээ авсан.</p>
<p>11,998 зөвлөмж өгч, 5,357.0 тэрбум төгрөгийн зөрчил арилгах чиглэл өгсөн.</p>	<p>296 албан шаардлагаар хариуцлага тооцуулах санал гаргаж, 437.9 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>
	<p>51 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 55.8 тэрбум төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.</p>

Дүрслэл 3. Аудитын зөрчлийн дүн, (Аудитын төрөл, тэрбум төгрөг)

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 20,277.4 тэрбум төгрөг зөрчил илэрснээс 83.9% хувь буюу 17,019.5 тэрбум төгрөгийн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар, 8.5% хувь буюу 1,717.9 тэрбум төгрөгийн зөрчил гүйцэтгэлийн аудитаар, 7.6 хувь буюу 1,540.0 тэрбум төгрөгийн зөрчил нийцлийн аудитын дүнд илэрсэн байна.



АУДИТЫН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Аудитаар илрүүлсэн зөрчлийн хүрээнд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт нь барагдуулах болон хэрэгжүүлэх хугацаанаас шалтгаалан он дамжин үргэлжлэх онцлогтой. Тайлант оны статистик мэдээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй мэт харагдах ч бодит байдалд өмнөх оны хэрэгжээгүй үлдсэн албан шаардлагын 15.3 хувь, зөвлөмжийн 11.0 хувь, мөн тайлант онд тогтоосон төлбөрийн актын 34.4 хувь, албан шаардлагын 41.7 хувь, зөвлөмжийн 64.1 хувийн хэрэгжилтийг тооцох, үнэлэх хугацаа нь хараахан болоогүй байна. Иймд тайлант оны бодит хэрэгжилтийг үнэлэхийн тулд өмнөх оны хэрэгжилтийг зэрэгцүүлэн доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Аудитын шийдвэрийн хэрэгжилт (төрөл, тоо, хувь)

Зөрчлийн төрөл	Өмнөх он			Тайлант он		
	Үлдэгдэл	Хэрэгжилт	Хэрэгжилт	Илрүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилт
	/Тоо/	/Тоо/	ХУВЬ	/Тоо/	/Тоо/	ХУВЬ
Төлбөрийн акт	803	361	45.0%	3,014	2,645	87.8%
Албан шаардлага	2,423	1,829	75.5%	7,424	5,688	76.6%
Зөвлөмж	2,938	2,213	75.3%	11,998	8,880	74.0%
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	93	80	86.0%	296	242	81.8%

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөнгөн дүн, тэдгээрийн хэрэгжилтийн хувь хэмжээг өмнөх болон тайлант оны байдлаар харуулав.

Хүснэгт 4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн мөнгөн дүн (тэрбум төгрөг, хувиар)

Зөрчлийн төрөл	Өмнөх он			Тайлант он		
	Үлдэгдэл /тэрбум төгрөг/	Хэрэгжилт /тэрбум төгрөг/	Хэрэгжилт хувь	Илрүүлэлт /тэрбум төгрөг/	Хэрэгжилт /тэрбум төгрөг/	Хэрэгжилт хувь
	Төлбөрийн акт	318.6	29.3	9.2%	57.4	31.3
Албан шаардлага	33,738.5	3,640.6	10.8%	14,369.3	3,244.4	22.6%
Зөвлөмж	9,882.5	6,358.9	64.3%	5,357.0	1,426.7	26.6%
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	417.8	417.6	99.9%	437.9	382.8	87.4%

Өмнөх оноос хэрэгжээгүй үлдсэн шийдвэрийн хэрэгжилтийн хувьд 318.6 тэрбум төгрөгийн төлбөрийн актын 29.3 тэрбум төгрөг, 33,738.5 тэрбум төгрөгийн албан шаардлагын 3,640.6 тэрбум төгрөг, 9,882.5 тэрбум төгрөгийн зөвлөмжийн 6,358.9 тэрбум төгрөг, 417.8 тэрбум төгрөг сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын 417.6 тэрбум төгрөг тус, тус хэрэгжсэн байна.

Тайлант онд тогтоосон 57.4 тэрбум төгрөгийн төлбөрийн актын 31.3 тэрбум төгрөг, 14,369.3 тэрбум төгрөгийн албан шаардлагын 3,244.4 тэрбум төгрөг, 5,357.0 тэрбум төгрөг зөвлөмжийн 1,426.7 тэрбум төгрөг, 437.9 тэрбум төгрөгийн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын 382.8 тэрбум төгрөг тус, тус хэрэгжсэн байна.

Хүснэгт 5. Аудитын шийдвэр өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, (тоо, тэрбум төгрөг)

Он		Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
2023	Илрүүлэлт	2,737	242.2	6,734	6,328.4
	Хэрэгжилт	2,276	35.8	5,276	2,215.9
2024	Илрүүлэлт	2,418	76.3	6,389	33,319.7
	Хэрэгжилт	2,136	12.0	4,723	3,252.3
2025	Илрүүлэлт	3,014	57.4	7,424	14,369.3
	Хэрэгжилт	2,645	31.3	5,688	3,244.4

Төлбөрийн актын хэрэгжилт өнгөрсөн оноос нэмэгдэж, албан шаардлагын хэрэгжилт тооны хувьд өссөн ч санхүүгийн үр дүн нь дорвитой нэмэгдээгүй байгаа нь энэ чиглэлд удирдлагын дэмжлэг, хяналт хариуцлагын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Аудитын шийдвэр өмнөх оны мөн үетэй харьцуулснаар (Үргэлжлэл)

Он		Зөвлөмж	Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Тоо	Тоо	Тоо
2023	Илрүүлэлт	9,949	355	25
	Хэрэгжилт	8,301	262	0
2024	Илрүүлэлт	9,629	315	27
	Хэрэгжилт	7,245	257	0
2025	Илрүүлэлт	11,998	296	51
	Хэрэгжилт	8,880	242	1


Тайлант онд зөвлөмжийн хэрэгжилтийн тоо өссөн ч хэрэгжилтийн түвшин өмнөх оноос буурч, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилт өмнөх түвшинд байна.

Нөгөө талаас хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын тоо нэмэгдсэн боловч бүрэн шийдвэрлэсэн нь бага байгаа нь аудитын шийдвэрийн хэрэгжилтийн дараах хяналт, хариуцлагын механизмыг дээшлүүлэх, удирдлагын түвшинд анхаарч ажиллах, хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

- Төлбөрийн акт, албан шаардлага болон зөвлөмжүүд нь нийтлэгээр нягтлан бодох бүртгэл хөтлөлт, бүртгэл-тооцоо бодолт, худалдан авалт, төсвийн сахилга, дотоод хяналт, хууль дагаж мөрдөхгүй зөрчил давтагдан гарч байгаа нь байгууллагуудын санхүүгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоо тогтвортой бус байгааг харуулж байна.
- Зөвлөмжийн дийлэнх нь хууль хэрэгжүүлж ажиллах, худалдан авалт, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийн чанар зэрэг суурь процессуудад чиглэж байгаа нь төрийн байгууллагуудын удирдлагын чадавх, хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлагыг системтэйгээр сайжруулах шаардлагатайг илтгэнэ.

Төлбөрийн акт: 2025 онд төсөв, санхүү, НББ-ийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн шалгадагч этгээдийн үйл ажиллагаанд 57.4 тэрбум төгрөгийн 3,014 төлбөрийн акт тогтоосон байна.

2025 онд тогтоосон төлбөрийн актаас 31.3 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 29.3 тэрбум төгрөгийг барагдуулж нийт 60.6 тэрбум төгрөгийг барагдуулсан байна. Тайлант онд тогтоосон 3,014 төлбөрийн актын хэрэгжилт тоогоор 2,645 буюу биелэлт 87.8 хувь бол мөнгөн дүнгээр 31.3 тэрбум төгрөг буюу 54.5 хувиар хэрэгжжээ.




Тайлант оны эцэст нийт 803 төлбөрийн актын үлдэгдлийн 15.6 хувь буюу 125 төлбөрийн актын биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

Хүснэгт 7. Төлбөрийн актын тоо, дүн, (Зөрчлийн ангиллаар)

Зөрчлийн ангилал	Тоо	Дүн (тэрбум төгрөг)
Төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн	26	0.4
Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй	62	6.3
Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон	1195	2.9
Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй	283	22.7
Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн	320	3.9
Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан	210	1.2
Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан	70	0.4
Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн	848	19.6

Төлбөрийн актын мөнгөн дүн нь голчлон төсвийн болон өмчийн орлогын дутуу төвлөрүүлэлтээс шалтгаалсан бол зөрчлийн тоо нь цалин, бүртгэл, тооцооллын давтамжтай алдаанд төвлөрч буй нь дотоод хяналт, санхүүгийн сахилга батад системтэй сайжруулалт шаардлагатайг харуулж байна.

Албан шаардлага: 2025 онд алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд 14.4 их наяд төгрөгийн 7,424 албан шаардлага өгсөн байна.



Тайлант оны эцэст нийт хэрэгжээгүй 2,326 албан шаардлагын 35.0 хувь буюу 814 албан шаардлагын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Тайлант онд тогтоосон албан шаардлагын 40.0 хувийг хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй байлгах чиглэлээр өгчээ.

Хүснэгт 8. Албан шаардлагын тоо, дүн, (Зөрчлийн ангиллаар)

Зөрчлийн ангилал	Тоо	Дүн (тэрбум төгрөг)
Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй	690	589.6
Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй	259	103.7
Өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан	42	6.7
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн	238	183.2
Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн	163	550.0
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	652	24.6
Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	294	530.1
Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй	447	677.3
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь төлбөрийн акт тогтоох үндэслэл бүрдээгүй бол	369	134.3
Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол	258	5,844.0
Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал	4012	5,725.7

Албан шаардлагын дийлэнх нь санхүүгийн бүртгэл, тооллого, худалдан авалт, төсвийн сахилга баттай холбоотой алдаа зөрчил, зөвлөмж болон аудитын шийдвэрийн хэрэгжилтээс шалтгаалсан төрийн байгууллагуудын дотоод хяналт ба хариуцлагын тогтолцоо сул байгаатай холбоотой юм.

Иймд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах механизмыг эрх зүйн зохицуулалт, байгууллагын засаглал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй уялдуулан тогтолцооны түвшинд авч үзэх шаардлагатай гэж үзэн холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулан ажиллаж байна.

Зөвлөмж: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд 2025 онд нийт 11,998 зөвлөмж хүргүүлсний 74.0 хувь буюу 8,880, өмнөх оноос шилжиж ирсэн 2,938 зөвлөмжийн 75.3 хувь буюу 2,213 нь тус тус хэрэгжсэн байна. Тайлант онд тогтоосон зөвлөмжийн хэрэгжилт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 нэгж хувиар буурсан байна.

Тайлант оны эцэст нийт 3,843 зөвлөмжийн үлдэгдлийн 54.1 хувь буюу 2,080 зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй бол нийт зөвлөмжийн 40.5 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгчээ.

Хүснэгт 9. Зөвлөмжийн тоо, дүн, (Зөрчлийн ангиллаар)

Зөрчлийн ангилал	Тоо	Дүн (тэрбум төг)
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	308	72.2
Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой	653	490.8
Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	2,307	208.6
Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой	548	176.0
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	4,883	2,183.4
Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	2,223	316.2
Худалдан авалттай холбоотой	685	1,047.3
Зориулалт бус зарцуулалттай холбоотой	235	5.9
Бусад	156	856.6

Зөвлөмжийн ихэнх нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор өгсөн нь төрийн байгууллагуудын худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчих, дотоод хяналт ба НББ, тайлагналын алдаа, зөрчилд төвлөрч, төсвийн төлөвлөлт болон орлого бүрдүүлэлтийн чанар, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Илэрсэн нөхцөл байдлыг шалгагдагч байгууллагуудын удирдлагад дахин анхааруулж, ил тод байдлаар танилцуулж, хэрэгжилтийн хариуцлагыг тодорхой болгох, зөрчлийг бүрэн арилгах, шийдвэрийн хэрэгжилтийн механизмыг үр нөлөөтэй байдлаар сайжруулах шаардлагатайг нотолж байна.

Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасны дагуу 2025 онд 296 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсний 242 буюу 81.8 хувь, өмнөх онуудын үлдэгдэл 93 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын 86.0 хувь буюу 80 албан шаардлага тус тус хэрэгжсэн байна.

Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилт 81.8 хувьд хүрсэн нь дээрх хуульд заасан хариуцлагын механизмыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц байгааг харуулахын зэрэгцээ, шийдвэрийн биелэлтийг эрх бүхий албан тушаалтны түвшинд цаг хугацаанд нь хангах, зөрчил дахин гарахгүй байх тогтолцооны хяналт, хариуцлагын үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагыг давхар тодотгож байна.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал: Тайлант онд хууль хяналтын байгууллагад 51 асуудал, өмнөх онуудын үлдэгдэл 38 асуудал, нийт 89 асуудал хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Үүнээс өмнөх онд шилжүүлсэн 7, тайлант онд шинээр шилжүүлсэн 1 асуудлыг бүрэн шийдвэрлэж, өмнөх онд шилжүүлсэн 19, тайлант онд шинээр шилжүүлсэн 11 асуудлыг хууль хяналтын байгууллагаас хэрэгсэхгүй болгосон байна.

Хүснэгт 10. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал (тоогоор)

Зөрчлийн төрөл	Эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд шинээр шилжүүлсэн	Бүгд	Хэрэгжилт					
				Бүрэн шийдвэрлэгдсэн		Хянагдаж байгаа		Хэрэгсэхгүй болсон	
				Өмнөх оноос	Тайлант оноос	Өмнөх оноос	Тайлант оноос	Өмнөх оноос	Тайлант оноос
Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	38	51	89	7	1	12	39	19	11

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын хувьд шийдвэрлэлт харьцангуй бага буюу дээрх үзүүлэлтээс харвал дийлэнх нь хяналтад байна. Төрийн аудитын байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нөхцөл байдлын талаарх шийдвэрлэлт, тэдгээртэй холбоотой мэдээллийг гаргуулан авах, нөгөө талаас үндэслэл бүхий баримт, нотолгоо, мэдээллээр тэдгээрийг хангах зэргээр тодорхой хүрээ, хязгаарт хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирол: Төрийн аудитын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна" гэж заасан. Тайлант онд 1,432.5 сая төгрөгийн 33 төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэснээс 13 буюу 39.4 хувь, өмнөх оны үлдэгдэл 96 төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үлдэгдлээс 9 буюу 9.4 хувь нь тус тус хэрэгжсэн байна.

Хүснэгт 11. Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлын шийдвэрлэлт, зөрчлийн төрлөөр (сая төгрөг)

Зөрчлийн төрөл	Эхний үлдэгдэл		Хэрэгжилт		Тайлант хугацаанд нэмэгдсэн		Хэрэгжилт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүгд	96	2,512.6	9	72.4	33	1,432.5	13	222.6
Зөвлөмж	2	31.7	-	2.0	3	493.1		
Албан шаардлага	82	2,216.9	9	69.7	25	918.1	9	205.3
Төлбөрийн акт	10	117.5		0.7	5	21.3	4	17.3
ХХБ-д шилжүүлсэн асуудал	2	146.8	-	-	-	-	-	-


АУДИТЫН ҮР ӨГӨӨЖ

Аудитын үр өгөөж нь төрийн аудитын байгууллага төсвөөс авсан санхүүжилтийн нэг төгрөг тутамд хэдэн төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бий болгон улс, нийгэм, байгууллага, иргэдэд ашиг тус үзүүлснийг илэрхийлэх үр дүнгийн үзүүлэлт юм.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж, хийсэн залруулгын дүнд шалгагдагч байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгө, нөөцөө хэмнэсэн, үр ашгаа дээшлүүлсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг сайжруулсан бол аудитаас үр өгөөж бий болсон гэж үздэг.

Санхүүгийн үр өгөөж нь төлбөрийн акт, албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлснээр бий болсон үр өгөөж байх бөгөөд аудитаар илрүүлсэн зөрчил, өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн акт болон албан шаардлагын хэрэгжилт нь төсвийн хэмнэлт үүсгэх, нөхөн төлбөр ногдуулснаар төвлөрүүлэх орлогын нэмэгдэл бий болох зэрэг бодит санхүүгийн үр өгөөжийг бий болгосон нь аудитын тайланд тусгагдсанаар нотлогддог.

Тайлант хугацаанд аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хэрэгжилтийн үр дүнд улс, орон нутгийн төсөвт нийт 62.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Нийт төвлөрүүлсэн орлогын 42.3 тэрбум төгрөг нь төлбөрийн актын дүнд, 20.5 тэрбум төгрөг нь албан шаардлагыг хэрэгжүүлснээр төвлөрсөн байна.



Дүрслэл 4. Санхүүгийн үр өгөөжийн дүн, (он)



Санхүүгийн бус үр өгөөж: Төрийн аудитын үйл ажиллагаа нь зөвхөн зөрчил илрүүлэхээс гадна дотоод хяналт, төлөвлөлт, тайлагналын чанар, эрсдэлийн удирдлага, худалдан авалтын сахилга бат болон байгууллагын хариуцлагыг сайжруулахад эерэг нөлөөллийг бий болгодог.

Шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд гарсан чанарын ахиц дэвшил, сайжралаар илэрхийлэгдэх 967 санхүүгийн бус үр өгөөж (мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх боломжгүй гэж үзсэн)-ийг бий болгожээ.

Төрийн аудитын байгууллага 2026 оныг “Аудитын нөлөөллийг тооцох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлэх жил” болгон зарлаж, бодлогын хэрэгжилтийг хэмжих, тайлагнах шинэ хандлагыг хэрэгжүүлэхээр зорьж байгаа тул санхүүгийн бус үр өгөөжийг найдвартай, итгэл үнэмшилтэй тооцож, аудитын дүнд бий болсон илрүүлэлтийг давтан гаргуулахгүй байх, тухайлсан аудитын түвшинд тогтоосон алдаа зөрчил дахин давтагдахгүй байхад орших юм.

Бид аудитын үр дүнд бий болсон нийт үр өгөөжийг тооцохын тулд санхүүгийн бус үр өгөөжийг бодитой тооцож үнэлэх, аудитын нөлөөллийн дүнд тодорхой ахиц дэвшил гарч, эерэг үр нөлөө, сайжрал бий болсон эсэхийг дүгнэж тайлагнадаг.

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн аудитын дүнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, засаглалын чанар, төсөв санхүүгийн зарцуулалтын сахилга бат, бодлого-төсвийн уялдаа, нийгмийн үйлчилгээний чанар зэрэг олон талын чанарын ахиц дэвшил гарснаар Төрийн аудитын байгууллагын бодит нөлөөллийг илэрхийлэх юм.

Төрийн аудитын дүнд чанарын ахиц дэвшил нь зөвхөн мөнгөн дүнгээр хэмжигдэхгүй ч төрийн үйл ажиллагааны үр ашиг, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, нийгмийн үнэ цэнийг нэмэгдүүлэх юм.

Санхүүгийн тайлангийн аудитаар төрийн байгууллагуудын санхүүгийн удирдлага, дотоод хяналт, хууль, журам мөрдөлт, санхүүгийн тайлагналын үнэн



зөв байдалд суурь түвшний чанарын ахиц гарч байсныг санхүүгийн бус үр өгөөж гэж үзсэн. Үүнд:

- Дотоод хяналтын тогтолцоо сайжирсан. Бүртгэл, тайлан, хөрөнгийн хадгалалт, авлага-өглөгийн хяналт сайжирч, зарим байгууллагууд санхүүгийн мэдээллээ үнэн зөв, найдвартай илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлсэн;
- Хууль, журам мөрдөлт нэмэгдсэн. Цалин, урамшуулал, худалдан авалт, гэрээ хэлцэл, төсвийн зарцуулалт хуульд нийцэж, давтан зөрчил багассан;
- Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал дээшилсэн. Орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөр, авлага-өглөгийн бүртгэл бодит дүнтэй нийцэж, байгууллагын удирдлагын шийдвэр гаргалт илүү нотолгоонд суурилдаг болсон;
- Үйл ажиллагааны үр ашиг, хэмнэлт бий болсон. Илүү олгосон цалин, урамшуулал, томилолтын зардлыг бууруулж, шаардлагагүй зардлыг таслан зогсоосноор төсвийн хэмнэлт бодитоор бий болсон;
- Ил тод байдал нэмэгдсэн. Шилэн дансны мэдээлэл, худалдан авалтын бүртгэл, тайлагналын чанар сайжирч, иргэд болон хэрэглэгчдэд хүрэх мэдээллийн ил тод байдал дээшилсэн;
- Эрсдэл буурсан. Найдваргүй авлага үүсэх, хөрөнгө үрэгдэх, хууль зөрчих, давтан зөрчил гарах эрсдэл багасаж, байгууллагын санхүү-үйл ажиллагааны тогтвортой байдал дээшилсэн;
- Байгууллагын засаглал, хариуцлага сайжирсан. Урамшуулал, шийдвэр гаргалт ил тод болж, дотоод хяналт бэхэжсэний үр дүнд байгууллагын соёл, сахилга, хариуцлага сайжирч байна.

Эдгээр ахиц дэвшил нь төрийн байгууллагуудын тогтвортой, үр ашигтай, хариуцлагатай үйл ажиллагааг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд аудитын байгууллагын нөлөөллийн үр дүнг нэмэгдүүлнэ.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж хэрэгжсэнээр зөрчил дутагдал дахин гарахгүй буурах, эрсдэлийг урьдчилан тооцож, таслан зогсоох, төсвийн хөрөнгийн үр ашиг, ил тод байдал нэмэгдэж, байгууллагын хариуцлага, санхүүгийн сахилга бат дээшилж, үнэлэгдэх боломжтой бөгөөд төрийн байгууллагын тогтвортой, хариуцлагатай, үр дүнд суурилсан менежментийн суурийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Аудитын дүнгээр "илрүүлэлт" буурахгүй байгаа ч 2025 онд гүйцэтгэсэн аудитын дүн, дүгнэлтээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн дүнд төрийн байгууллагуудын бодлого, төсвийн уялдаа, төлөвлөлтийн чанар, үйлчилгээний хүртээмж, хяналт-шинжилгээ, дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн сахилга, тайлагналын үнэн зөв байдал зэрэг суурь үзүүлэлт сайжирсан байна.

Гүйцэтгэлийн аудитын хүрээнд төсвийн бодлого, хөрөнгө оруулалт, үйлчилгээний чанар, засаглалын ил тод байдал дээшилж, санхүүгийн тайлангийн аудитын үр дүнд санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, хууль, журмын мөрдөлт, хяналтын тогтолцоо, арвилан хэмнэлт, хариуцлага сайжирсан байна.

АУДИТЫН ДҮН

ҮАГ-ын аудитын чиг үүрэг бүхий нэгж болох Санхүүгийн аудитын газар (САГ), Нийцлийн аудитын газар (НАГ), Тусгай чиг үүргийн аудитын газар (ТЧҮАГ), Гүйцэтгэлийн аудитын газар (ГАГ)-ын аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын 2025 онд гүйцэтгэсэн аудитын үр дүнг сэдэв бүрээр хураангуйлан тайлагнаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтын дагуу Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, аудитын тайланг УИХ, Засгийн газарт хүргүүлсэн.



Аудитаар нийт 10,845.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,806.4 тэрбум төгрөгийн 8 алдааг залруулж, 13.1 тэрбум төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5,406.6 тэрбум төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, орон нутгийн 1 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд "Сөрөг" дүгнэлт авсан тул хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 618.9 тэрбум төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 726.1 тэрбум төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 9 зөрчлийг давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өгч, 13.1 тэрбум төгрөгийн 2 санхүүгийн үр өгөөжийг тооцсон байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 1 асуудал толилуулж, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах 12 зөвлөмж өгснөөс Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн болон Сангийн сайдад тус тус 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулсан нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангахад чиглэсэн өөрчлөлт сайжруулалт хийхийг уламжилсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөсөн нь:

Төсвийн сахилга, хөрөнгө оруулалтын удирдлага болон аудитын дүгнэлт, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг жил дамжуулан барьцаа дансанд байршуулах шийдвэрийн зохистой байдлыг нягтлан судалж, аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг үнэлж, хангалтгүй хэрэгжилттэй захирагчдад хариуцлага тооцох зайлшгүй шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх шаардлага тулгамдаж байгаа бөгөөд санхүүгийн тайланг эзэмшлийн бүтэц, салбар чиглэлд тохируулан зөв нэгтгэх, хувьцааг олон нийтэд нээлттэй арилжих замаар компанийн ил тод байдал, үр ашиг, хяналтыг нэмэгдүүлэх нь чухал байна.

Төрийн байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэхийн тулд дотоод аудитын эрх зүйн орчныг сайжруулж, түүний үр нөлөөг дээшлүүлэн, аудитаар илэрч буй алдаа, зөрчлийг бууруулахад чиглэсэн бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь байгууллагуудын санхүүгийн сахилга, удирдлагын чанарт эерэг хөшүүрэг болно.

Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайд нарт зөвлөсөн нь:

Олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон болон олон улсын байгууллагуудаас санхүүжиг төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, хэлэлцээрийн шатанд эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд илүү онцгойлон анхаарах шаардлагатай байна. Мөн экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэл, эрчим хүчний нийлүүлэлтийг сайжруулах бодлогын хүрээнд гадаад зээлийн оновчтой ашиглалтыг өргөжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн дэлхийн зах зээл дэх металлын үнэ, цэвэршүүлэх өртгийн өөрчлөлтийг харгалзан "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэр"-ийн техник, эдийн засгийн үндэслэлд нэмэлт тооцоо хийх шаардлага тулгарч байна.

Гадаад зээлийн хэлэлцээрүүдийг улсын төсвийн шингээх чадвар, төсөл хэрэгжилтийн хуваарь, хөрөнгийн үр ашигтай нягт уялдуулан боловсруулж, ашиглагдаагүй эх үүсвэрээс үүсэх зардлыг бууруулах, санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд анхаарч ажиллах нь зөв гэж үзэж байна.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагын ангиллыг үнэн зөв тогтоож нэгтгэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг бүрэн хамруулах нь санхүүгийн мэдээллийн ил тод, найдвартай байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд энэ чиглэлд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Мөн гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн дамжуулан зээлийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчидтай тооцоо нийлж нягтлан баталгаажуулах, авлагын барагдуулалтыг шуурхай зохион байгуулах нь санхүүгийн сахилга бат, төсвийн тогтвортой байдлыг дэмжихэд нэн шаардлагатай тул энэ асуудалд онцгойлон анхаарч ажиллах нь зүйтэй байна.



МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтын дагуу Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, УИХ, Засгийн газарт хүргүүлэв. Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн нийт орлого ба тусламж 29,670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж, 274.1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 29 зөвлөмж өгч, 117.1 тэрбум төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулга хийлгэлээ.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 2 асуудал толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 11, Монгол улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 11, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад 1, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 1, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад 2, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргад 1, нийтлэг асуудлаар ТЕЗ нарт зөвлөмж, нийт 29 зөвлөмж тус тус хүргүүлж, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөв. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулсан нь:

Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан ч төсвийн хүрээний мэдэгдэлд давтан өөрчлөлт оруулж буй нь төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдахад хүргэж байгаад анхаарах, мөн төсөвт шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусган батлах зөрчил давтагдаж байгаа тул төсвийн төслийг санал болгох, өргөн барих, батлах үе шатанд хариуцлагын зохицуулалтыг сайжруулах шаардлага хэвээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өмнөх жилүүдэд Улсын Их Хурал, Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байгаа бөгөөд хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд төлөвлөхгүй орхигдуулж ирсэн тогтолцооны алдааг зассан бодит шийдвэр гаргах шаардлагатайг тэмдэглэсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөсөн нь:

Төсвийн бодлогын хэрэгжилтийг урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдтэй уялдуулж үнэлэх, төсвийн тайлагнал ба хариуцлагын системийг сайжруулах нь чухал бөгөөд нэгдсэн төсөв, төсвийн хүрээний мэдэгдлийн давтамжтай өөрчлөлтөөс үүдэлтэй тогтвортой байдлын алдагдлыг бууруулах шаардлагатай байна. Төсөвт шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж батлах зөрчил давтагдаж буй тул төсвийн төсөл боловсруулах, өргөн барих, батлах шат бүрд хариуцлагын зохицуулалтыг бэхжүүлэх;

Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилт, хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг дунд хугацаанд нарийвчлан тодорхойлох, төсвийн өртөг, зориулалт, хамрах хүрээ зэргийг ил тод зааглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх шилжүүлэлтийн шалгуурыг тодорхойлох шаардлагатай. Хяналт-шинжилгээ, гүйцэтгэлийн дүгнэлтийг үе шаттай хийж тогтолцооны алдааг арилгаж, хөрөнгө оруулалтын үр ашиг, хариуцлагыг дээшлүүлэх;

Үндэсний баялгийн сан болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бодлогын түвшинд нэмэгдүүлэхийн тулд стратегийн ордуудаас төр эзэмших хувьцааны загвар, нөөц ашигласны төлбөрөөр орлуулах боломжийг судалж хэрэгжүүлэх, корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагын мандатыг боловсруулж сангийн хөрөнгийг эрсдэлийн удирдлагатай уялдуулан өсгөх шаардлагатай. Мөн төсвийн бодлогыг тогтвортой өсөлт рүү чиглүүлж, урсгал зардлыг хязгаарлан сонгуулийн мөчлөгөөс үл хамаарах хариуцлагатай төсөвлөлтийг хэрэгжүүлэх;

Засгийн газрын байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж үр ашгийг дээшлүүлэх, төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газруудад цалингийн ангилал, шатлалыг нэг мөр мөрдүүлэх замаар санхүүгийн сахилга батыг сайжруулах шаардлагатай. Түүнчлэн татаас, хөнгөлөлтийн үр нөлөөг үнэлж шат дараатай бууруулах, олон жил дамнасан авлага, эргэн төлөлтгүй зээл, хохирлын асуудлыг шийдвэрлэн барагдуулах, Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын сангийн эрх зүйн орчныг шинэчилж сангуудын тогтвортой үйл ажиллагааг хангах бодлогын шинэчлэл хийх асуудлыг тус тус хөндсөн байна.

Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайд нарт зөвлөсөн нь:

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс эрдэс баялгийн үнийн богино хугацааны хэлбэлзлээс хэт хамааралтай орлогын өсөлтөөс зайлсхийж, олон тулгуурт бүтэц бүхий эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх бодлогыг урт, дунд хугацааны төсвийн баримт бичгүүдэд тодорхой тусган хэрэгжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгасан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж тайлагнах замаар төсвийн удирдлага болон бодлогын хэрэгжилтийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Төсвийн бодлогын хэрэгжилтийг сайжруулахын тулд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөх, тэдгээрийг гүйцэтгэлтэй уялдуулан тайлагнах нь төсвийн үр ашиг, хариуцлагыг дээшлүүлэх үндэс болно.

Төсвийн хязгаарын хүрээнд төлөвлөлт хийгдсэн эсэхийг хянаж, төсөв захирагчдын санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулах, зардлын ангиллыг нарийвчлан тодорхой болгож, зарцуулалтын ил тод байдлыг хангах нь чухал байна. Үүнтэй зэрэгцэн татварын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулж, уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалтыг татах замаар эрдэс баялгийн мөчлөг дагасан орлогын хамаарлыг бууруулах бодлого баримтлах шаардлагатай.

Төсвийн төслийн санал боловсруулах, хянах, батлах үйл явцад төсвийн ерөнхийлөн захирагчидтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хуульд хамааралгүй байгууллагын зардлыг тодорхойгүй байршуулахгүй байх, орон нутгийн сан, дансны ангиллыг нэгдсэн бодлогоор журамлах асуудал чухал байна.



МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбоотойгоор Засгийн газрын шинэчилсэн бүтэц, бүрэлдэхүүнд нийцүүлсэн байдлаар Засгийн газар нь 16 яам, Ерөнхий сайд болон 19 сайдтай байхаар төсвийн тодотголыг өргөн мэдүүлж 8.4 тэрбум төгрөг, хуулиар тусгайлан байгуулаагүй 7 хороо, 3 зөвлөл, тэдгээрийн ажлын албыг татан буулгаж 11.2 тэрбум төгрөг, нийт 19.6 тэрбум төгрөгийн зардлыг бууруулжээ.

Гэвч УИХ-аас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны албан хаагчдын тоог 9 хувь бууруулахаар заасныг Төсвийн тодотголд хэрэгжүүлж эхлэхээр тооцсон нь чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийгээгүй, түүнд үндэслэсэн цогц төлөвлөгөөгүйгээр механик аргаар бүх ТЭЗ нарын орон тоог жигд бууруулж байгаа нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах эрсдэлийг бий болгож байгааг тэмдэглэсэн.

Засгийн газрын шинэ бүтэцэд нийцүүлэн тодорхой зардлыг бууруулсан боловч төрийн албан хаагчдын тоог механикаар бууруулах арга хэмжээний хувьд чиг үүргийн давхардал, ажлын ачааллын үнэлгээ, төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийгдээгүй, нөгөө талаас төрийн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй бөгөөд ингэснээр ажлаас шалтгаангүй чөлөөлөгдөх ажилтнуудад олгох нэг удаагийн тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын тэтгэмжийн зардал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байгааг анхааруулсан.

Аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг, санхүүжилтэд орох өөрчлөлтөд өгөх дэд дүгнэлтийг боловсруулсан. Тодотговол:³

- 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар тухайн төсөл, арга хэмжээний үндсэн барилгын ажлын даалгавар, зураг төсөл болон төсвийг бүрэн боловсруулж батлуулаагүй байгаа бөгөөд 2025 онд буюу сүүлийн хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нь хугацаандаа хэрэгжихгүй байх, төлөвлөсөн 41.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тухайн онд бүрэн ашиглах чадахгүйд хүрэх эрсдэлтэй гэж үзсэн.
- Дулааны III цахилгаан станцын өргөтгөл хэсгийн дээвэр болон байрны засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээнд 7.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй байжээ.
- Дүгнэлтэд дурдсан барилга байгууламж, их засварын 2 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг, зураг төсөл магадлалаар баталгаажаагүй нь төсөвлөлтийн шаардлагад нийцэхгүй, холбогдох байгууллагуудаар хянуулж баталгаажуулсны дараа төсөвт өртөг өөрчлөгдөж болзошгүй гэж дүгнэсэн байна.




³ УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын хүрээнд гаргасан дүгнэлтээс ...

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Улсын төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, үр ашиг дээшлүүлэх чиглэлээр нийт 415 санал гаргаснаас 253 саналыг хэрэгжүүлж, 581.2 тэрбум төгрөгийн санхүүгийн үр нөлөө бодитоор бий болгосон нь аудитын зөвлөмж хэрэгжилтийн шатанд бодит үр дүн өгсөн.

Дүгнэлт өгөхдөө Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр бодлогын баримт бичгүүдтэй агуулгын хувьд нийцэж байгаа боловч улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх чиглэл, санхүүгийн тогтвортой бодлогын зарчимд давхар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байгааг анхааруулсан байна.



- Монгол Улсын Их Хуралд улсын нэгдсэн төсвийн төслийг жил бүр хэлэлцэхдээ төсвийн хүрээний мэдэгдлийг давтан өөрчлөх явдлыг хязгаарлаж, дунд хугацааны төлөвлөлтийн үр нөлөөг алдагдуулахгүй байх чиглэлийг Засгийн газарт өгөхөөс гадна төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлж буй хууль, тогтоолын төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн нийтлэг болон тусгай шаардлагыг бүрэн хангасан байх зарчмыг хатуу мөрдүүлж байхыг уламжилсан.
- Монгол Улсын Засгийн газарт төсвийн тогтвортой байдлын зарчмыг баримтлан төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдсан төсвийн төслийг өргөн мэдүүлэх, эрдэс баялгийн үнэ буурах эрсдэлд бэлэн байхын тулд орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн санг бүрдүүлж төсөвт байршуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн тэвчиж болох зардлыг хасаж, бүх шатны төсөв захирагчдад төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэл өгөх зэрэг асуудлуудыг хөндсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 26 ТЭЗ-ийн төсвийн багцад 2026 онд шинээр хэрэгжих 149, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 430, нийт 9,631.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 579 төсөл, арга хэмжээг 3,267.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснийг хянаж дүгнэлт гаргасан. Тухайлбал:⁴

- Аудитаар улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний суурь судалгаа, санхүүжилтийн бүтэц, бодлогын уялдаа, төлөвлөлтийн аргачлал, мэдээллийн чанар, хяналт, үнэлгээний тогтолцоо зэрэгт системийн доголдол байгааг тогтоов. Хөрөнгө оруулалтын нийт санхүүжилтийн 77.9 хувь нь барилга, 16.9 хувь нь тоног төхөөрөмж, үлдсэн бага хувийг ТЭЗҮ, цахим системд хуваарилсан нь хөрөнгө оруулалтын бүтэц хөгжлийн оновчтой чиглэлд нийцэхгүй, урсгал зардлын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. 2026 онд 3.27 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн нь 2025 оноос өссөн ч төслийн тоо 2024 оноос 56 хувь, 2025 оноос 5.5 хувь буурсан нь шилжиж буй төслүүдийн хөрөнгө оруулалт дийлэнх нь байна. Шинэ төслүүдийн үр нөлөө, бэлэн байдлыг хангах төлөвлөлт сул байгааг тодотгон дүгнэв.
- Дунд хугацааны бодлогын үндсэн баримт бичгүүд (2026–2030) батлагдаагүй, боловсруулах шатанд байгаа тул хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлоготой уялдуулах боломжгүй, хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа хангагдаагүй байна. Санхүүжилтын эх үүсвэр нь "улсын төсөв" гэсэн ерөнхий нэршлээр тусгагдаж, урсгал ба хөрөнгийн зардлын ангилал, холимог эх үүсвэрийн ангилал тодорхойгүй нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт төсвийн хязгаарлалттай уялдахгүй, гүйцэтгэлийг шинжлэх боломжийг хязгаарласан.
- Шинээр хэрэгжүүлэх 71 барилгын төслийн урсгал зардлын ирээдүйн дарамтыг тооцох судалгаа хангалтгүй, ТЭЗ-дын оруулсан мэдээлэл хоорондоо зөрүүтэй, зарим төсөлд урсгал зардлын тооцоо огт байхгүй байсан нь төсвийн ачааллыг урьдчилан үнэлэх боломжийг боомилж байна. Шинэ 149 төслийн 50.3 хувьд (75 төсөл) санхүүжилтийг тэнцүү хуваарилаагүй нь төслийн хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж, хугацаа хэтрэх, хөрөнгө дутагдах шалтгаан болж байна.

⁴ УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын хүрээнд гаргасан дүгнэлтээс ...





- Сангийн яамны төсвийн удирдлагын PIMIS системд төсөл бүрийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулах ёстой ч зарим ТЭЗ бодлогын хамааралгүй заалт ашигласан, иж бүрнээр, бодитойгоор бус уялдаагүй бүртгэсэн нь хөрөнгө оруулалтын бодлогын үнэн зөв төлөвлөх зарчмыг алдагдуулсан байна гэж үзсэн. Тоног төхөөрөмж, зураг төсөв, ТЭЗУ ангиллын төслийн шалгуур, аргачлалыг нарийвчлан тодорхойлоогүй, жишиг үнэ, өртөг тооцох арга зүй дутмаг, хөрөнгийн мэдээллийн сан болон тоног төхөөрөмжийн стандартчилал, норм бүрдээгүй нь хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, тооцооны алдаа, хяналтгүй нөхцөл үүсгэж байна гэж дүгнэлээ.
- ТЭЗ-д салбарын хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай суурь судалгаа хангалтгүй, тоон мэдээлэл бодит бус, их өгөгдөлд тулгуурласан хэрэгцээг эрэмбэлэх тогтолцоо сул байгаа нь нэн тэргүүний шаардлага, бодит үр нөлөөтэй төслийг эрэмбэлэх боломжийг хязгаарлаж байна. Сангийн яам, БШУЯ-тай хамтран сургууль, цэцэрлэгийн барилгын хэрэгцээг их өгөгдлөөр үнэлэх ажлыг эхлүүлсэн нь эерэг боловч дорвитой шинэчлэл болж чадахгүй байна гэж дүгнэсэн.
- Өмнөх аудитын 6 зөвлөмжийн 5 нь хэрэгжих шатанд, 1 нь хангалтгүй хэрэгжсэн нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, удирдлагын аргачлалд хийх шаардлагатай шинэчлэл удаашралтай байгааг харуулж байна гэж дүгнэсэн.

Төсвийн шууд захирагч, төсөл хөтөлбөрийн нэгжийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит:

Төсвийн 351 шууд захирагчдын, төсөл хөтөлбөрийн 118 нэгжийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитад хамруулсан. Үүнээс 260 санхүүгийн тайланг аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 209 санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан.

Уг аудитын дүнд нийт 1,767.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 596.0 тэрбум төгрөгийн 512 алдааг залруулж, 2.8 тэрбум төгрөгийн зөрчилд 165 төлбөрийн акт тогтоож, 848.0 тэрбум төгрөгийн зөрчилд 596 албан шаардлага, 8.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 31 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 312.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 820 зөвлөмж өгч, 0.4 тэрбум төгрөгийн 6 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.



Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит: Төсвийн 22 төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, санал дүгнэлт гаргасан байна.

Аудитын дүнд нийт 468.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 48.2 тэрбум төгрөгийн 30 алдааг залруулж, 0.6 тэрбум төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 247.5 тэрбум төгрөгийн зөрчилд 75 албан шаардлага, хариуцлага тооцуулах 4 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 172.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 40 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит: Нийт төсвийн 36 ерөнхийлөн захирагчдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлсэн.

Нийт 4,172.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,652.2 тэрбум төгрөгийн 36 алдааг залруулж, 3.7 тэрбум төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 1,083.6 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 9.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 13 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 423.0 тэрбум төгрөгийн зөрчилд 131 зөвлөмж өгч, 0.5 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит: Төрийн өмчит 101 аж ахуйн нэгжийн 2024 оны санхүүгийн тайланг аудитад хамруулахаас 34 байгууллагын санхүүгийн тайланг аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 67 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өглөө.

Энэхүү аудитын хүрээнд нийт 3,191.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 823.6 тэрбум төгрөгийн 168 алдааг залруулж, 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 52 төлбөрийн акт тогтоож, 997.9 тэрбум төгрөгийн зөрчилд 310 албан шаардлага, 61.7 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 21 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 1,300.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 338 зөвлөмж өгч, 7.0 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

Засгийн газрын тусгай сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит: Засгийн газрын 24 тусгай сангийн санхүүгийн тайланг аудит хамруулахаас 15 байгууллагын санхүүгийн тайланг аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 9 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 2,426.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 86.6 тэрбум төгрөгийн 16 алдааг залруулж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 2,332.6 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 0.8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 4 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 6.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 17 зөвлөмж өгч, 0.1 тэрбум төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна.



УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 712, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 607, нийт 11,579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1319 төсөл, арга хэмжээг 3,828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 1319 төсөл, арга хэмжээнээс 56.1 хувь буюу 740 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар, 43.9 хувь буюу 579 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 2020–2022 онд 1,330.9–1,418.9 тэрбум төгрөг төлөвлөж байсан бол 2023 онд өмнөх оноос 92.7 хувиар өсөж 2,686.0 тэрбум, 2024 онд 42.5 хувиар өсөж 3,828.6 тэрбум төгрөгт хүрсэн.



Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хангалтгүй хэрэгжүүлснээс зөрчил давтагдан гарч, барилга байгууламжийн үе шатны хяналт, захиалагчийн хяналтын тогтолцоо, инженерийн шугам сүлжээний бүрэн төлөвлөлт, ТЭЗҮ-ийн шаардлага тогтоох, төсөл арга хэмжээний мэдээллийг цахим системд бүрэн байршуулах болон дотоод аудитын үр нөлөө, давтамж сул байна.

Түүнчлэн барилга ашиглалтад оруулах дүрмийн хэрэгжилтийг нэгдсэн арга зүйгээр хангах, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудад төсвийн хөрөнгөөр бий болсон байгууламж, тоног төхөөрөмжийг ил тод, өрсөлдөөнт зарчмаар ашиглуулахаар журам тогтоох, сургууль, цэцэрлэгийн ширээ, сандлын чанарын стандарт, худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулах зэрэг салбар хариуцсан сайд нарт хаягласан бодит ажлууд хэрэгжээгүй хэвээр байна. Тухайлбал:

- Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр хөрөнгө оруулалтын үр дүн тодорхой хэмжээнд

гарсан боловч төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын шатуудад нийтлэг доголдлууд давамгайл байгааг тогтоов. Тодруулбал, боловсрол, соёл, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг салбарт нийт 100 гаруй барилга байгууламж, 200 км авто зам ашиглалтад орсон ч харин санхүүжилтийн гүйцэтгэл 62.7 хувь, төслийн хэрэгжилт 69 хувь буюу хангалтгүй байна. Төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл явц оновчгүй, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл 74.4 хувь, төсөвлөлтийн шаардлага хангаагүй барилга 52.8 хувьд хүрсэн нь хөрөнгө санхүүгийн нөөцийг үр ашиггүй зарцуулах үндсэн шалтгаан болж байна;

- Хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, төсөвт өртгийн ялгаа, төслийн төрөл, ач холбогдол, эрэмбэлэх механизм тодорхойгүйгээс үүдэн төрийн санхүүжилт үр ашиггүй зарцуулагдах эрсдэл өндөр хэвээр байна. Барилга байгууламжийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал хууль, норм нормативтай нийцэхгүй байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулалтын эрэмбэ алдагдаж, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдвэр гаргалт хангагдаагүй;
- Захиалагчийн хяналт сул, худалдан авах ажиллагааны гомдлын шийдвэрийн дагаж мөрдөлт хангалтгүйгээс бодит гүйцэтгэлээс давсан санхүүжилт олгох, техникийн шаардлага хангаагүй барилга хүлээн авах зэрэг зөрчил давтагдсан;
- Хэрэгжиж дууссан 2.1 их наяд төгрөгийн өртөгтэй 1,148 төслийн 6.2 хувь нь үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдаагүй, тоног төхөөрөмжийн урьдчилсан судалгаа, байршуулалт, ашиглалтын зохицуулалт хангалтгүйгээс зарим тоног төхөөрөмж ашиглалтад ороогүй, үр ашиггүй байна. Төсвийн хөрөнгөөр хувийн өмчид шилжих боломжгүй төсөл хэрэгжүүлсэн нь төрийн байгууллагыг бизнесийн үйл ажиллагаа эрхлэх байдалд хүргэсэн буруу жишиг байна.



Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 2 асуудлыг толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4, ТЭЗ нарт 3 зөвлөмжийг тус тус өгсөн байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023–2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитаар Засгийн газрын 2023–2025 оны өрийн байдал, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн судалгаа, шинжилгээ хийж, нотлох баримтад үндэслэн Засгийн газрын өрийн удирдлагын харгалзах оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг үнэлж, "Өрийн удирдлагын стратегийн дунд хугацаанд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн явц 2023–2024 оны байдлаар хангагдсан хэдий ч ханшийн өсөлт, эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулахад анхаарах шаардлагатай байна" гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Хүснэгт 12. Улсын нийт гадаад өрийн мэдээлэл, (2022–2024 оны байдлаар, сая ам.доллар, тэрбум төгрөгөөр)

Салбарын ангилал	2022 он		2023 он		2024 он	
	ам.дол	төгрөг	ам.дол	төгрөг	ам.дол	Төгрөг
Засгийн газар	8,012.5	27,599.9	8,105.1	27,644.0	7,887.6	26,979.2
Төв банк	2,179.0	7,505.8	1,784.8	6,087.4	1,086.3	3,715.6
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,532.6	5,279.2	1,733.2	5,911.4	2,657.0	9,088.2
Бусад салбарууд	8,436.0	29,058.6	7,865.8	26,827.8	8,235.1	28,167.8
Аж ахуйн нэгж хоорондын зээллэг шууд хөрөнгө оруулалт	13,184.8	45,416.4	15,080.6	51,435.3	17,254.3	59,017.6
Нийт гадаад өр	33,344.9	114,859.8	34,569.5	117,905.8	37,120.3	126,968.5

Эх сурвалж: Монголбанк

- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үнэлгээгээр стратегийн баримт бичгийн чанар, хэрэгжилтийн зохицуулалт, өрийн эрсдэл, мэдээллийн нэгдсэн байдал болон орон нутгийн өрийн менежментэд ноцтой доголдол байгааг энэхүү аудитаар тогтоов.
- Өрийн удирдлагын стратегийг хуульд нийцүүлэн боловсруулсан ч голлох стратегийг сонгосон үндэслэл, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтгүй тул бодлогын биелэлтийг үнэлэх боломж хязгаарлагдмал, иж бүрэн дүгнэлт өгөхөд саад учирсан, Өрийн удирдлагын зөвлөл 2023–2024 онд хуралдаагүй, стратегийн хэрэгжилтэд үнэлгээ, зөвлөмж гаргаагүй байсан нь хуулийн 21.2-т заасан чиг үүрэг биелээгүй байна.
- Стратегид дэвшүүлсэн 6 бодлогын зорилт, 23 арга хэмжээ нь хуульд заасан журмаар тайлагнасан боловч өрийн удирдлагын тогтвортой байдлыг хангах бодит ахиц хангалтгүй байна. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2024 онд 41.8 хувь болж буурсан эерэг нөлөөтэй байгаа ч эдийн засгийн бүтцийн төвлөрөл нь ирээдүйн тогтвортой байдалд эрсдэл учруулсан хэвээр байна. Төсвийн хүрээний мэдэгдэлд өрийн хязгаарыг ДНБ-ий 45–55 хувьд барихаар тогтоосон нь зохистой боловч хууль тогтоомжийг давтан, ойр ойрхон өөрчлөх нь дунд хугацааны төсвийн болон өрийн удирдлагын бодлогын тогтвортой байдлыг алдагдуулж байна.
- Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал 2023–2024 онд 9.6 их наяд төгрөг, 2025–2028 онд төлөх өрийн үйлчилгээ 16.4 их наяд төгрөгт хүрэхээр

төлөвлөгдсөн нь дахин санхүүжилтийн болон хүүгийн эрсдэл дунд хугацаанд өндөр хэвээр байгааг харуулж байна. Мөн ашиглаагүй гадаад зээлд тооцогдсон хүүгийн шимтгэлд 51.5 тэрбум төгрөг төлсөн нь төсөл эхлүүлэх бэлтгэл хангалтгүй, зээлийн үр ашиг буурч байгааг нотоллоо.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан бонд нь Өрийн удирдлагын тухай хуулийн зарчимд нийцээгүй, богино хугацаатай, өндөр хүүтэй санхүүжилтийг урт хугацааны дэд бүтцэд ашигласан нь эдийн засгийн үр ашиггүй бөгөөд улсын түвшинд өрийн бодлогын алдааг давтах эрсдэлтэй байна. Засгийн газрын өрийн зохицуулалтаар өмнөх гадаад үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авах, дахин үнэт цаас гаргах зэрэг арга хэмжээ авч, богино хугацаанд дарамтыг бууруулсан боловч урт хугацаанд дахин санхүүжилтийн эрсдэл учрахаар байна.

Хүснэгт 13. Засгийн газрын өрийн мэдээлэл, (2022–2024 он, тэрбум төгрөг)

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	2022 он	2023 он	2024 он*
1. Засгийн газрын дотоод өр	1,035.5	234.1	400.5
1.1. Үнэт цаас	1,035.5	234.1	400.5
2. Засгийн газрын гадаад өр	29,641.6	30,274.6	30,247.8
2.1. Үнэт цаас	9,359.8	9,371.7	8,655.0
2.2. Зээл	20,281.8	20,902.9	21,592.7
3. Бусад өр төлбөр	1,288.7	264.8	2,736.4
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	812.9	29.5	178.0
3.2. Орон нутгийн өр	463.5	4.5	2,558.4
3.3. Концесс (барих-шилжүүлэх)	12.3	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	31,965.8	30,773.5	33,384.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	27,691.6	26,582.9	
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%	65.0%	60.0%
		(ӨҮЦ)	(Нэрлэсэн)
Засгийн газрын өр / ДНБ	59.4%	43.7%	41.8%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	58.2%	37.7%	-

*-Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: Сангийн яам

- Сангийн яам болон Үндэсний статистикийн хорооноос гаргаж буй өрийн мэдээлэл зөрүүтэй байгаа нь өрийн үлдэгдэл аудитаар баталгаажсаны дараа статистикийн мэдээллийг шинэчлэн тусгадаггүй, мэдээллийн бүтэц зөрдөгтэй холбоотой бөгөөд бодлогын түвшний ил тод, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Засгийн газрын өрийн багцын эрсдэлийн тооцоонд нийслэлийн үнэт цаасны нөлөөллийг тусгаагүй бөгөөд энэ нөлөөллийг бодитоор тооцвол 2024 оны зорилтот түвшнийг давсан дүнтэй гарч байгаа нь өрийн бодит эрсдэлийг буруу үнэлэх, хууль өөрчлөх шийдвэр буруу гарах эрсдэлтэйг харуулсан.


Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хурлын анхааралд 2 асуудал толилуулж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 1, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, Сангийн сайдад 5, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 1 зөвлөмжийг тус тус өглөө.



МОНГОЛ УЛСЫН 2021–2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Үндсэн чиглэлд баталсан нийт 243 арга хэмжээний 25.5–52.7 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөөнд тус тус туссан, 36.6–49.4 хувь нь Монгол Улсын 2021–2025 онуудын төсвийн тухай хуульд туссан байна. Дээрх 243 арга хэмжээнээс 2022–2025 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 53 арга хэмжээ буюу 21.8 хувь нь огт тусгагдаагүй байна.

Монгол Улсын 2021–2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр 150 төсөл, арга хэмжээ



Үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан нийт 150 төсөл, арга хэмжээний 19.3–30.0 хувь Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөөнд туссан бол 8.0–16.0 хувь Монгол Улсын 2021–2025 оны төсвийн тухай хуульд туссан бол дээрх 150 арга хэмжээнээс нийт 64 төсөл арга хэмжээ буюу 42.6 хувь нь огт тусгагдаагүй байна.

- "Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилт 67.7 хувьтай байгаа бөгөөд нийт арга хэмжээний гуравны нэг орчим нь үр дүн дутуу, цаашид эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн нь хөгжлийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.
- Үндсэн чиглэлийг хуульд заасан шаардлагын дагуу иж бүрэн судалгаатай боловсруулаагүй, хэрэгжилтийг жилийн төлөвлөгөө болон төсвийн хуультай уялдуулах зохицуулалт хангалтгүй байсан нь арга хэмжээ хугацаандаа биелэх, үр нөлөөг бодитой үнэлэх боломжийг хязгаарлаж байна.
- Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагын тогтолцоо тодорхой бус, хариуцлага тооцох шалгуур нарийвчилж тогтоогоогүй тул үр дүнгүй, хэрэгжилт удаашралтай арга хэмжээний хувьд санхүүгийн болон удирдлагын хариуцлага бодитоор хэрэгжихгүй нөхцөл бий болжээ.
- Үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, арга хэмжээний нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тооцох тогтолцоо бүрдээгүй, бодлогын баримт бичиг хоорондын уялдаа сул, санхүүжилтийн эх үүсвэр баталгаажуулалт дутуу зэрэг шалтгаанаар хэрэгжилтийн үр ашиг буурч, хөгжлийн бодлогын нөлөө бодитоор илрэхгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 3 асуудал толилуулж, Тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-д 2 болон ЗГХЭГ-ын даргад 4, Сангийн сайдад 2, ТЕЗ нарт 3 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.



УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн үр дүн 68.8 хувь, ТЕЗ-дын үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 53.9 хувь, Хөтөлбөрийн үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 58.6 хувь, 194 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52.2 хувь байна.


- Гадаад худалдааны бараа эргэлтээр 2024 онд экспортын хэмжээ 15.8 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 0.6 тэрбум ам.доллаар нэмэгдсэн ч төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ 40 хувьтай буюу зорилт үр дүнг бүрэн хангаагүй байна.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2024 онд 4 тэрбум ам.долларт хүрч зорилтот түвшнийг хангасан ч "Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ" гэсэн тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний дундаж үнэлгээ 51.2 хувьтай буюу зорилтот үр дүнг бүрэн хангаагүй байна.
- Нэгдсэн Үндэсний Байгууллагаас улс орнуудын Хүний хөгжлийн индексийн тайланг 4 жилд нэг удаа гаргадаг тул тэргүүлэх чиглэлийн үр дүнг 2024 оны байдлаар үнэлэх боломжгүй байна.
- "Аялал жуулчлалыг хөгжүүлнэ" гэсэн тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтээр 2024 онд Монгол улсын хүлээн авах гадаад жуулчны тоог 1.3 саяд хүргэхээр төлөвлөсөн ч 0.7 сая жуулчин хүлээн авснаар зорилтот түвшнийг хангаагүй байна.
- Манай Улс Хүнсний аюулгүй байдлын индексийг тооцох аргачлалыг боловсруулж батлаагүй тул Тэргүүлэх чиглэлийн үр дүнг үнэлэх боломжгүй байна.
- "Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна" гэсэн тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт болох "хотын хөгжлийн үзүүлэлт /индекс/" 2023 онд 0.5022 болж 83.7 хувьтай үнэлэгдэж зорилтод түвшнийг хангаагүй байна.
- "Засаглалын үзүүлэлтийг сайжруулна" гэсэн тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хүрээнд 2024 оны Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж үзүүлэлт гараагүй тул тус шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна.
- "Ногоон хөгжлийг дэмжинэ" гэсэн тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт "байгаль орчны гүйцэтгэлийн индекс"-ээр 2024 онд 180 орноос 143 дугаарт эрэмбэлэгдсэн нь 48 хувь буюу "эрчимжүүлэх шаардлагатай" үнэлэгдсэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 4 зөвлөмж, Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4 зөвлөмж, Сангийн сайдад 1 зөвлөмж, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 3 зөвлөмж, нийт 12 зөвлөмжийг өгсөн байна.



"МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ ҮР НӨЛӨӨ, ҮР АШИГ

Монгол Улсын Үндэсний аудитын газар, Оросын Холбооны Улсын Тооцооны танхим хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг удирдлага болгон Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар Төмөр зам" ХНН-ийн Зөвлөлт Холбоот Улс, БНМАУ-ын Засгийн газар хооронд (хуучин нэрээр)-ын 1949 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хэлэлцээрийн хэрэгжилт болон "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагааны үр дүн, нийгэм эдийн засагт үзүүлж буй үр нөлөө, үр ашиг"-ийн байдалд аудитыг төлөвлөсний дагуу Оросын Холбооны Улсын Тооцооны танхимын аудитын багтай хамтран гүйцэтгэлээ.



Аудитаар "Улаанбаатар Төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн нэр дээр байнга ашиглах эрхийн бүртгэлд хамрагдах ёстой газрууд нь бусад этгээдийн (хуулийн этгээд, хувь хүн) нэр дээр бүртгэлтэй, зарим газрын байнгын ашиглалтын эрхийн бүртгэлийг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж баталгаажуулаагүй бөгөөд 1949 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн заалт бүрэн хэрэгжээгүй байгааг тогтоосон.

"Улаанбаатар Төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зорчигчийн 332 вагоноос ашиглалтын хугацаа дууссан 160 вагоныг зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж байна, мөн 5,655.1 сая төгрөгийн үнэ бүхий 259 вагоны ашиглалтын нормт хугацаа дууссан, "УБТЗ" ХНН-ийн үндсэн хөрөнгөд 141 илчит тэрэгнээс 51 илчит тэрэгний ашиглалтын хугацаа дууссан, 29-40 жил ашиглаж байгаа 92 вагон, 40-с дээш жил ашиглаж байгаа 167 вагоноос Монгол Улсын MNS 6312, 6039 стандарт буюу "... Ашиглалтын хугацаа дууссан илчит тэргийг төмөр замын тээврийн үйл ажиллагаанд ашиглахгүй" гэсэн заалтыг зөрчсөн зэрэг зөрчлүүд илэрсэн. Төрийн аудитын байгууллагаас дээрх алдаа, зөрчлийг арилгах талаар төлбөрийн акт, албан шаардлагыг "Улаанбаатар Төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгт хүргүүлсэн.

Хамтарсан аудитын үр дүнд төрийн аудитын байгууллагаас "Улаанбаатар Төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгт хоёр улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, хамтарсан менежментийн бүтэц, хариуцлагын зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой 11 дүгнэлт өгч, Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, нийгэмлэгийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн 6 зөвлөмжийг өглөө.

ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨРТӨГ, ЗАРДАЛ

Аудитаар эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлт, бүтэц тогтолцоо, санхүүжилт, тарифын зохицуулалт, төслүүдийн хэрэгжилт болон салбарын үр ашигт байдалд нийтлэг системийн доголдол байгаа нь тогтоогдлоо. Салбарын хөгжлийн бодлогууд Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуураар уялдуулан төлөвлөгдөөгүй, "Алсын хараа 2050"-д тусгасан зорилго, арга хэмжээг хэмжих суурь мэдээлэл бүрдээгүй, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг уялдуулах тогтолцоо бүрдээгүйгээс урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих чадвар сул байсан.

Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгжүүд санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж, улсын төсвөөс тогтмол татаас авч буй нь компанийн засаглал, хариуцлага, санхүүгийн сахилга бат сул байгааг харуулж байна.

- Томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд төсвийн дэмжлэг, алдагдлын дарамт нөлөөлж, төслүүдийн гүйцэтгэл хоцрох, өртөг нэмэгдэх, төслийн санхүүжилт эрэмбэлж шийдвэрлэх тогтолцоо бүрдээгүй байна. Хуримтлагдсан алдагдлаас шалтгаалж тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ хойшлогдож, эрчим хүчний тасралтгүй, найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл үүссэн байна.
- Сэргээгдэх эрчим хүчний бодлого хэрэгжилтийн хувьд системд нийлүүлэх хэмжээ өссөөгүй ч хэрэглэгчээс авах төлбөр өссөн, гэрээний гарааны үнэ өртөг зардлын бодит тооцоолдол суурилаггүй, дэмжих тарифын мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй тусгаагүй зэрэг нь ил тод байдал, хэрэглэгчийн эрхийг хязгаарлаж байна.
- Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөг, үйл ажиллагааны зардал, инфляцын нөлөөг харгалзан тооцох, тогтмол индексжүүлэх зохицуулалт хангалтгүйгээс салбарын алдагдал гүнзгийрч, хэрэглэгчдэд ирэх санхүүгийн дарамт нэмэгдэж байна. Өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын эх үүсвэрээс хангах бодит хүчин чармайлт сул, импортын хамаарал нэмэгдэж, тарифын өсөлтөд нөлөөлсөн хэвээр байна. Гэр хорооллын цахилгааны хэрэглээнд олгож буй хөнгөлөлт бодит тооцоо судалгаагүй, зорилтот бүлэгт чиглээгүйгээс эрчим хүчний салбарын татаас улам нэмэгдэх шалтгаан болж байна.
- Тариф тогтоох зарчим болон диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагаанд давхардсан, уялдаагүй, үндэслэлгүй зохицуулалт илэрч, ЭХЗХ-ны баталсан тарифын бүтэц аргачлалдаа нийцэхгүй байгаа нь тарифын үнэн зөв тогтоолтод эргэлзээ үүсгэж байна. Үндэсний аудитын газраас 2017, 2021 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, системийн доголдол арилж сайжрахгүй хэвээр байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдад 2, Эрчим хүчний сайдад 10, ЭХЗХ-ны удирдлагад 10, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-д 2 зөвлөмж тус тус өгсөн байна.



УУЛ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитаар уул уурхайн салбарын бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн зохицуулалт, тусгай зөвшөөрлийн олголт, мэдээллийн сангийн уялдаа холбоонд системийн доголдол давамгайл байгаа нь ил тод, хариуцлагатай уул уурхайн тогтолцоо бүрэн бүрдээгүйг харууллаа. Салбарын гол хуулиудад шинэчлэл хийгдсэн ч хөгжлийн бодлогын зорилт тусгагдаагүй, Ашигт малтмалын тухай хууль болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт уялдаагүйгээс нэгдсэн бодлого, шийдвэр гаргалт төлөвшөөгүй байна.

Хууль тогтоомж хоорондын уялдаагүй байдал болон мэдээллийн нэгдсэн сан дутуугаас шалтгаалан тусгай зөвшөөрөл давхцан олгогдох нөхцөл бүрдэж, салбарын ил тод байдалд ноцтой эрсдэл учруулжээ.

Эрдсийн хуримтлалтай талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгодог практик нь стратегийн ач холбогдолтой ордуудад хяналтгүй ашиглалт, борлуулалтын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ордын нөөц, ТЭЗҮ-г зөвхөн зөвшөөрөл авах зорилгоор хэлэлцүүлж байгаа нь олон улсын стандарттай нийцэхгүй бөгөөд уул уурхайн төсөл, хөрөнгө оруулалтын үнэн зөв тооцооллыг хангах боломжийг хязгаарлаж байна. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолд заасан 39 ордыг судалж стратегийн ордод хамруулах эсэхийг өнөөг хүртэл шийдээгүй, стратегийн орд эзэмшигчид хувьцааныхаа 10 хувийг үнэт цаасны биржээр арилжих хуулийн заалт огт хэрэгжээгүй нь салбарын засаглал, хариуцлага, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг сааруулж байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалыг улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд үндэслэн тодорхойлох, Үндэсний баялгийн санд татвар, төлбөрийг тэгш төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бий. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын хариуцлага, эрхийг хамгаалах зохицуулалт сул, Зөвшөөрлийн тухай болон Захиргааны ерөнхий хуультай нийцээгүй байдал үр ашиггүй тусгай зөвшөөрөлтэй талбайн тоог нэмэгдүүлж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын АМНАТ-ын тооцоолол бүрэн зохицуулагдаагүй, гео мэдээллийн сангийн кибер аюулгүй байдал, хүртээмжийн зохицуулалт бүрэн хэрэгжээгүй, архив мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй зэрэг нь салбарын мэдээллийн нэгдмэл байдлыг алдагдуулж байна. Эдгээр доголдол нь салбарын хариуцлагатай хөгжил, орлогын шударга хуваарилалт, стратегийн ордын засаглалыг бүрэн гүйцэтгэх нөхцөлийг сулруулж байгаа гол шалтгаанууд оршоор байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-ын анхааралд 2 асуудлыг толилуулж, ЗГХЭГ-т 2, АҮЭБЯ-нд 4, Ашигт малтмал, газрын тосны газарт 1 зөвлөмж тус тус өгсөн байна.



УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн нөхөн сэргээлтийн бодлого, хууль эрх зүй, санхүүгийн баталгааны тогтолцоо болон хэрэгжилтийн бүх шатанд системийн доголдол давамгайл байгааг тогтоов. ААН-үүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бодитой гаргаагүй, хугацаанд нь батлуулаагүй, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд шаардлагатай хөрөнгийг бүрэн байршуулдаггүй, зарим сум, дүүрэг тусгай данс нээгээгүйгээс баталгааны мөнгийг бусад дансанд төвлөрүүлж зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчил нийтлэг байна.

Хууль тогтоомжийн зохицуулалт баталгааны мөнгийг хаана, хэрхэн төвлөрүүлэх талаар ялгаатай, тодорхой бус тул хэрэгжилт нэг мөр биш, баталгааны сан бүрэн бүрэлдээгүй байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо бодит бус, хугацаандаа батлагдахгүй байгаа нь нөхөн сэргээлтийн зардлыг бүрэн тооцох боломжгүй болгож, эвдэрсэн газрын хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр дутагдах нөхцөл бүрдүүлжээ. Баталгааны санг зарцуулах эрх зүйн тогтолцоо тодорхой бус, уурхайн хаалтын үед хөрөнгийг буцаан олгох зохицуулалт нь төлөвлөгөөний зардлыг хийсвэрээр тооцох шалтгаан болж байна.

Нөхөн сэргээлт хийгээгүй, баталгааны мөнгө байршуулаагүй, тайлангаа хугацаанд гаргаагүй зэрэг зөрчил гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд холбогдох байгууллага хуульд заасан арга хэмжээ авч ажиллаагүйгээс эвдэрч, орхигдсон газрын хэмжээ тасралтгүй нэмэгдэх эрсдэлтэй байна. Сум, дүүргийн тусгай данс нээгдээгүй, баталгааны мөнгө бусад дансанд төвлөрсөн нь санхүүгийн сахилга бат алдагдаж, нөхөн сэргээлтийн санг зориулалт бусаар ашиглах эрсдэлийг бий болгожээ.

Нөхөн сэргээлт хийгдээгүй аж ахуйн нэгжүүдэд нэмэлт зардлыг гаргуулж, хариуцлагыг оногдуулаагүйгээс эвдэрсэн газрыг ихэвчлэн улсын болон орон нутгийн төсвөөр эсвэл бусад компаниар дүйцүүлэн нөхөн сэргээх байдал давамгайл байна. Нөхөн сэргээгдсэн газрын дараагийн ашиглалтын зориулалт тодорхойгүй, бодлогын уялдаа хангалтгүй байна.

Нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын талаарх мэдээлэл төрийн байгууллагуудын хооронд зөрүүтэй, уялдаагүй, улсын хэмжээний нэгдсэн бодит тоон мэдээлэл байхгүйгээс зарим нөхөн сэргээсэн талбайд дахин тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол илэрсэн нь мэдээллийн нэгдсэн тогтолцоог яаралтай бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн БОУАӨС-д 7, Сангийн сайдад 2, ҮСХ, БОУАӨЯ, ХЗДХЯ, АҮЭБЯ, ГЗБГЗЗГ-ын удирдлагад тус бүр 1, ХЗДХС-д 1 зөвлөмж тус тус өгснөөс гадна 11 зөрчилд 5.8 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25 зөрчилд 0.9 тэрбум төгрөгийн албан шаардлага өгсөн байна.



ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮН

Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоо улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ, шийдвэрийг дэмжих мэдээллийн системийн шатанд бүрэн төлөвшөөгүй, системийн түвшний доголдол давамгайл байгааг тогтоов. Хөгжлийн бодлогын баримт бичгийг 4 түвшний урт, дунд, богино хугацааны бодлоготой уялдуулах шаардлагатай атал бодлогын бусад гол дэмжлэг болох үр дүнд суурилж төсөвлөх, гүйцэтгэлийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.

Төрөөс төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого, шинэчлэлийг 30 жилийн турш хэрэгжүүлэхээр оролдсон ч хэрэгжилт нь тогтмол тасалдсан, манлайлал, улс төрийн дэмжлэг, засаглалын соёл, чадавх сул байснаас үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоо бүрэлдээгүй хэвээр байна. ЭЗХЯ болон Сангийн яамны стратегийн чиг үүрэгт ч үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтөд шилжих бодлогын зорилт тодорхой бус байна.

Бодлогын баримт бичгийн уялдаа сул, хөгжлийн баримт бичиг хэт олон, төсвийн төлөвлөлтийн "гүүр" болж чадахгүй байгаагаас төсөв захирагчид шахуу хугацаанд хөтөлбөр төлөвлөж, суурь судалгаа, тооцоолол орхигдох, хуульд заасан шалгуурыг бүрэн хангахгүй төлөвлөгөө гаргах шалтгаан болж байна. Хөтөлбөрийн өртгийг тооцох норм, норматив тогтоогдоогүй тул санхүүгийн нөөцийг тогтвортой төлөвлөх боломжгүй, хэрэгжилт удааширч, өртөг нэмэгдэх нөхцөл бүрджээ.

ТЕЗ-д хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ёстой боловч ихэнх тохиолдолд судалгаанд суурилагагүй, хэмжигдэхүйц бус, загвар жишиг хөтөлбөргүйгээс төсвийн хөтөлбөрийн чанар хангалтгүй байна. Засгийн газрын бүтэц хөгжлийн бодлого, стратегийн хэрэгжилтэд нийцээгүй, олон асуудлыг зэрэг шийдэх гэж оролдсоноор төсөл, хөтөлбөрүүдэд санхүүгийн нөөцийн хуваарилалтын үр дүн багасаж, төсвийн үр ашиг буурахад хүрч байна.

- Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг эдийн засгийн боломжид үндэслэн эрэмбэлж тодорхойлох, төсөл хөтөлбөрийн бэлэн байдлыг үнэлэн, түүнд нийцсэн Засгийн газрын бүтцийг бүрдүүлэх нь төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх гол нөхцөл боловч хэрэгжихгүй байна.
- Хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлтөд оролцогч талуудыг нэгтгэсэн, мэдээллээр хангах нэгдсэн мэдээллийн систем байхгүй тул хяналт, үнэлгээ бодит үр нөлөөтэй хийгдэх боломжгүй, үнэлгээ нь зөвхөн бичиг баримтад оноо өгөх түвшинд хязгаарлагджээ.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хурлын анхааралд 3 асуудал толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 2, Үндэсний статистикийн хороонд 1 зөвлөмж тус тус өглөө.



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ТОГТОЛЦОО, ҮР ДҮН

Хүнсний аюулгүй байдлын бодлого төлөвлөлт, эрх зүйн орчин, хяналтын тогтолцоо, лабораторийн шинжилгээ, мэдээллийн уялдаа холбоо болон импортын хяналтын бүх шатанд системийн доголдол давамгайл байгааг тогтоов.

Бодлогын зорилт, арга хэмжээ нь уялдаа сул, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломж хязгаарлагдаж, хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл болон холбогдох яам, агентлагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлээгүйгээс хүнсний аюулгүй байдал зөрчигдөж байна.

- Аюулгүй байдлын стандарт, техникийн зохицуулалт олон улсын шаардлагад нийцээгүй, зарим бохирдуулагчийг хянах стандартгүй, үндэсний лабораториуд хүнсний сорилт, шинжилгээг бүрэн хийх чадавхгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлын үндсэн баталгааг алдагдуулж байна. Лавлагаа лабораториуд MNS ISO/IEC 17025:2018 стандартад нийцэхгүй, лаборатори хоорондын шинжилгээний дүн зөрүүтэй, арга зүй баталгаажуулж, олон улсын хэмжээнд тохирлын баталгаажуулалтын үнэн зөв байдалд эргэлзээ үүсэх эрсдэл өндөр байна. Хүнсний сав, савлагааны материалаас хүнсэнд шилжих химийн бодисын шинжилгээ Монгол Улсад огт хийгдэхгүй байгаа нь хүнсний хяналтын цоорхойг үүсгэж, хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл бий болгожээ.
- Импортын хүнсний хяналтын эрх зүйн орчин бүрдээгүй, гаалийн хяналт эрсдэлд суурилсан байхаар шинэчлэгдээгүй, аюулгүйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг шийдвэрлэх үе шатанд хяналт сул тул хүнсний аюулгүй байдлын доголдол үргэлжилсээр байна. Улсын болон гадаадын зээлээр баригдсан лабораторийн барилга, тоног төхөөрөмж ашиглагдахгүй, шинжилгээ хийгдээгүй зөрчил гарсан нь хөрөнгө оруулалтын үр ашиггүй байдлыг харууллаа.
- Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоонд салбар хоорондын уялдаагүй, чиг үүргийн давхардалтай, хяналт, мэдээлэл солилцооны нэгдсэн систем бүрдээгүй, шинжилгээний дүнг нэгтгэх мэдээллийн сан байхгүй тул бодит эрсдэлийг үнэлэх, хяналт, хариуцлага хэрэгжүүлэх боломж хязгаарлагджээ. Хүнсний салбарын мөрдөж буй стандартын 23 хувь нь хуучирсан, олон улсын Кодекс, Европын холбооны стандартуудад тусгасан бохирдуулагч үзүүлэлтүүдийн ихэнхийг Монголд шинжилдэггүй нь хяналтын бүрэн бүтэн байдал, хэрэглэгчийн аюулгүй байдлыг алдагдуулж байна. Мал, амьтны гаралтай хүнсний бохирдуулагчийн шинжилгээ хангалтгүй, эрсдэлийн үнэлгээ 2022 оноос хойш хийгдээгүй, аюулгүйн үзүүлэлтүүд шинэчлэгдээгүй байна.
- Үүнээс гадна ХАБҮЛЛ, УМЭАЦТЛ зэрэг байгууллагын шинжилгээний хугацаа удаан, арга зүй, серийн дугаар тэмдэглэлт зэрэг зохион байгуулалтын доголдол нь түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний хяналт, буцаан татан авах үйл ажиллагааг хүндрүүлж, хүн амын эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд 4, ХХААХҮЯ-нд 11, ЭМЯ-нд 1, Мал эмнэлгийн ерөнхий газарт 4, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2, Стандарт, хэмжил зүйн газарт 5, ХАБҮЛЛ-д 6, Гаалийн ерөнхий газарт 5 зөвлөмж өгөв.



БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН 2017–2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

Боловсролын зээлийн сангийн эрх зүйн орчин, байгуулалтын бүтэц, сангийн үйлчилгээний чанар, санхүүжилтийн ашиглалт, хариуцлагын тогтолцоо, мэдээллийн системийн чадамж зэрэгт нөлөөлөхүйц доголдол байгааг тогтоов. Засгийн газраас БЗС-гийн ажлын албыг байгуулалгүй, сангийн хуулийн статус тодорхойгүй, холбогдох хуулиудад уялдаа хангагдаагүйгээс сангийн зорилго, чиг үүрэг бодитоор хэрэгжих боломж хязгаарлагджээ. Журмын олон удаагийн өөрчлөлт, дотоод зохион байгуулалтын тогтворгүй байдал, хүний нөөцийн тогтворгүй байдал нь иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чанаргүй, үр нөлөөгүй болгож байна.

Улсын төсвөөс 2017–2024 онд олгосон нийт санхүүжилтийн 57 хувь нь тэтгэлэгт, 43 хувь нь сургалтын төлбөрийн зээлд зарцуулагдсан боловч сонгон шалгаруулалт ил тод бус, зарим тохиолдолд сайдын тушаалаар журмын шаардлага зөрчигдөн тэнцээгүй иргэдэд олгосон, өмнөх зээлээ төлөөгүй иргэдэд давхар санхүүжилт олгосон зэрэг ноцтой зөрчил илэрсэн байна. Сангаас байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, хариуцлага тооцох тогтолцоо байхгүйгээс 299 иргэний 19.9 сая ам.долларын зээл эргэн төлөгдөөгүй, хуульд нийцээгүй шийдвэрээр 381 иргэн нийт 11.2 сая ам.долларын зээлээс чөлөөлөгдсөн нь эрх мэдлийн хэтрүүлсэн, улсын төсвийн хохирлыг нэмэгдүүлжээ.

Судалгаанд суурилсан бодлого, хяналт, хариуцлага сул байгаагийн улмаас гадаадын их, дээд сургуульд суралцсан 237 иргэний төгсөлт, буцаж ирсэн эсэх, мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх бүртгэлгүй, улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн боловсон хүчний үр нөлөө хэмжигдээгүй байна. Мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, ашиглаж буй систем нь автоматжуулалт дутмаг, олон мянган суралцагчийн хувийн баримт бичиг цаасан суурьтай хэвээр байх нь мэдээллийн ил тод, найдвартай байдлыг алдагдуулж, маргаан үүсэх, баримт устах эрсдэлийг үүсгэжээ.

Өмнө нь хийгдэж байсан АХЭ-ийн санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтээр буюу 2017–2019, 2022–2024 онд "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан, салбарын яам дотоод хяналтыг 5 жилийн хугацаанд огт хэрэгжүүлээгүй зэрэг нь хяналтын тогтолцоо сул, үр нөлөөгүй байсныг нотолж байгаа бөгөөд тэдгээр аудитаар 31.3 сая ам.долларын алдаа, зөрчил илэрч, сангийн удирдлагад болон салбарын сайд, Монгол Улсын Ерөнхий сайдад нийт 18 зөвлөмж хүргүүлсэн байна.

Боловсролын салбарын сайдаас эрх мэдлээ хэтрүүлэн гаргасан 381 иргэний 11,233.2 мянган ам.долларын сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлсөн шийдвэрийг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлж, нийт 132.0 мянган ам.доллар буюу 491.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт 2, Боловсролын яаманд алдаа зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, нийт 19,927.8 мянган ам.доллар буюу 71,643.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлагыг хүргүүлээд байна.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ӨМНӨХ ОНУУДАД АЖИЛ НЬ ЭХЭЛСЭН БОЛОВЧ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ АУДИТЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ

Дүгнэлт гаргах аудитын хүрээнд нийт 10 ТЕЗ-ийн 1,299,492.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 185 ТАХ-ний төсөвт өртгийг 650,397.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр ирүүлсэн ба нийт 1,949,889.1 сая төгрөгийг төсөвт өртгийн тооцооллыг хянасан байна.

Нийт 185 төслийн ажлын зураг төсөл (ТАХ)-ийг хянаснаас 145 ТАХ-д төсөвт өртгийн талаарх нарийвчилсан дүгнэлт гаргасан бөгөөд зураг төсөл, тооцооллын чанарт өргөн хүрээний алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд зураг төслийн алдаа болон давхардсан, үндэслэлгүй зардлын хүснэгтийг залруулах замаар нийт 150.7 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлэн зассаныг тогтоов. Тухайлбал:

- 33.3 тэрбум төгрөгийн зураг төсөл алдаатай, дахин магадлах шаардлагатай;
- 29.3 тэрбум төгрөгийн төсөв улсын төсөвт тусгах шаардлагагүй;
- 61.7 тэрбум төгрөгийн зураг төсөлд алдааг залруулж зөв дүгнэлт гаргасан;
- Төсөв нэмэгдүүлэх саналын 31.3 хувь нь үндэслэлгүй байсныг залруулж, магадлалын дүгнэлтийн алдааг зассанаар 87.9 тэрбум төгрөгийг бууруулсан.

Зураг, төсөл боловсруулах үйл явцад норм, дүрмийн шаардлагыг баримтлаагүй 65 хуулийн этгээд зөрчил гаргаснаас:

- 49 нь 29.0 тэрбум төгрөгийн зөрчил бүхий 1–2 удаагийн алдаа;
- 11 нь 13.6 тэрбум төгрөгийн 3–5 удаагийн алдаа;
- 4 нь 46.7 тэрбум төгрөгийн 6–8 удаагийн алдаа гаргасан нь зураг, төслийн чанарыг хянах тогтолцоо сул байгааг илтгэж байна.

Нийт 101 төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт алдаатай, норм, нормативын шаардлага хангаагүй зураг төсөл баталгаажсан, экспертийн хяналтаар алдааг засахгүйгээр магадлал хийсэн зэрэг зөрчлийн улмаас "зураг төсөл, магадлалын алдаанд холбогдох хариуцлага тооцох" албан шаардлага хүргүүлсэн. Эдгээр зөрчлийн шалтгаан нь зураг төсөл боловсруулах, магадлал хийх, баталгаажуулах үйл явцын хяналт, хариуцлагын тогтолцоо сул, процессын урсгал тодорхой бус, мэргэжлийн хяналтын шатлал хоорондын уялдаа хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд аудитын дүгнэлтээр барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх үйл явцыг процессын зураглалын түвшинд шинэчлэн зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай гэж үзсэн.

Аудитаар 145 ТАХ-ний төсөвт өртгийг 1,408.3 тэрбум төгрөг байхаар тооцоолж, захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналын дүнгээс 163.0 тэрбум төгрөг буюу 31.3 хувь, магадлалаар баталгаажсан төсвийн дүнгээс 87.9 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар бууруулж 68.7 тэрбум төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

УИХ-д 1 асуудлыг толилуулж, ЗГХЭГ-ын даргад 2, Сангийн сайдад 1, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 4 зөвлөмжийг тус тус өгсөн байна.



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, засаглал, санхүүжилт, аюулгүй ажиллагааны тогтолцоо бүх шатанд системийн доголдол байгааг тогтоов. Салбарын бодлого нь барилга, дэд бүтэц нэмэгдүүлэхэд голчлон чиглэсэн бөгөөд салбарын өрсөлдөх чадвар, үйлчилгээний чанар, аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн чадавх, менежментийн шинэчлэл зэрэг гол чиглэл орхигдсон байна.

- Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, салбарын навигаци, холбоо, ажиглалтын чухал тоног төхөөрөмжүүдийн ихэнх нь ашиглалтын хугацаа дуусах дөхсөн, найдвартай ажиллагаа алдагдах эрсдэл өндөр байна. Энэ нь 2026 онд хийгдэх Олон улсын иргэний нисэхийн байгууллагын аудитад Монгол Улс ноцтой эрсдэлтэй байгууллагаар ангилагдах аюул үүсгэж, олон улсын түншүүдийн итгэл, улсын агаарын тээврийн хөгжилд саад болох сөрөг үр дагавартай байна.
- Салбарын байгууллагын удирдлагын тогтворгүй байдал нөхцөл байдлыг улам хүндрүүлж байгаа бөгөөд 2012–2025 онд салбарын гүйцэтгэх удирдлагыг 11 удаа өөрчилсөн, нэгжийн дундаж ажилласан хугацаа 1 жил 4 сар, төсвийг дунд хугацаанд тогтвортой батлахгүй байх зэрэг нь мэргэшсэн хүний нөөц бүрдэх, байгууллагын соёл төлөвших боломжийг алдагдуулжээ.
- Навигацийн үйлчилгээний хураамжаас 2018–2024 онд нийт 1.47 их наяд төгрөг төвлөрүүлсэн ч олон улсын гэрээний дагуу аюулгүй ажиллагааг сайжруулахад зориулж зохистой зарцуулаагүй нь салбарын аюулгүй ажиллагааны чадавхыг сулруулсан, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх бодлого бүрдээгүйгээс он дамжсан авлага 4.3 тэрбум төгрөгт хүрч, орон нутгийн нисэх буудлууд 2019–2024 онд нийт 116.1 тэрбум, Буянт-Ухаа ОУНБ 2018–2024 онд 27.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.
- Иргэний нисэхийн тухай хуулийн олон улсын гэрээтэй нийцээгүй байдлаас шалтгаалан нисэхийн аюулгүй байдлын байцаагчийн эрх зүйн статус тодорхойгүй, эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй, олон улсын шаардлагад нийцсэн сургалт, үнэлгээ, чадавхжуулах тогтолцоо бүрдээгүй байна. Энэ нь үндэсний дүрмийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, олон улсын түвшинд мэргэшсэн байцаагч ажиллуулах боломжийг хааж байна.
- Хяналтын тогтолцоо сул, тогтворгүй, бие даасан мониторинг хийх бүтэц бүрдээгүйгээс салбарын удирдлагын шийдвэр гаргалт нь аюулгүй ажиллагааны хариуцлагатай шууд зөрчилдөх байдалд хүрчээ. 2022–2024 онд "Зорт Эйр" ХХК-ийн агаарын хөлгийг гэрчилгээжүүлэхдээ дүрмийн ангиллыг зөрчиж, шаардлагатай хяналтын үе шатыг алгассан зэрэг зөрчил илэрсэн нь хяналтын тогтолцооны хариуцлага сул байгааг нотолж байна.
- ОУИНБ-ын 2010, 2017 оны аудитын үнэлгээ харьцангуй сайн байсан ч илэрсэн зөрчлүүдийг арилгаагүй, шинэчлэл хийгдээгүй, урьдчилсан шалгалтаар ноцтой эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

УИХ-д 2 асуудал толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Зам, тээврийн сайдад 2, ИНЕГ-т 4, Иргэний нисэхийн үндэсний төвд 3 зөвлөмжийг тус тус өглөө.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУД БОЛОН "ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦ" ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн санхүүжилт болон дэмжлэгийн тогтолцоо нь хууль эрх зүйн уялдаа сул, сангийн үйл ажиллагааны зохион байгуулалт тогтворгүй, санхүүжилтийн хяналт, хариуцлагын тогтолцоо дорой, мэдээллийн нэгдсэн орчин бүрдээгүй зэрэг нийтлэг, системийн доголдолтой болохыг илрүүлсэн байна.

ХХААХҮЯ ба ЖДҮГ-Бодлого, зохион байгуулалт, дотоод хяналтын дутагдлууд илэрсэн байна. Тухайлбал:



- ЖДҮГ стратеги төлөвлөгөөгүй ажилласан нь Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын шаардлага зөрчсөн;
- Хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг батлахдаа хүү, хугацаа, чөлөөлөх нөхцөл зэргийг тооцоололгүй, үндэслэлгүй баталсан;
- ХХААХҮЯ баталсан салбар, чиглэлд хамаарахгүй 25 ААН-д 2.8 тэрбум төгрөгийн зээл олгосон нь бодлогын баримт бичгийг зөрчсөн;
- Дотоод хяналтын газраас зээлдэгчдийн эргэн төлөлтөд хяналт хэрэгжүүлээгүйгээс "найдваргүй зээлдэгчдийн" тоо өссөн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан-Шалгалтгүй зээл олголт, тэгш бус хүртээмж, эргэн төлөлтийн эрсдэлтэй байдал илэрсэн байна. Тухайлбал:



- 2023-2024 онд сангийн эх үүсвэр 111.7 тэрбум төгрөг, үүнээс 74.0 тэрбум төгрөгийг бичил ангиллын ААН-д олгосон боловч жижиг, дунд ангиллын ААН-д зээл олгоогүй-тэгш хүртээмжийн бодлого хэрэгжээгүй;
- Төсөл сонгон шалгаруулалт баримт бичгийн шалгалт дутуу, санхүүгийн чадамж бодитоор үнэлээгүй, шалгуур хугацаа тодорхойгүй, хяналтын процесс бүрдээгүй;
- 25 ААН-д улсын бүртгэлд байхгүй чиглэлээр 3.9 тэрбум төгрөгийн зээл олгосон;
- Авлага бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ 2009-2024 онд олгосон 370.1 тэрбум төгрөгийн зээлийн 50.3 хувь буюу 186.0 тэрбум нь эргэн төлөгдөөгүй, үр дүнд хүрээгүй байна.

"Хөдөө Аж Ахуйн корпорац" ТӨХХК-Бүтээгдэхүүн нөөц бүрдүүлэлт, авлага, өглөгийн эрсдэл үүсчээ. Тухайлбал:



- Улаан буудайн улсын нөөцийн бүрдүүлэлт, гүйцэтгэл 2023 онд 73.3 хувь, 2024 онд 70.5 хувь буюу дутуу биелсэн-Элеваторын хүчин чадлын хязгаарлалтаас шалтгаалсан;
- Нийт авлага 2023 онд 213.9 тэрбум төгрөг, 2024 онд 194.2 тэрбум төгрөг, үүнээс ердөө 11.8 хувийг барагдуулах төлөвлөгөөтэй-Ажиллах хүч, төлөвлөлт уялдаагүй;
- Нийт өглөг 226.0 тэрбум төгрөг, үүнээс БНХАУ, БНБУ, "Ди Би Эм лизинг" ХХК-ийн лизингийн зээл төлөлт үргэлжилж байгаа;
- ХАА-г дэмжих 174.9 тэрбум төгрөгийн 8,523 зээлийн 80.4 хувь хугацаа хэтэрсэн, санхүүгийн сахилга, зээлийн хяналт сул;
- 65.8 тэрбум төгрөгийн 654 зээлдэгчийн мэдээллийг Монголбанканд бүртгээгүй, чанаргүй зээл өсөх эрсдэл өндөр хэвээр байна.

Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)-Эрх зүйн нийцэл, хяналтын дутагдалтай байдал илэрсэн. Тухайлбал:



- Баталсан зарим журмыг хууль зүйн төв байгууллагаар хянуулаагүйгээр шууд мөрдсөн-хууль ёсны хүчин төгөлдөр байдал бүрэн баталгаажаагүй;
- Улсын бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээлэл шинэчлэгдээгүй;
- СЗХ-ны баталсан хяналтын журмын дагуу 2023-2024 онд ЗБДС-гийн үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй;
- АХБ-ны санхүүжилттэй дамжуулсан зээлийн нийт үлдэгдэл 116.0 тэрбум бөгөөд 6.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд;
- ЗБДС нь ХХААХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд нийцэхгүй салбарт батлан даалт гаргасан тохиолдол бүртгэгдсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 35.2 тэрбум төгрөгийн 82 зээлдэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, нийт 148.6 тэрбум төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлагын холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад 1 зөвлөмж, Санхүүгийн зохицуулах хорооны даргад 1 зөвлөмж, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яаманд 3 зөвлөмж, Жижиг, дунд үйлдвэрийн газарт 4 зөвлөмж, "Хөдөө аж ахуйн корпорац" ТӨХХК-ийн гүйцэтгэх захиралд 4 зөвлөмж, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захиралд 3 зөвлөмж, нийт 14 зөвлөмжийг хүргүүлсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРААС БУСАД САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Аудитаар гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, мэдээллийн ил тод байдал, өрийн эрсдэлийн үнэлгээ зэрэг бүх шатанд системийн доголдол байгааг тогтоов. Төслүүдийн ихэнх нь улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх зорилтуудтай уялдаагүй, үр нөлөөг урьдчилан тооцсон судалгаанд тулгуурлаагүйгээр гэрээ хэлэлцээр байгуулагдаж УИХ-аар батлагдсан байна.

Гол шалтгаан нь зээлийн шалгуур, шаардлагыг хангаагүй төслүүдэд гадаад зээлийн хөрөнгө зарцуулсан нь төслийн үр ашиггүй байдал, хугацаа хэтрэлт, төсвийн ачаалал нэмэгдэх бодит эрсдэлийг үүсгэжээ.



Гадаад зээлийн хүрээнд батлагдсан 89 төслийн 14.7 их наяд төгрөгийн хөрөнгө ашиглаагүй байршиж байгаа нь хүлээсэн үр дүн гарахгүй хоцрох, эдийн засгийн өсөлтийг дэмжих, зардлын үр ашиг буурах, ашиглаагүй үлдэгдэлд хураамж төлөх замаар төсөвт үргүй зардал гарч байгааг харуулж байна. Засгийн газрын гадаад зээлтэй холбоотой бодлого тодорхойгүй, зээлийн зохистой харьцаа, хязгаарлалтыг тогтоогоогүйгээс хөрөнгийг улсын тэргүүлэх чиглэл бус, үр нөлөө багатай арга хэмжээнд зарцуулсан тохиолдол олон байна.

Мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, хэрэгжүүлэгч байгууллагууд хооронд уялдаа сул, зээл, тусламжийн талаарх мэдээлэл ил тод биш, нэгдсэн цахим орчинд бүрэн байршаагүй байна. Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 158 төсөл, арга хэмжээнд 11.0 их наяд төгрөг зарцуулсан боловч тэдгээрийн нийгэм, эдийн засагт үзүүлсэн бодит үр нөлөөг тооцож үнэлээгүй, олон нийтэд мэдээлээгүй байна.

Зээлийн эргэн төлөлт нь улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг судалгаа, нарийвчилсан тооцооллоор үнэлээгүй нь ирээдүйд өрийн дарамт нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна. Цаашид гадаадын зээлийн бодлогыг тодорхой болгож, төслийн сонголтыг стратегийн ач холбогдол, бодит хэрэгцээнд тулгуурлах, хэрэгжилт үр нөлөөг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болсон байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 1 асуудлыг толилуулж, Ерөнхий сайдад 2, Тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-д 1, Сангийн сайдад 6, ТЕЗ нарт 4 зөвлөмж, 66,500.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага өгсөн байна.



“УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮР НӨЛӨӨ” (ТХЗ-2030"-ЫН 6.1)

Аудитаар илэрсэн зүйлс болон анхаарал хандуулах дараах асуудал байгааг тогтоож “Хүн амыг эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах бодлогын үр нөлөөг үнэлж чадахгүй байна” гэж дүгнэсэн. Тухайлбал:

- Хүн амыг эрүүл аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зорилтын суурь үзүүлэлт “Эрүүл, аюулгүй ундны ус” гэсэн микробиологийн, химийн чанарын шалгуур тусгагдаагүй тул урт хугацааны бодлогын зорилтын чанарын хэрэгжилт үнэлэгдэхгүй, ТХЗ 6.1, 6.2-ын шаардлагыг хангаагүй;
- Нийт сумдын 71 хувьд нь усны нөөц тогтоогдоогүй, 77 хувь нь цэвэрлэх байгууламжгүй;
- Хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг 21 аймаг, 330 сумдад бүрэн хийгээгүй нь төсөв болон хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалсан;
- Малчин өрхийн хэдэн хувийг эрүүл аюулгүй ундны усны эх үүсвэрээр хангах бодлого тодорхойгүй, хүн амын эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг нэгтгэн хянаж, тайлагнах чиг үүрэг бүхий төрийн байгууллага тодорхойгүй;
- Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжаар ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой 1.9 их наяд төгрөг зарцуулсан ч бодлогын хэрэгжилтийн ахиц тодорхойгүй;
- Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, өгөгдлийн сан бүрдүүлэлт хангалтгүй, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт ус, ариун цэврийн байгууламжийг зөв, зохистой ашиглах талаар тусгаагүй байна.

Мөн аудитын хүрээнд нийслэл, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд иргэдийн эрүүл аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа ч бодлогын зорилтод түвшинд хэрхэн нөлөөлж байгааг уялдуулан дүгнэх тогтолцоо бий болоогүй байгааг тогтоосон. Үүнд:

- Нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичигт ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой үндсэн зорилтыг тусгаагүй, нийслэлийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилт болон усны чанарын шаардлага хангалтгүй;
- Ус суваг, удирдлагын газрын хариуцдаг Налайх, Дүнжингарав, Монос, Нисэх, Ханын материал зэрэг бохир ус тээвэрлэх таван цэгт хяналт, зохицуулалт хангалтгүй байгаа нь төв цэвэрлэх байгууламжид стандартын шаардлага хангаагүй бохир ус нийлүүлэх эрсдэлийг бий болгосон;
- Улаанбаатар хотын хэмжээнд ус бохирдуулагч үйлдвэрүүдийн 70 хувь нь урьдчилан цэвэрлэх байгууламжгүй, хууль, стандартын шаардлага хангахгүй, мөн хот суурин газруудын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг холбогдох хууль, журам, стандартын дагуу тогтоогоогүй;
- Нийслэл, аймаг, сумдын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтад авсан нэгдсэн судалгаа, дүн мэдээ хангалтгүй байна. Орон нутгийн төрийн

байгууллагуудын уялдаа, холбоо сул, аймаг, сумдын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлуулж, Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний акт болж албажуулсан мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгээгүй, газар зохион байгуулалтын төлөвлөлт хийхдээ ундны усны эх үүсвэрийн хязгаарлалтын болон эрүүл ахуйн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар олгох, барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон;

- Малчин өрх эрүүл ахуйн наад захын шаардлага хангасан эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдахгүй байна.

Аудитын дүнд илэрсэн зөрчлийг арилгуулах 5 албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлж, Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий Сайдад 13 зөвлөмж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Сайдад 4 зөвлөмж, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын Сайдад 3 зөвлөмж, Эрүүл мэндийн Сайдад 2 зөвлөмж, Боловсролын Сайдад 1 зөвлөмж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдад 4 зөвлөмж, нийт 27 зөвлөмжийг өгсөн байна.



АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14.7 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитын дүнд үндэслэн "Төрийн байгууллагууд ахмадын сан ажиллуулах хуулиар хүлээсэн үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна" гэсэн дүгнэлтэд хүрч, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2, Сангийн яаманд 1 нийт 3 зөвлөмж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээнд сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр 66.7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, ахмадын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 9.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэх 3 төлбөрийн акт тогтоосон байна.

Аудитын тайланг 2025 оны А/133 "Аудитын тайлан баталгаажуулах тухай" тушаалаар тайланг баталгаажуулан Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.



ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитын дүнд үндэслэн "Гамшгаас хамгаалах тогтолцоо бүрдсэн ч салбар дундын уялдаа холбоо хангалтгүй, хөрөнгө оруулалт дутагдалтайгаас гамшигт бэлэн биш байна" гэсэн дүгнэлт өгч, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хуралд 1, Монгол Улсын Ерөнхий сайдад 2, Шадар сайдад 13, Боловсролын сайдад 2, Эрүүл мэндийн сайдад 1, Онцгой байдлын ерөнхий газарт 11 нийт 30 зөвлөмж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байх 6 албан шаардлага өгсөн байна.

ТӨРӨӨС АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны даргад 2, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд 9 нийт 11 зөвлөмж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар нийт 8 тэрбум төгрөгийн 4 албан шаардлага өгч, 281.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон байна. Аудитын тайланг тушаалаар баталгаажуулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд тус тус хүргүүлэв.



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО БОЛОН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Аудитын дүнд үндэслэн "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын цахим тогтолцоо бүрдээгүй, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна" гэсэн дүгнэлт өгч, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газарт 2, Эрүүл мэндийн болон Сангийн сайд нарт 3, Эрүүл мэндийн сайдад 13, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд 1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 15 нийт 34 зөвлөмж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар Эрүүл мэндийн яаманд 2, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмийн зөвлөлд 1, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 1, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд 1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2 нийт 7 албан шаардлага хүргүүлж, 18.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.



САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН "НЭГДҮГЭЭР ТОЙРОГ ЗАМ" ТӨСӨЛД ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА ГАРГУУЛАХ ХҮСЭЛТИЙН ДАГУУ ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 11 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 11.2.3 ДАХЬ ЗААЛТЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.2.3 дахь заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/6503 дугаар албан бичгээр ирүүлсэн Засгийн газрын өрийн баталгааг гаргуулах хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээнд аудит хийв.

Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалтад "Төрийн аудитын байгууллага өрийн удирдлагын хүрээнд энэ хуулийн 9.1.9-д заасан эрсдэлийн үнэлгээнд тухай бүр хөндлөнгийн аудит хийж, дүгнэлт гаргах" гэж заасны дагуу эрсдэлийн үнэлгээнд хийсэн аудитын дүгнэлтийг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 2070 дугаар албан бичгээр хүргүүлэв.

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийх, төлөвлөгөөт бус аудитыг хийх, нийгэм эдийн засагт ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, төсвийн тооцоолол, гэрээ хэлцэлд урьдчилсан аудит хийх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр Тусгай чиг үүргийн аудитын газрыг шинээр байгуулсан.

Төсвийн захирагчдын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах ажлын хүрээнд 81 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулав.



Баталгаажуулалтад хамрагдсан санхүүгийн тайлангийн 78.6 хувьд өөрчлөлтгүй, 21.4 хувьд хязгаарлалттай дүгнэлт өгч, чиг үүрэгт хамааралтай Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн шууд захирагчийн 53 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, аудитын илрүүлэлтийг дээд шатны захирагчийн аудитын тайланд тусгасан.

Төсвийн захирагчдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитаар нийт 41,889.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 10,579.2 сая төгрөгийн 36 алдааг залруулж, 177.8 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоож, 25,751.2 сая төгрөгийн зөрчилд 53 албан шаардлага хүргүүлэн, 5,381.0 сая төгрөгийн зөрчилд 230 зөвлөмжийг хүргүүлэв.

Гүйцэтгэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын санхүү, төсвийн зарцуулалтад хийсэн аудитын тайланг УИХ-ын Тусгай хяналтын дэд хороонд хуульд заасан хугацаанд хүргүүлэн ажиллав.

Гүйцэтгэлийн аудитаар "Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн" сэдэвт аудитыг гүйцэтгэж нийт 6,088.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 564.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 5,523.7 сая төгрөгийн 17 албан шаардлага хүргүүлж, 59 зөвлөмжийг өгсөн.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ОРОЛЦОО

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны тогтоолын дагуу "Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл" сэдэвт ерөнхий хяналтын сонсголын үйл ажиллагаанд ҮАГ-аас албан хаагчид томилогдон ажилласан.



Ерөнхий хяналтын сонсголын хүрээнд утааны эсрэг Төрийн байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хууль тогтоомж, санхүүжилт болон бодлогын хэрэгжилттэй холбогдох асуудлыг судалж, дүгнэх хянан шалгагч, шинжээч нарын ажлын даалгаварт тусгасан баримт материалыг судлан сонсголд хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, хариуцагч байгууллагуудын илтгэлийн шүүмж, дүгнэлт, шинжээчийн тайлан болон холбогдох мэдээллийг бэлтгэн ажиллажээ.

УИХ-аас "Оюу толгойн нээлттэй сонсгол" зохион байгуулахтай холбоотойгоор Хянан шалгах түр хорооны шийдвэрийн дагуу ҮАГ-ын мэргэжилтнүүд ажлын хэсэгт томилогдон архивын баримт материалыг шинжлэн судлах, нотлох баримт, тооцоо, судалгаанд тулгуурлан тайлбар тодруулга бэлтгэх, УИХ болон Засгийн газраас хэрэгжүүлсэн хяналт, шалгалтын үр дүнг үнэлэх, мэргэжлийн түвшинд үнэн бодит санал дүгнэлт боловсруулах хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

АМГТГ нь гэрээлэгчийн үйл ажиллагааны тайлан мэдээг хугацаанд нь хянаагүйгээс илэрсэн алдаа зөрчлүүд залруулагдаагүй, дараагийн жилүүдэд давтан гарсан байна.

Аудитын дүнгээс харахад өртөг нөхөгдөх зардлын тайланг ирүүлэх, холбогдох байгууллагын хяналт шалгалт хийх хугацааг журамд нарийн тогтоогоогүйгээс алдаа, зөрчил давтагдах, аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл үүссэн байна. Гэрээлэгчдийн хувьд аудитын шийдвэр, төлбөрийн актыг биелүүлэхгүй удаашруулж, өр хуримтлуулах хандлага давамгайл байгаа нь цаашид аудит үргэлжлэх боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна. Мөн Засгийн газар болон салбарын сайдын олгосон эрх хүчин төгөлдөр байгаа боловч зарим орон нутгийн шийдвэрээс шалтгаалан гэрээлэгчид үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүй болж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөлд хүрчээ.

АМГТГ өртөг нөхөгдөх зардалд хүлээн зөвшөөрөх шалгуур, зардлын бүртгэл, нөөцийн тооцооллын заавар аргачлалыг бүрэн боловсруулаагүй, зарим гэрээлэгчийн газрын тосны хөрөнгийн тайлагнал, бүртгэл тооцоог тогтоосон стандартын дагуу хянаж баталгаажуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн холбогдох шаардлагуудтай нийцээгүй байна. Тухайлбал, Петроматад ХХК-ийн хөрөнгийн шилжилт, тайлагнал СТОУС болон Газрын тосны бүртгэлийн журмын шаардлагыг зөрчсөн байна.

Мөн 2022–2023 онд хийгдсэн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын дүнг хянаж баталгаажуулаагүй, өмнөх аудитын шийдвэр, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь зөрчил давтагдах, хариуцлагын тогтолцоо сул хэвээр байгааг харуулж байна. Эдгээр асуудал нь салбарын бодлогын хэрэгжилт, гэрээний биелэлт, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн борлуулалтын зардлын хүлээн зөвшөөрөх шалгуурыг тодорхой болгох, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, орон нутгийн хууль бус үйл ажиллагааны саадыг арилгах эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх, өмнөх аудитын шийдвэрүүдийн хэрэгжилтийг бүрэн хангаж хариуцлагатай байдлыг хангуулах, газрын тосны хөрөнгийн бүртгэл, өртөг нөхөлтийн зардал, орлого төвлөрүүлэлтийн хяналтыг журмын дагуу сайжруулах, тайлангийн баримт нотолгоог иж бүрэн болгох, гэрээлэгчдийн зөрчил давтагдахгүй байх тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус зөвлөмж өгсөн байна.



ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧДИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

Аудитын явцад гэрээлэгчдийн 2023 оны өртөг нөхөгдөх зардлын тайлагналд бүтээгдэхүүн хуваах гэрээний заалтад нийцээгүй 4.9 сая ам.долларын зардлыг хасаж, 18.1 сая ам.долларын зардлыг өртөг нөхөлтөд тооцон баталгаажууллаа.

Хяналтад хамрагдсан 11 гэрээлэгчийн 12 талбайн батлагдсан төлөвлөгөө, төсөвлөсөн хөрөнгийн гүйцэтгэлийн 30 хувьд зөрчил илэрсэн нь төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, анхдагч баримтын бүрдүүлэлт дутуу, тайланг хугацаанд ирүүлдэггүй алдаа давтагдсан байна.

"Газрын тосны бүртгэл тооцооны журам"-д өөрчлөлт оруулах талаар удаа дараа зөвлөмж өгсөн хэдий ч хэрэгжээгүй бөгөөд салбарын зохицуулалтын тодорхойгүй байдал ужгирсан нь үйл ажиллагааны эрсдэлийг нэмэгдүүлж байна.

АМГТГ нь гэрээлэгчдийн үйл ажиллагааны тайлан мэдээг хугацаанд нь хянаагүйгээс алдаа, зөрчил залруулагдалгүй дараагийн жилүүдэд давтагдаж, аудитын үр нөлөө буурч, өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Энэ нь хяналтын тогтолцооны сул тал, зөрчил давтагдах нөхцөлийг бүрдүүлж, салбарын бодлогын хэрэгжилт болон гэрээний сахилга, хариуцлагад сөргөөр нөлөөлж байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Газрын тосны салбарын хяналт, зохицуулалтын механизм сул байгаагаас хайгуул, ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, зардлын тайлагналын зөрчил давтагдах, гэрээний үүргийн биелэлт алдагдах зэрэг эрсдэлүүд тогтмол үүсэж байгааг тэмдэглэсэн.

Төрийн холбогдох байгууллагын хяналтын зохицуулалтыг шинэчилж сайжруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, тайлангийн чанар, бүртгэл, тооцооны журмыг уялдуулан боловсронгуй болгох, хайгуулын ажлын доод хэмжээг удаа дараа биелүүлээгүй талбайн гэрээг цуцлах, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хариуцлагын зохицуулалтыг мөрдүүлэх шаардлагатай байна.

Ашигт малтмал, газрын тосны газар гэрээлэгчдэд нягтлан бодох бүртгэл болон хяналт шалгалтын шаардлагыг бүрэн ойлгуулах сургалт зохион байгуулах, тайлангийн анхдагч баримтыг журмын дагуу бүрдүүлэх хяналтыг сайжруулах, төлөвлөгөө болон төсвөө хугацаанд батлуулаагүй болон гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Зөрчил давтагдахгүй байх орчныг бүрдүүлэхийн тулд гэрээлэгч бүрийн үйл ажиллагааны мэдээлэл, тайланг нэгтгэсэн цахим сан бий болгож, ил тод байдал, хяналт, тайлагналын үр ашгийг нэмэгдүүлэх асуудлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус зөвлөмж өгсөн байна.



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн бодит хэрэгжилтийн түвшинд сул тал давамгай, төсвийн сахилга бат хангалтгүй, хуулийн зарим заалт тогтмол зөрчигдөж буйг тогтоож, хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна гэж дүгнэсэн.



- Төсвийн сахилга, хэмнэлтийн бодлого бүрэн хэрэгжээгүй буюу 2022–2024 онд нийт 209.4 тэрбум төгрөгийн зөрчил гарч, тэргүүн дэд, дэд, орлогч даргаар ажиллахыг хориглосон заалтыг орлуулсан нэршлээр дарга, менежерийн албан тушаал шинээр бий болгосон, хот дотор болон томиллотод автомашин ашиглахыг хориглосон заалтыг зөрчиж зардал гаргасан, төрийн өмчит болон орон нутгийн өмчит байгууллагууд цалин, урамшуулал, шагнал, тусламжийг хууль зөрчин давхардуулан олгосон.
- Хэмнэлтийн бус зардал огт буурахгүй, зарим аймагт өсөх хандлагатай буюу 2023–2024 онд 980.7 сая төгрөгийн контент, бэлэг дурсгал, нэвтрүүлэг, арга хэмжээний зардал гаргасан, орон нутгийн ТЕЗ, ЗДТГ-уудын дунд хуулиар хориглосон зарцуулалт (хөдөлмөр хамгааллын бус хувцас, арга хэмжээ, сургалтын хөтөлбөрт хамаарахгүй зардал зэрэг) нийт 730.3 сая төгрөгт хүрсэн, зарим аймагт төсвийн зориулалтын бус зардал, хандив, урамшууллын төлбөр тогтмол өссөн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хууль, стандартын шаардлага хангахгүй батлах, нийслэл болон аймгууд нийт 1.22 их наяд төгрөгийн өртөгтэй 685 төсөл нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 726.1 тэрбум төгрөгийн он дамжсан үлдэгдэлтэй байна.
- Хяналт, дотоод аудит сул, үндсэн зөрчил дахин давтагдсан буюу ТЕЗ нар хяналт, баталгаажуулалтын үүргээ биелүүлэхгүйгээс 2022–2024 онд төсвийн үлдэгдэл 969.3 тэрбум төгрөг буцааж төвлөрүүлэх нөхцөл үүссэн, ТӨБЗГ, салбарын яамд "албан өрөөний стандарт", "нийтлэг жишиг", "ашиглалтын хэм хэмжээ" зэрэг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон заалтыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, цэнхэр дугааргүй 8,863 авто тээврийн хэрэгслийн бүртгэл-хяналтын доголдлыг бүрэн шийдэгдээгүй.
- Хуулийн зорилго болох төсвийн хэмнэлт гарсан ч бодит нөлөөлөл болж чадахгүй, хэмнэлтийн бодлогын үр ашиг, зарцуулалтын ил тод байдал, хариуцлагын системд бодит нөлөө үзүүлж чадсан эсэх нь тодорхойгүй, хэмнэлтийн зорилго нь салбарын суурь хэрэгцээ, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх бодит арга хэмжээнд чиглэхгүй байна.

Аудитын дүнд үндэслэн нийт 27 зөвлөмж буюу ЭЗХЯ, Сангийн яам, БОАЖЯ, ХБОНСЯ, ЭМЯ, БШУЯ, ХХААХҮЯ зэрэг холбогдох байгууллагуудад өгсөн байна.



АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРУУДЫН 2025 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын 2025 онд гүйцэтгэсэн аудитын үр дүнг хураангуйлан тайлагнаж байна. Дэлгэрэнгүйг 5 дугаар хавсралтад харуулав.



АНТАГ-уудын аудитын гүйцэтгэлийн дүн: Аймаг, нийслэлийн түвшинд 2025 онд хэрэгжүүлсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын үр дүнгээр шалгагдагч байгууллагуудын санхүүгийн тайлагнал, НББ, дотоод хяналтын тогтолцоо, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, захиалагчийн хяналт, сангуудын удирдлага, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийтлэг шинжтэй, давтамжтай зөрчил их хэмжээгээр илэрсэн гэж тэмдэглэгдсэн байгаа нь аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагууд өмнөх аудитын шийдвэрт ач холбогдол бага өгч, аудитын мөрөөр засаж сайжруулах арга хэмжээ авах үйл ажиллагаа нь бүрэн төлөвшөөгүйтэй холбоотой байна.

Шалгагдагч байгууллагуудын санхүүгийн тайлагнал, НББ, дотоод хяналт, хөрөнгө оруулалтын удирдлага, сангийн зарцуулалт, орлогын бүрдүүлэлт зэрэг чиглэлээр илэрч буй зөрчил нь хариуцлагын чадавх сул, байгууллагын засаглал тогтолцооны түвшний доголдол давамгайлж буйг харуулж байна.

- Эдгээр доголдол нь нэгж байгууллагын түвшинд хязгаарлагдахгүйгээр орон нутгийн хэмжээнд давтагдаж, зарим тохиолдолд тогтолцооны шинжтэй алдаа болж, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, сангуудын зарцуулалт, ил тод байдал, хяналт-шинжилгээний тогтолцоо зэрэг бодлогын үндсэн үйл явцад нөлөөлж байна.
- Монгол Улсын Засгийн газрын түвшинд бодлого, зохицуулалт, удирдлага хяналтын тогтолцоог цогцоор нь сайжруулах, төсвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг бодит үр дүнтэй хэрэгжүүлэх, санхүүгийн сахилга бат, дотоод хяналтын системийг бэхжүүлэх шаардлага өндөр байгааг харуулж байна.

- ТАГ-уудын зүгээс аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг орон нутагтаа эдийн засаг, нийгмийн бодит үзүүлэлтээр хэмжих, аудитын мөрөөр авах арга хэмжээг илүү үр нөлөөтэй төлөвлөх, аудитын үр өгөөжийг иргэд, олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх зэргээр нөлөөллийн арга хэмжээгээ илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь чухал байгааг нотолсон юм.

АНТАГ-ын аудитын гүйцэтгэлээс харахад орон нутгийн засаглал, санхүүгийн удирдлага, хяналт хариуцлагын тогтолцоог бодлогын түвшинд шинэчлэх шаардлагатай юм. Аудитын үр нөлөөг тогтвортой өсгөх үндсэн нөхцөл нь аймаг, нийслэлийн төрийн байгууллагуудын албан тушаалтны чадавх, хариуцлага, үйл ажиллагааны ил тод байдлыг цогцоор сайжруулахад анхаарч ажиллах нь зүйтэй байгааг илэрхийлж байна.

АНТАГ-уудын аудитын мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа: Аймаг, нийслэл дэх ТАБ-ын хэрэгжүүлсэн санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын үр дүнгээс харахад орон нутгийн санхүүгийн тайлагнал, дотоод хяналт, хөрөнгө оруулалтын удирдлага, сангуудын зарцуулалт болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшинд нийтлэг, тогтолцооны шинжтэй доголдол илэрч байгаа нь төрийн байгууллагуудын хариуцлагын чадавхыг бэхжүүлэх шаардлага тулгамдсан хэвээр байгааг нотлон харуулж байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт олон аймагт 90–100 хувьтай биелж, төсвийн сахилга, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоог бодитоор сайжруулахуйц үр нөлөө үзүүлжээ.

Аймаг, нийслэлийн түвшний аудитын үр нөлөө нь тодорхой тоон үзүүлэлтүүдээр баталгаажиж байна. Тухайлбал, Хэнтий аймаг дахь ТАГ 2025 онд 327.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 11.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилган, нийт 10.3 тэрбум төгрөгийн бодит үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн нь аудитын зардлын өгөөжийн хувьд үр дүнтэй жишээ юм. Энэ үр дүн нь харилцагч талуудтай хийх уулзалтыг өмнөх оноос 2,6 дахин нэмэгдүүлж, тогтмол харилцаа, хамтын ажиллагааг хэвшүүлэн, зөвлөн туслах үйлчилгээ, аудитын мөрөөр тавих хяналтыг системтэй хэрэгжүүлсний бодит илэрхийлэл бөгөөд аудитын үр нөлөө, шийдвэрийн хэрэгжилт, төсвийн сахилга хариуцлага бодитоор дээшилснийг харуулж байна.

Дархан-Уул аймаг дахь ТАГ нэг жилийн хугацаанд 99.4 тэрбум төгрөгийн алдааг залруулж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 96–100 хувиар ханган ажилласан нь аудитын байгууллагын нөлөөллийн бодит үр дүнг харууллаа.

Орон нутгийн төсөв, бодлого боловсруулах түвшинд үзүүлсэн нөлөөллийн хувьд Зүүн бүсийн ТАГ-ууд 2026 оны төсвийн төсөлд аудитын зөвлөмжийг тусгуулах замаар 18.2 тэрбум төгрөгийн нэмэлт орлого, 2.27 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлтийг бодитоор бий болгосон нь аудитын дүн бодлогын уялдааг сайжруулах чиглэлд системтэй нөлөөлж буйн нотолгоо юм.

Аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудтай (ИТХ, ЗДТГ, төсөв захирагчид) тогтмол харилцаа хөгжүүлж, аудитын дүнг бодлогын түвшинд тусгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг дэмжих үр нөлөөтэй хамтын ажиллагааг өргөжүүлжээ. Тухайлбал:

- Архангай аймаг дахь ТАГ нь ИТХ-аар орон нутгийн өмчийн удирдлага, ОНХС-гийн хөрөнгийн бүртгэлийн хяналтыг сайжруулах чиглэлд 2 тогтоол батлуулсан;
- Дархан-Уул аймаг дахь ТАГ нь аймгийн ЗДТГ-тай хамтран төсөв захирагч, санхүүгийн ажилтанд зориулсан аудитын үр дүнг сайжруулах сургалт, хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулж тогтмолжуулсан;
- Баянхонгор аймаг дахь ТАГ-аас “Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилт, ОНХС-гийн зарцуулалтад хийсэн аудитын үр дүнг бодлогын түвшинд хэрэгжүүлэх шийдвэрүүдийг гаргуулсан зэрэг сайн туршлагауд бүртгэгдсэн, “Хууль эрх зүйн зөвлөгөө авах маягт”-ыг зохион ашигласнаар зөвлөгөө авах үйл явц эмх цэгцтэй, баримт нотолгоонд суурилсан болж, аудитын шийдвэрийн үндэслэлтэй байдал хангагдахад чухал ач холбогдолтой болсон.

Иргэд, олон нийтэд аудитын үр дүнг ойлгомжтой, хялбар, хүртээмжтэй хүргэх шинэ арга хэлбэрүүд нэвтрэн хөгжиж байна. Үүнд:

- Өвөрхангай аймаг дахь ТАГ-аас аудитын явц, үйл ажиллагааны талаар Audit.mn цахим сайт, “Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар” фейсбүүк хуудас, UNN.mn видео сайт болон сайтын фейсбүүк хуудсаар дамжуулан 4 контент, 165 хураангуй тайлан, 8 визуал тайлан, 185 цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол иргэд, олон нийтэд түгээж ажилласан.
- Дорнод аймаг дахь ТАГ-аас аудитыг цахим хэлбэрээр танилцуулан давхардсан тоогоор нийт 307,918 хандалт авсан нь аудитын ил тод байдлыг нэмэгдүүлсэн байна.

Эдгээр тоон үр дүн, сайн туршлага, хамтын ажиллагаа нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа орон нутгийн бодлого, төсөв, хөрөнгө оруулалтын удирдлагад бодит нөлөөлөл үзүүлж байгаа хэрэг юм. Онцлох сайн туршлагын тухайд хөрөнгө оруулалтын гэрээ, тендерийн үе шатны төсөвт өртгийг хяналтын буюу баталгаажсан төсөвтэй харьцуулан шалгах боломж бүрдэж, эхний үе шатны санхүүжилтийн үнэн зөв байдал сайжруулсан байна. Үүний үр дүнд төсөл, арга хэмжээний эхний үе шатанд нэгж өртгийн хяналтаар баталгаажуулаагүй илүү санхүүжилт олгох эрсдэл арилж, гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналт бодитоор олгогдох нөхцөлийг бүрдүүлжээ.

Аудитын эрсдэлийн санг бүрдүүлэх, баримтжуулах чанарыг сайжруулах хүрээнд зохиомжийн бүтэц, форматын шинэчлэлийг хийж, нотлох баримтыг үнэлэх шалгах хуудас, дүн шинжилгээний баримтжуулалтын загваруудыг боловсруулан хэрэгжүүлж, практикт ашиглах нөхцөлийг бүрдүүлжээ. Аудитын эрсдэлийг системтэй үнэлэх, нотолгооны чанар, бүрдлийг хангах, шийдвэр гаргалтын суурийг оновчтой болгоход чухал үр нөлөө үзүүлэх юм.

Аудитын нөлөөлөл зөвхөн зөрчил илрүүлэх, шийдвэр гаргах хүрээнд хязгаарлагдахгүй, харин орон нутгийн засаглал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогын үр нөлөөг үнэлэх шинэ соёлыг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН АУДИТЫГ
ДЭМЖИХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА



ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Чанарын удирдлага: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны чанарыг тогтвортой сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодит арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлж, бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээний уялдааг хангахад анхаарч ажиллалаа. Энэ хүрээнд эхний ээлжид чанарын удирдлагын тогтолцоог олон улсын стандарттай нийцүүлэх, аудитын түвшний болон тогтолцооны чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх ажлуудыг төвлөрүүлэн зохион байгуулсан юм.

Чанарын удирдлагын эрх зүйн болон арга зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд АДБОУС 140-ийг Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж, стандартыг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж эхэлсэн. Мөн хэрэгцээ шаардлагын үнэлгээ, олон улсын зөвлөмжид тулгуурлан боловсруулсан "Чанарын удирдлага, эрсдэлийн бодлого", "Чанарын зорилгыг 2026–2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/148 дүгээр тушаалаар баталсан нь чанарын удирдлагын тогтолцоог системийн түвшинд тогтоох суурь нөхцөл болов.

Эрсдэлийн удирдлага: Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг системтэй төлөвшүүлэх шаардлагатайг үндэслэн эрсдэлийн удирдлагын баримт бичгийг боловсруулах, сайжруулах ажлыг шат дараатай хэрэгжүүлсэн. Энэхүү ажлыг АДБОУБ-ын Хөгжлийн санаачилгаас хэрэгжүүлж буй "CRISP" хөтөлбөрийн амлалтын хүрээнд гүйцэтгэж, байгууллагын онцлог, өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн баримт бичгийн төслийг боловсрууллаа.

"CRISP" хөтөлбөрийн хүрээнд хийсэн эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээ, гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний үр дүн нь Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бодлогын түвшинд шинэчлэн төлөвшүүлэх шаардлагыг тодорхой харууллаа. Үнэлгээгээр эрсдэлийн удирдлагын үйл явц байгууллагын хэмжээнд жигд хэрэгжихгүй, баримт бичиг, арга зүйн хувьд нэг мөр болгох хэрэгцээ байгааг тогтоогоод байна.





Судалгааны дүн, дүгнэлтэд үндэслэн "Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийн төсөл"-д үе шаттай сайжруулалт хийж, олон шатны санал авах, CRISP хөтөлбөрийн зөвлөмжтэй уялдуулах ажлыг зохион байгуулсан.

Эдгээр зөвлөмж, бодлогын шинжтэй ажлууд нь эрсдэлийн удирдлагыг нэг удаагийн үнэлгээ бус, тасралтгүй үйл явц болгон төлөвшүүлэх, улмаар аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтүнэлгээтэй уялдуулах стратегийн ач холбогдолтой бөгөөд эрсдэлийн удирдлага нь байгууллагын дотоод засаглал, аудитын чанар, нөлөөллийг нэмэгдүүлэх бодлогын чухал хэрэгсэл болж байна.

Чанарын баталгаажуулалт ба хяналт, үнэлгээ: Уг чиг үүргийн хүрээнд аудитын түвшинд санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитад чанарын хяналт хийж, санхүүгийн аудитын чиглэлээр ҮАГ-ын нэгжүүдэд 39, АНТАГ-т 26, аудитын хуулийн этгээдүүдэд 44 зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын чиглэлээр ҮАГ-ын нэгжүүдэд 11, АНТАГ-т 22 зөвлөмж тус тус хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна. Түүнчлэн аудитын 6 хуулийн этгээдэд нэгтгэсэн тайлангаар 36 зөвлөмж өгсөн бөгөөд тогтолцооны түвшинд албан хаагчдын чадамжийн хүрээний хэрэгжилтэд чанарын баталгаажуулалт хийлээ.

Гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ: ТАБ болон зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/19-р тушаалаар батлуулсан бол 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний ТАБ-ын 158, ЗББН-ийн 1,191 арга хэмжээний гүйцэтгэл-тайлагналын түвшинд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилттэй холбоотойгоор анхаарах асуудлыг зөвлөмжөөр хүргүүлэн биелэлтийг хангуулав.

АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

Төрийн аудитын байгууллагын өнөөгийн нөхцөл шаардлагыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүтцэд үндсэн чиг үүрэг болон үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийн тогтолцоог эрх зүй, дүн шинжилгээ, судалгааны үндсэн дээр хөгжүүлэх, дэмжих нэгжийн үйл ажиллагааг эхлүүлээ.

Тайлант онд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянах тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд гүйцэтгэл, нийцлийн аудитын шийдвэрийг бүртгэх цахим бүртгэлийн системийг шинээр зохиомжилж, ашиглалтад оруулснаар шийдвэрийн бүртгэл, хэрэгжилт, үлдэгдлийг нэгдсэн байдлаар хянах, хугацаа хэтэрсэн шийдвэрийг эрт илрүүлэх, нөлөөллийг бодит өгөгдөлд суурилан боловсруулах боломжийг бүрдүүлээ.



Үүнтэй уялдуулан аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангахтай холбоотой журам, зааврыг баталж мөрдүүлснээр хяналт, үнэлгээ нь нэг удаагийн тайлагналын шинжээс гарч тасралтгүй, системтэй хэрэгжих үйл ажиллагаа болон төлөвшиж байна.

Аудитын хэрэгжилтийн түвшин, нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаа:

Түүнчлэн Төрийн аудитын тухай хуулиар аудитын шийдвэрийн үр нөлөө, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг үнэлж тайлагнах үүргийг хэрэгжүүлэх хүрээнд аудитын шийдвэрийн санхүүгийн болон санхүүгийн бус нөлөөллийг тодорхойлох, бодит жишээнд тулгуурлан үнэлэх, мэдээлэл цуглуулах, нэгтгэх ажлуудыг зохион байгуулж эхлүүлээд байна. Ингэснээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн тоон биелэлтээр бус, нийгэм, төрийн санхүү, хариуцлагын тогтолцоонд авчирч буй бодит өөрчлөлтөөр хэмжих хяналтүнэлгээний арга замаар нөлөөллийг үнэлж тайлагнах ажлыг шинэ шатанд гаргахаар зорьж байна.

Хугацаа хэтэрсэн шийдвэрийн тайлбарыг авч нэгтгэн 3182 шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хугацаатай 22 албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, 31 албан бичгийг ТЕЗ нарт, 63 албан бичгийг ТТЗ, ТШЗ нарт тус тус хүргүүлж, хариу ирүүлсэн нотлох баримтыг үнэлж ажиллав.

Төрийн аудитын байгууллагаас 2022–2025 оны хооронд хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлын дэлгэрэнгүй судалгааг нэгтгэж 117 албан бичгээр шилжүүлсэн 134.5 тэрбум төгрөгийн 249 зөрчлийн мэдээллийн сан, бааз үүсгээд байна.

Хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлуудын шийдвэрлэгдсэн байдлыг авч үзвэл нийт 51 албан бичгээр шилжүүлсэн 44.5 тэрбум төгрөгийн 111 зөрчил

мөрдөн шалгах ажиллагаанд, 30 албан бичгээр шилжүүлсэн 65.5 тэрбум төгрөгийн асуудлыг эрүүгийн хэрэг нээхээс татгалзсан болон хэрэгсэхгүй болсон, 8 албан бичгээр шилжүүлсэн 0.6 тэрбум төгрөгийн асуудлыг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Төрийн байгууллагын хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд төрийн аудитын оруулж буй хувь нэмрийг үнэлэх зорилгоор сахилгын шийтгэл, хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийн биелэлтэд дүн шинжилгээ хийсэн байна.

Гүйцэтгэлийн аудит болон бодлогын түвшинд хийсэн бусад аудитын шийдвэр нь төрийн үйлчилгээний чанар, тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, хүрээлэн буй орчны тогтвортой байдал, нийгмийн хүртээмж, эдийн засгийн хөгжилд ямар эерэг өөрчлөлт авчирч байгааг тодорхойлох, мөн төсвийн хэмнэлт, орлогын өсөлтөөр аудитын нөлөөллийг хэмжих суурь үнэлгээг хийж байна.

Аудитын шийдвэртэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх:

Аудитын шийдвэртэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг нэгдсэн бүртгэлийн сан үүсгэн, Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2024 болон 2025 оны эхний хагас жилийн мэдээллийг нэгтгэн Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын бүртгэл, мэдээллийн санд бүртгэн авч ажиллалаа. Ингэснээр өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэхдээ тэдгээрийн агуулга, хууль зүйн үндэслэлийг ангилан ялгаж, цаашид хянан шийдвэрлэх суурь өгөгдлийг бүрдүүлсэн юм.

Цаашид аудитын шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн биелэлтийн тоогоор бус, санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж, төрийн байгууллагын хариуцлага, сахилга бат, төрийн үйлчилгээний чанарт гарсан бодит өөрчлөлтөөр үнэлэх чиглэлд ажлуудыг хийж хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон баримтлах бодлогын чиглэлд тусган ажиллаж байна.



Энэ нь төсвийн сахилга бат, хууль ёсны байдлыг хангахад бодит ахиц гаргахад дэмжлэг болж нийгэмд чиглэсэн эерэг өөрчлөлт бий болгож буйг харуулах нотолгоо, нөлөөллийг илүү бодитой үнэлэх үндэслэл болж байна.

ДОТООД АУДИТЫН ҮР ДҮН

Дотоод аудитын хэрэгжилт: Төрийн аудитын байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, дотоод аудитын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хандлагаар зохион байгуулж, байгууллагын гүйцэтгэл, дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд үнэлгээ хийж ажиллалаа. Дотоод аудитын газар нь дотоод аудитын олон улсын стандарт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан нийт 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Аймаг дахь ТАГ-уудад хийсэн дотоод аудитын үнэлгээ: Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн баталгаажуулах болон давтан баталгаажуулах дотоод аудитаар Хэнтий (94.1 хувь), Увс (91.05 хувь), Дорнод (83.9 хувь), Дорноговь (80.0 хувь), Өмнөговь (73.1 хувь), Баян-Өлгий (78.32 хувь) аймаг дахь Төрийн аудитын газруудын үйл ажиллагаанд иж бүрэн үнэлгээ өгсөн байна. Дотоод аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, зөвлөн туслах ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.

Өмнөх жилийн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ: 2021–2024 онуудад хийгдсэн дотоод аудитын тайлангаар өгсөн 215 зөвлөмжийг (22 ТАГ) нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд 87.6 хувийн гүйцэтгэлтэй буюу "хангалттай" гэсэн дүгнэлт гаргасан байна. Энэхүү дүн шинжилгээ нь дотоод аудитын зөвлөмж бодитоор хэрэгжиж, байгууллагын үйл ажиллагаанд ахиц гарч буй эсэхийг үнэлэх суурь мэдээлэл болж байна.

Шилэн дансны мэдээлэлд хийсэн бодит цагийн аудит: ҮАГ-ын Дотоод аудитын нэгжид чиглэл болгосны дагуу аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээнд шилэн дансны цахим мэдээлэлд бодит цагийн аудит гүйцэтгэж, нийт 3,933 мэдээлэлд үнэлгээ хийхэд ил тод байдлын хэрэгжилт 86.7 хувь буюу "хангалттай" гэж дүгнэсэн боловч "ерөнхий мэдээлэл" дэд ангилал 63.8 хувь буюу "сайжруулалт хэрэгтэй" гэсэн үнэлгээ авчээ. Уг хяналт-шинжилгээний үр дүнд 4 дүгнэлт, 5 зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн байна.

Дотоод аудитын зөвлөмж, үр дүн: Дотоод аудитын хүрээнд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийт 55 зөвлөмж өгч, хэрэгжилтийг уялдуулан хянаснаар дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бодитоор сайжруулахад тодорхой ахиц гаргалаа. Дотоод аудит, үйл ажиллагааг төлөвлөхдөө эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан нөөцийг төвлөрүүлж, хяналтыг өндөр эрсдэлтэй чиглэл, нэгжүүдэд чиглүүлсэн нь аудитын үр дүнг бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал алхам болов.

Ингэснээр дотоод аудитын зөвлөмж нь тайлангийн баримт бичигт үлдэх бус, байгууллагын дотоод хяналт, сахилга хариуцлагын тогтолцоонд бодит сайжрал авчрах, үр дүнг чанарын удирдлага, эрсдэлийн үнэлгээнд ашигласнаар аудитын байгууллагын дотоод хяналтын тогтолцоо илүү уялдаатай, өгөгдөлд суурилсан байдлаар хэрэгжиж байна.

ДИЖИТАЛ ШИЙДЭЛ, ӨГӨГДӨЛ АШИГЛАЛТ

Аудитын үйл ажиллагаанд технологи, өгөгдөл ашиглалт: Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаанд өгөгдөлд суурилсан хандлага бодитойгоор төлөвшиж, аудитын сэдэв тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хянах, тайлагнах үе шатанд цахим систем, өгөгдлийн багц тогтмол ашиглагдах нөхцөл бүрдүүлэх зорилгыг агуулсан юм.



Аудитын үндсэн өгөгдөл нь Санхүүгийн тайлангийн аудитын систем (FAS), Аудитын сэдэв сонголтын систем, Статистик мэдээний систем, Хяналт-шинжилгээ, үнэлгээний систем (мониторингийн модуль)-д бүртгэгдэж, аудитын тайлан, шийдвэр, алдаа зөрчил, хэрэгжилтийн мэдээллийг нэгдсэн хэлбэрээр боловсруулах боломжийг эрэлхийлж байна.

Тоон үр дүнгээр авч үзвэл:

- FAS системд 7,076 байгууллага, 13,176 хэрэглэгч бүртгэлтэй;
- 15,090 аудитын тайлан, 66,799 аудитын шийдвэр системд хуримтлагдсан;
- Статистик мэдээний 27 маягт, 10 бүртгэлийн маягтыг цахимаар нэгтгэн тайлагнах;
- Аудитын сэдэв сонголтоор иргэд, олон нийтээс 100 санал цахимаар хүлээн авсан;
- Аудитын үйл ажиллагаа баримтад суурилсан биш, өгөгдөлд суурилсан хэлбэрт бодитойгоор шилжүүлэх алхмуудыг гүйцэтгэж, аудитын шийдвэр гаргалтад ашиглах өгөгдлийн санг тоон болон чанарын хувьд тэлэх бодлого хэрэгжүүлсэн;
- Аудитын сэдэв сонголтыг иргэд, олон нийтийн саналаар өгөгдөл цуглуулж, системд ангилан, эрэмбэлэх хэлбэрт шилжүүлснээр аудитын төлөвлөлтийн ил тод байдал, нотолгоонд суурилсан чанар сайжирсан байна.

ДИЖИТАЛ АУДИТЫН ХЭРЭГЦЭЭ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Төрийн аудитын байгууллагын хувьд аудитын объект, шалгагдах өгөгдлийн хэмжээ нэмэгдэж, аудитын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг богино хугацаанд үр нөлөөтэй гүйцэтгэх шаардлага өсөн нэмэгдэж байгаатай уялдан дижитал аудит нь зайлшгүй чухал чиглэл болж байна.



Тайлант хугацаанд мэдээлэл технологийн үйл ажиллагаанд гарсан ахиц, тулгамдсан асуудал, өгөгдлийн удирдлагын өнөөгийн байдал, дижитал аудитын хэрэгцээнд хийсэн үнэлгээнд үндэслэн Төрийн аудитын байгууллагын Мэдээлэл технологийн бодлого (2026–2030 он)-ыг боловсруулаа.

Уг бодлогын баримт бичгийг боловсруулахдаа АДБОУБ-ын Хөгжлийн санаачилгын рiCTure хөтөлбөрт хамрагдаж, 5 удаагийн сургалт, чиглүүлэг, 5 шалгуурт суурилсан дижитал төлөвшлийн үнэлгээг гүйцэтгэж, олон улсын чиг хандлага, байгууллагын 2025–2030 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан дотоод нөхцөл байдалд суурилсан дүн шинжилгээг ашигласан болно.

Мэдээлэл технологийн бодлого (2026–2030 он)-д:

- Тэргүүлэх 3 чиглэл 3;
- Стратегийн 10 зорилт;
- Хэрэгжүүлэх 27 арга хэмжээг тусгаж, аудитын үйл ажиллагааг өгөгдөлд суурилсан, дижитал хэлбэрт үе шаттай шилжүүлэх зорилтыг тодорхойлов.

Уг бодлогын баримт бичгийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий аудиторын А/118 дугаар тушаалаар баталж, 2026 оноос хэрэгжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын суурийг бүрдүүлж ажилласнаар мэдээлэл технологийн үйл ажиллагаанд бодит ахиц дэвшил гарч 2025 онд мэдээлэл технологийн үйл ажиллагаа нь бодлогын хувьд зөвхөн систем хөгжүүлэлтээс илүүтэй аудитын хөгжилд чиглэсэн алсын хараатай бодлогыг хэрэгжүүлэх зорилт, төлөвлөгөөтэй стратегийн түвшинд шилжсэн юм.

Судалгаа, дүн шинжилгээний хэрэгслүүдийн хэрэглээ: Төрийн аудитын байгууллагын засаглах үйл ажиллагаа, аудитын удирдлага, төлөвлөлт, тайлагналын үе шатны ажлыг дэмжих зорилгоор Microsoft Power BI болон холбогдох дүн шинжилгээний хэрэгслүүдийг туршилтаар ашиглаж эхэлсэн нь өнгөрөгч тайлант хугацааны онцлог ажил байлаа.



Байгууллагын хэмжээнд Microsoft Power BI-ийн:

- 11 стандарт лиценз,
- 1 Power BI Pro лиценз,

Аудитын статистик, гүйцэтгэл, төлөвлөлтийн өгөгдөлд суурилсан удирдлагын хяналтын самбар боловсруулж, ашиглах эхлэл тавигдсан.

Microsoftын үнэлгээгээр:

- Хэрэглэгчийн чадвар – 249/600 оноо,
- Технологийн чадвар – 140/200 оноо,
- Нийт ашиглалтын түвшин – 41 хувь байна.

Системийн хэмжээнд 2025 оны байдлаар 11 мэдээллийн систем ашиглагдаж байгаа бөгөөд үүнээс 7 систем (63.6 хувь) нь дотоод хөгжүүлэлт, 2 систем (18.2 хувь) нь гэрээт, 2 систем (18.2 хувь) нь лицензийн хэлбэртэй байна. Энэ нь аудитын болон дэмжих чиг үүргийг цахим хэлбэрт шилжүүлэх техникийн суурь бүрдсэн болохыг харуулах юм.

Төрийн аудитын байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Кибер аюулгүй байдлын хууль болон холбогдох дүрэм, журам, Олон улсын стандартад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргуулах, холбогдох эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хөндлөнгийн "СЕКЬЮРЗОН" ХХК-иар аудит хийлгэн өгсөн зөвлөмжийг 2026 онд үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХАРИЛЦАГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА



Төрийн бодлого, үйл ажиллагаа нийтийн ашиг сонирхлын төлөө хэрэгжиж, улсын болон орон нутгийн төсөв, сан, төрийн өмчийг иргэд олон нийтийн амьдралыг дээшлүүлэхэд зарцуулж байгаа эсэх талаар үнэн зөв, ил тод хариулт хүссэн нийгмийн хүлээлтэд нийцүүлэн стратегийн хэрэгжилт, ил тод байдлыг хангах гол баримт бичиг болох "Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцоог хангах бодлогын баримт бичиг (2026–2030)"-ийг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалаар шинэчлэн баталлаа.

Төрийн аудитын байгууллага 2019–2023 онд "Харилцагч талуудын оролцооны стратеги" болон "Иргэдийн оролцоог хангах стратеги" төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн нэгдсэн системтэй, бодлогын түвшинд зохицуулах, хоёр талт харилцааны түвшинд шилжих зорилтын хүрээнд бодлогын баримт бичгээ шинэчлэн боловсруулсан юм.

Төрийн аудитын байгууллага нь хууль тогтоомжийн дагуу төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ харилцагч талуудтай идэвхтэй, хоёр талын нээлттэй, ил тод харилцаанд суурилсан тогтвортой хамтын ажиллагааг үр нөлөөтэй байлгах замаар төрийн аудитын байгууллагад итгэх итгэлийг бэхжүүлэхэд чиглэж байна.




Монгол Улсын Их Хурал, Засгийн газартай харилцах харилцаа: Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, ЗГХЭГ болон холбогдох яамдад Төрийн аудитын аудитын байгууллагаас мэдээлэл, тодруулга өгөх, аудитын үр дүнг тайлагнах, бодлогын санал, дүгнэлт, толилуулга хүргүүлэх зэрэг харилцааны хэлбэрээр ажиллаж байна.

Аудитын дүн, тайлан, мэдээлэл танилцуулах: УИХ-ын байнгын болон дэд хорооны түвшний хуралдаанд аудитын дүгнэлт, гол эрсдэл, зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийг танилцуулж, холбогдох асуултад тайлбар өгч оролцов.

Мэдээлэл солилцох, тодруулга хийх харилцаа: Цаг тухайд нь ирүүлсэн хууль, бодлогын баримт бичигт санал өгөх, тодруулгаар хангах, мэдээлэл солилцох хэлбэрээр холбогдох байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцож, шаардлагатай тодруулгыг ажилласан.

Шалгагдагч байгууллагуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагаа:

Төрийн аудитын байгууллагаас ялангуяа шалгагдагч байгууллагуудтай харилцах хамтын ажиллагааны хүрээнд аудитын үр дүн, зөвлөмжийг удирдлагад нь танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих, тайлбар, зөвлөмж өгөх ажлыг тогтмол зохион байгууллаа. Тайлант хугацаанд албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, шалгагдагч байгууллагуудтай харилцах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан байна.



Уулзалт, зөвлөлдөх харилцаа: Аудитын нээлт, талбарын үйл явцад анхаарах асуудал үргэлжлэх болон тайлагнах үе шатанд хэрэгжүүлэх горимын талаар мэдээлэл өгөх, удирдлагын захидал илгээх, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзалт зохион байгуулах, аудитын хамрах хүрээ, эрсдэл, илэрсэн алдааны талаар зөвлөлдөж, тодорхой асуудлыг газар дээр нь шийдвэрлэн ажиллав.

Мэдээлэл солилцох, техникийн дэмжлэг үзүүлэх харилцаа: Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын мэдээллийн чанар болон дотоод хяналтын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлаар шалгагдагч байгууллагуудад мэдээлэл өгөх, шаардлагатай асуудлаар хариу санал, зөвлөмж хүргүүлэх, аудитын стандартын талаарх загвар, арга зүйг тогтмол солилцож дэмжлэг үзүүлж ажилласан байна.

Асуудлыг шийдвэрлэсэн байдал: Илэрсэн асуудлаар бүртгэл хөтөлж танилцуулах, аудитад гаргах тайлбар, нотолгоо дутуу баримт материалыг бүрдүүлэх, хэрэгжилт хоцорсон зөвлөмжүүдийг байгууллагатай хамтран дахин хянаж, засвар хийлгэн баталгаажуулсны үндсэн дээр асуудлыг шат дараатайгаар хааж, хэрэгжилтийн сахилгыг сайжруулан ажиллав.

Шалгагдагч байгууллагуудтай харилцах хамтын ажиллагаа нь мэдээлэл, нотолгооны чанарыг сайжруулж, зөрчил арилгах, зөвлөмжийн хэрэгжилтийг бодит ахицтайгаар нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнд чиглэсэн үйл явц байв.

Олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцаа: Төрийн аудитын байгууллага олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж, аудитын тайлан, бодлого, үйл ажиллагааны мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэхэд анхаарч ажиллав.

Төрийн аудитын байгууллагын цахим хуудас (audit.mn), аудитын тайлангийн нээлттэй портал (open.audit.mn) сайтыг нэгтгэн шинэчлэлт хийж, үйл ажиллагааны үр дүн, аудитын тайлан, аудитын шийдвэр, үр дүнгийн мэдээлэл, УИХ, бусад холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд нээлттэй ил тод байдлыг хангах боломжтой болов.

Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор аудитын тайланг сэдэв, төрөл, гүйцэтгэсэн хугацаа, төсөв захирагчийн ангиллаар хайх боломжийг бүрдүүлж, англи хэл дээрх мэдээллийн цэсийг нэвтрүүлээ. Мөн нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан аудитын үр дүнг тайлбарласан мэдээ, ярилцлага, видео контентыг тогтмол түгээж, олон нийтийн ойлголт, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэв.



Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аудитын тайланг сэдэв, төрөл, гүйцэтгэсэн хугацаа, төсөв захирагчийн ангиллаар ангилан хайх боломжийг нэвтрүүлж, байгууллагын цахим мэдээллийн санг сайжруулсан. Үүний зэрэгцээ олон нийтийн сүлжээг ашиглан аудитын дүгнэлт, ач холбогдлыг тайлбарласан 63 текст мэдээ, 21 видео мэдээ, 51 видео ярилцлага, 14 богино хэмжээний цахим мэдээллийг бэлтгэн түгээж, аудитын үйл ажиллагааны ил тод байдал, ойлгомжийг нэмэгдүүлэв.

Түүнчлэн иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цахим систем болон бүртгэлийн журмаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж шилжүүлэх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих замаар хуулийн хугацаанд шийдвэрлэж, мэдээллийн ил тод байдал, хариуцлагатай харилцааг ханган ажилласан нь олон нийттэй харилцах үйл ажиллагааны бодит үр дүн болов.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллага гадаад хамтын ажиллагааг тасралтгүй өргөжүүлэн хөгжүүлж, олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд төсөл хөтөлбөрт оролцох оролцоог нэмэгдүүлэх, шилдэг сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх замаар албан хаагчдын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх, аудитын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч байна.



Хоёр талт хамтын ажиллагаа: Тайлант онд бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг өрнүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж, шинээр Бүгд Найрамдах Арчилсан Лаос Ард улс (БНАЛАУ), Бүгд Найрамдах Киргиз улс (БНКУ), Холбооны Бүгд Найрамдах Бразил улс (ХБНБУ)-ын Аудитын дээд байгууллагуудтай "Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг шинээр, Бүгд Найрамдах Хятад Ард улс (БНХАУ)-ын Үндэсний аудитын газартай санамж бичгийг шинэчлэн байгууллаа.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага нь 1999 оноос хойш нийт 18 орны АДБ-тай хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан ба 2025 оны байдлаар БНХАУ, ОХУ, БНСУ, Унгар улс, БНСВУ, БНАЛАУ, ХБНБУ, БНКУ, ОХУ-ын Буриад улсын нийт 9 Аудитын дээд байгууллагуудтай "Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санаж бичиг"-ийн хүрээнд шууд харилцаа тогтоон ажиллалаа. Тухайлбал, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Тооцооны танхим, БНКУ-ын Тооцооны танхим, БНТУ-ын Тооцооны шүүх, БНСУ-ын Аудит, хяналтын зөвлөлийн төлөөлөгчдийг хүлээн авч, Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, байгууллага хоорондын үйл ажиллагааны туршлага солилцох уулзалт, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар яриа хэлэлцээ өрнүүллээ.

Олон талт хамтын ажиллагаа: Гурван жил тутам зохион байгуулагддаг Аудитын дээд байгууллагуудын дээд хэмжээний чуулга уулзалтын ээлжит 25 дугаар Чуулган 2025 онд Египед улсын Шарм Эль Шейх хотноо зохион байгуулагдаж, Шарм Эль Шейхийн Тунхаглал батлагдсан. Энэхүү Чуулга уулзалтад Төрийн аудитын байгууллагын төлөөлөгчид оролцож, олон улсын түвшинд Монгол Улсыг таниулах үүргээ амжилттай биелүүлсэн нь онцлог үйл явдал байв.



АДБ-уудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог тасралтгүй сайжруулах бодлого баримтлан идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Аудитын дээд байгууллагын Олон улсын болон Азийн байгууллагын ажлын хэсгүүдэд бүрэн эрхт гишүүнээр элсэж, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, хямралын үед хийх аудит, төрийн өмчит аж ахуйн нэгж, хүрээлэн буй орчны аудит зэрэг олон улсын түвшинд анхаарал татаж буй сэдвүүдээр туршлага солилцов. Тухайлбал, БНХАУ-ын Харбин хотноо 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан АДБОУБ-ын Их өгөгдлийн ажлын хэсгийн IX чуулганд манай төлөөлөгчид оролцож, 22 улсын 69 төлөөлөгчтэй хамтран аудитад их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах чиг хандлагын талаар хэлэлцсэн.



Мөн БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 08 дугаар сард зохион байгуулагдсан АДБАБ-ын Хямралын удирдлагын аудитын ажлын хэсгийн III чуулганд оролцож, Монгол Улсад 2021 онд хэрэгжүүлсэн "Цар тахлын үеийн бодит цагийн аудит"-ыг шилдэг туршлага болгон танилцуулсан нь байгууллагын туршлага олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхөд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Төсөл, хөтөлбөрт орох оролцоог нэмэгдүүлээ: Аудитын үйл ажиллагааны чанар, аудиторуудын чадавхыг сайжруулах зорилгоор олон улсын сургалт, төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй хамрагдав.

2025 онд нийт 195 албан хаагч биет болон цахим хэлбэрээр зохион байгуулагдсан 49 удаагийн олон улсын сургалт, семинар, хурал, уулзалтад хамрагдсан. Тухайлбал, АДБОУБ-ын Хөгжлийн санаачилгаас зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн зорилгын аудитор бэлтгэх хөтөлбөр 2025-2027"-т 6 албан хаагч, "Аудитын чанарын удирдлагын мэргэшүүлэх сертификатын хөтөлбөр 2025-2026"-т 4 албан хаагч, Мэдээлэл технологийн стратеги боловсруулах "rICTure" хөтөлбөрт 6 албан хаагчдыг хамрууллаа. Түүнчлэн БНЭУ-ын "Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ИТЕС)"-т 10 албан хаагч амжилттай хамрагдсан бол Япон Улсын Засгийн газрын "JDS" тэтгэлэгт хөтөлбөрөөр 1 албан хаагч, БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр Нанжины аудитын их сургуульд 2 албан хаагч магистрын зэрэг хамгаалж төгссөн нь хүний нөөцийн чадавхыг урт хугацаанд бэхжүүлэхэд бодит хувь нэмэр орууллаа.

Олон улсын сургалт, төсөл хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын эзэмшсэн мэдлэг, туршлагыг байгууллагын хэмжээнд түгээх, байгууллагын дотоод мэдлэг хуваалцах орчныг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилгоор "Knowledge Sharing" цахим арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлээ.



Шилдэг туршлагын нутагшуулалт:

Олон улсын шилдэг туршлагыг судалж, байгууллагын үйл ажиллагаанд нутагшуулах чиглэлд бодит ахиц гарсан жил байв. Тухайлбал, ХБНБУ-ын Холбооны тооцооны шүүхтэй хамтын ажиллагааг эхлүүлж, аудитын үйл ажиллагаанд ашиглаж буй хиймэл оюунд суурилсан ChatTCU болон CopilotTCU системүүдийг судлан нэвтрүүлэх хүсэлт тавьсны дагуу тус 2 системийн техникийн мэдээллүүд болон эх кодыг хүлээн авч нутагшуулах ажил эхлүүлээд байна.

АДБООУБ-ын Хөгжлийн санаачилгын "piCTure" хөтөлбөрийн үр дүнд байгууллагын мэдээлэл технологийн өнөөгийн байдлыг үнэлж, олон улсын арга зүйд тулгуурласан "Мэдээлэл технологийн стратеги (2026–2030)"-ийг боловсруулан баталсан нь Төрийн аудитын байгууллагын дижитал шилжилт, өгөгдөлд суурилсан аудит, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог шинэ түвшинд гаргах суурь болж байна.



Төрийн аудитын байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаа нь аудиторуудын чадавх, дижитал шилжилт, стратегийн шинэчлэлийг дэмжсэн бодит үр нөлөө бүхий хөгжлийн гол хөшүүрэг байлаа.

ИЛ ТОД БАЙДАЛ

Төрийн аудитын байгууллагын бодлого, үйл ажиллагаа, гүйцэтгэсэн аудитын тайлангийн үр дүнг хэвлэл мэдээлэл, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх зорилгоор "Аудитын тайлан, үйл ажиллагааг сурталчлах төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн нийт 4,423 аудитын тайланг албан ёсны audit.mn вэб сайтад нээлттэй байршуулан олон нийтэд хүргэлээ. Үүнээс Үндэсний аудитын газар 351, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд 4,071 тайланг тус тус мэдээлсэн байна.





Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор audit.mn вэб сайтыг шинэчилж, аудитын тайланг аудитын сэдэв, төрөл, гүйцэтгэсэн огноо, төсөв захирагчийн ангилал, тайлангийн дүгнэлтийн төрлөөр нарийвчлан хайх боломжийг бүрдүүллээ. Мөн байгууллагын бодлого, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг улс, нийслэл, 21 аймагаар ангилан хүргэхийн зэрэгцээ олон улсын болон бусад орны аудитын дээд байгууллагад зориулсан англи хэл дээрх цэсийг нэвтрүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулсан.

Аудитын шийдвэр, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилгоор гүйцэтгэсэн аудитын тайлан, үйл ажиллагаанд тулгуурлан 14 рийл контент бэлтгэн түгээсэн. Мөн Төрийн аудитын байгууллагын бодлого, үйл ажиллагааг нээлттэй сурталчлах хүрээнд текст мэдээ-63, видео мэдээ-21-ийг бэлтгэн audit.mn вэб сайт, Үндэсний аудитын газрын пэйж хуудсаар дамжуулан нийтэлж, мэдээллийн сайтууд болон өдөр тутмын сониноор түгээж ажиллалаа.



Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад зориулан цахимаар түгээгддэг "Аудит" цахим сэтгүүлийн хоёр дугаарыг бэлтгэн дотоод удирдлагын программ, audit.mn вэб сайт, Үндэсний аудитын газрын фэйсбүүк хуудсанд нийтэлж, олон нийтийн хүртээл болголоо.



Аудитын мэдээллийг ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй түгээх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан "Мэдлэг хуваалцах цаг-2025" сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд шинэ вэб сайтаас аудитын тайлан хайх, дүгнэлт, зөвлөмжийг нийтлэл, нэвтрүүлэгт ашиглах арга зүй болон санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын ялгаа, онцлогийн талаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн сонирхсон асуултад аудитын газрын удирдлагууд дэлгэрэнгүй хариулт өглөө.

Төрийн аудитын байгууллага нь сэтгүүлчдийн баримт нотолгоонд тулгуурласан мэдээ, мэдээлэл бэлтгэх найдвартай эх сурвалж болж, гүйцэтгэсэн аудитаар ярилцлага, мэдээлэл өгөх, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг олон нийтэд хүргэх, хариуцлага нэхэх үйл явцад иргэдийг татан оролцуулах замаар төрийн санхүү, төсвийн зарцуулалтыг сайжруулахад идэвхтэй ажиллалаа.

ХҮНИЙ НӨӨЦ, ЧАДАВХЫН ХӨГЖИЛ

Төрийн аудитын байгууллага хүний нөөцийн бодлогоо бүтцийн шинэчлэл, чиг үүргийн оновчлолтой уялдуулан хэрэгжүүлж, төвлөрсөн зохион байгуулалтын тогтолцоонд нийцсэн хүний нөөцийн хуваарилалтыг хийхэд голлон анхаарлаа. Төрийн аудитын тухай хуульд заасан үндсэн үйл ажиллагааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын оновчтой шийдэл хийж албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан.




Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд нийт 541 албан хаагч ажиллаж байгаагаас Үндэсний аудитын газарт 191, Нийслэл дэх Төрийн аудитын газарт 57, аймаг дахь Төрийн аудитын газруудад нийт 293 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Хүний нөөцийн удирдлагад чадамжид суурилсан арга хандлагыг нэвтрүүлж, дэвшүүлэх томилгоо, шилжилт хөдөлгөөн, тусгай шалгалт, сургалт, хөгжлийн төлөвлөлтийг уялдуулснаар байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдал, гүйцэтгэлийн уялдаа, хариуцлагын соёлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын өөрчлөлтийг эхлүүлсэн.


Өнөөгийн байдлаар хүний нөөцийн боловсролын түвшинг авч үзвэл албан хаагчдын 52.5 хувь нь магистр, 44.8 хувь нь бакалаврын зэрэгтэй байгаа нь хүний нөөцийн чадамжийг бодлогоор дэмжих суурь нөхцөл бүрдсэнийг харуулж байна. Мөн хугацаанд хууль тогтоомж, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн шатлан дэвших зарчмыг баримтлан байгууллага дотроо дэвшлүүлэн томилсон 26, байгууллага дотроо ижил ангиллын албан тушаалд шилжүүлэн томилсон 37, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн томилсон 23, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс томилсон 101, албан үүргийг түр орон гүйцэтгүүлэхээр 35, өөрийн хүсэлтээр албан тушаал бууруулж томилсон 5, хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болж томилогдсон 12, нийт 239 иргэн, албан хаагчийг холбогдох шийдвэрийн дагуу албан тушаалд томилон ажиллуулжээ.

Албан хаагчдын насны бүлэг: Нийт 541 албан хаагчаас 1.5 хувь нь 24 хүртэлх насны, 7.0 хувь нь 25–29 насны, 12.4 хувь нь 30–34 насны, 23.7 хувь 35–39 насны, 20.5 хувь нь 40–44 насны, 17.6 хувь нь 45–49 насны, 10.9 хувь нь 50–54 насны, 6.3 хувь нь 55–59 насны, 0.2 хувь нь 60 ба түүнээс дээш насны албан хаагч тус тус ажиллаж байна.


Дүрслэл 5. Төрийн аудитын байгууллагын хүний нөөц (хүйс, насны бүлгээр)




Дүрслэл 6. Хүний нөөц, албан тушаалаар




Дүрслэл 7. Хүний нөөц, мэргэжлээр



Дүрслэл 8. Хүний нөөц, ажилласан жилээр



Дүрслэл 9. Хүний нөөц, боловсролын түвшнээр



Сургалт, хөгжил: Төрийн аудитын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, хөгжлийн бодлогыг системтэй хэрэгжүүлж, сургалтын хэрэгцээ шаардлагад үндэслэн дотоод болон гадаад сургалтуудад албан хаагчдыг тасралтгүй хамрууллаа.

Сургалт хөгжлийн төлөвлөгөө нь зөвхөн мэдлэг олгоход бус, аудитын бодит ажилд хэрэглэгдэх чадварыг дэмжсэн, өгөгдлийн шинжилгээ, орчин үеийн технологи ашиглалт, төрийн аудитын арга зүй, мэргэшүүлэхэд чиглүүлсэн нь албан хаагчдын мэргэжлийн өсөлтийг дэмжихэд хувь нэмрээ оруулав.

Аудитын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, хөгжлийн бодлогыг системтэй хэрэгжүүлж, 2025 онд нийт 105 багц сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 11,270 албан хаагчийг хамруулсан байдлаас үзвэл "Нэг" албан хаагч дунджаар 18-21 сургалтад хамрагдсан нь тасралтгүй хөгжлийн бодлого бодитой хэрэгжсэнийг илтгэнэ.

Мөн АХЭ-ийн аудиторуудыг чадавхжуулах 5 багц сургалтад давхардсан тоогоор 3,599 аудитор хамрагдсан нь аудиторын чадамжийг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр болсон юм.

Сургалтыг цахим, танхим, онлайн, хосолсон хэлбэрээр зохион байгуулж, цахим сургалтад давхардсан тоогоор 7,659 албан хаагч хамрагдаж, үүнээс сертификат олгох сургалтад хамрагдсан 947 албан хаагчийн 70 хувь нь амжилттай төгссөн. Өгөгдлийн шинжилгээ, Excel, Power BI, Data analytics, хиймэл оюун ухаан зэрэг аудиторуудын чадамжид чиглэсэн сургалтуудыг зохион байгуулсан нь аудитын арга зүйн шинэчлэлийг хүний нөөцийн хөгжлөөр дэмжих суурь болж өгсөн. Цаашид тасралтгүй сургалт хөгжлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн нэгдсэн төлөвлөгөөний дагуу уламжлал болгон хэрэгжүүлэх юм.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал: Төрийн аудитын байгууллага төсвийн гүйцэтгэл, НББ, санхүүгийн тайлагналыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын сахилга бат, санхүүгийн хяналтыг хангахад анхаарч ажилласан. Санхүүгийн тайлагналын ил тод байдал, бодит байдалд тавих хяналтыг сайжруулснаар байгууллагын санхүүгийн удирдлага, тайлагналын итгэлцлийг бэхжүүлж ажиллав.

Түүнчлэн төсвийн болон санхүүгийн мэдээллийг олон нийтэд нээлттэй хэлбэрээр мэдээлэх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь санхүүгийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын нэг хэсэг байв.

Төрийн аудитын байгууллагын төсөв 2025 онд 48.4 тэрбум төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл 99.0 хувьтай, 328.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийн сахилга, санхүүгийн удирдлагыг ханган ажилласныг харуулж байна. Батлагдсан төсвийн зардлын 78.2 хувийг цалин, урамшуулал, 9.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байна.

Хүснэгт 14. Төрийн аудитын байгууллагын 2025 оны төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)

Д-д	Зардлын зүйл	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Хэтрэлт (-) Хэмнэлт (+)
		Урсгал зардал	Эзлэх хувь	Урсгал зардал	Эзлэх хувь	
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	37,877.7	78.2	37,726.6	78.7	154.1
2	Нийгмийн даатгалын шимтгэл	4,753.8	9.8	4,727.6	9.9	26.2
3	Байр ашиглалттай холбоотой зардал	692.7	1.4	677.0	1.4	15.7
4	Хангамж, бараа материалын зардал	453.8	0.9	425.8	0.9	28.0
5	Эд хогшил, урсгал засварын зардал	272.3	0.6	270.1	0.6	2.2
6	Томиллолт, зочны зардал	868.4	1.8	793.7	1.7	74.7
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр,	2,041.5	4.2	1,924.5	4.0	117.0
8	Бараа үйлчилгээний бусад зардал	196.8	0.4	174.5	0.4	22.3
9	Урсгал шилжүүлэг	1,258.9	2.6	1,224.0	2.6	31.9
10	Хөрөнгийн зардал	-	-	-	-	-
	НИЙТ ЗАРДАЛ	48,415.9	100.0	47,943.8	100.0	472.1

ҮАГ төсвийн сахилга, санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд төсвөө 99.0 хувийн гүйцэтгэлтэй гарч, 328.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээ.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд батлагдсан төсөв болон гүйцэтгэл нь 2024 оныхтой харгалзан 9.3 хувь ба 12.3 хувиар өсөж, гүйцэтгэлийн түвшин 96.3 хувиас 99.0 хувь болж 2.65 нэгжээр ахисан нь байгууллагын төсөвлөлт, санхүүжилтийн хэрэгжилт, гүйцэтгэлийн уялдаа сайжирсныг илтгэх юм.

Төсвийн болон санхүүгийн мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь байгууллагын ил тод байдал, хариуцлагын бодлогын салшгүй хэсэг болж иргэдэд хүргэх мэдээллийн чанарыг дээшлүүлэв.

Шилэн дансны мэдээлэл: Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, тайлант хугацаанд байршуулбал зохих 89 мэдээллийг 100 хувь цахим хуудсанд байршуулсан нь санхүүгийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын үр дүн байлаа.

Өмч хөрөнгийг хадгвалах, хамгаалах, ашиглалтын зохицуулалт: Байгууллагын өмч хөрөнгийг хадгалах, хамгаалах, ашиглалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, өмчийн бүртгэл, тооллого, актлах, дахин үнэлгээ, балансаас баланст шилжүүлэх ажлыг үе шаттай гүйцэтгэж, Өмч хамгаалах зөвлөлийн хурлыг 2025 оны 3 дугаар сард зохион байгуулж, 2025 оны өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ.

ТАБ-ын хөрөнгийн 2024 оны тооллогын тайлан болон Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 141 нэр төрлийн 435.4 сая төгрөгийн хөрөнгийг актлуулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн санал авч, ТӨБЗГ-ын 2025 оны 257 дугаар тогтоолыг үндэслэн хөрөнгийг данс бүртгэлээс хаслаа.





Тамгын даргын 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/55 дугаар тушаалаар хагас жилийн хөрөнгийн тооллогын комисс байгуулж, 2025 оны 6 дугаар сарын 16-наас 20-ны өдрүүдэд хөрөнгийн тооллого зохион байгуулан, тайланг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэв. Тайлант хугацаанд нийт 654.5 сая төгрөгийн үнэ бүхий 953 ширхэг цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 404 нэр төрлийн, 284.0 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган дахин үнэлэх, мөн 2 автомашиныг балансаас баланст шилжүүлэх саналуудыг ТӨБЗГ-т хүргүүлж, холбогдох шийдвэрийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллав.


Худалдан авах ажиллагаа: Тайлант онд нийт 1,979.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 худалдан авах ажиллагааг төлөвлөснөөс 748.6 сая төгрөгийн 6 ажиллагааг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 85.7 хувьтай биелсэн байна.

Аудитад шинжээч, АХЭ ажиллуулах: Аудитын үйл ажиллагаанд нарийн мэргэжлийн шинжээч болон аудитын хуулийн этгээдийг оролцуулах хуулийн зохицуулалтын дагуу ЗББНүүдээс санал авч нэгтгэн, "Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитад шинжээч ажиллуулах ерөнхий төлөвлөгөө"-г баталж хэрэгжүүлэв.

Төлөвлөгөөний дагуу аудитын 9 сэдвийн хүрээний 17 ажилд шинжээч ажиллуулахаар тусгасан бөгөөд шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу audit.mn цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр нээлттэй зарлан, тайлант хугацаанд батлагдсан ажлын даалгаварт хамаарах сонгон шалгаруулалтыг 100 хувь амжилттай зохион байгууллаа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДҮГНЭЛТ

- Төрийн аудитын байгууллага-2025 он
- Төрийн аудитын байгууллага-2026 оны бодлого, чиг хандлага



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА-2025 ОН

Төрийн аудитын байгууллага нь хуулиар хүлээсэн бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийн удирдлагад тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг бодит мэдээллээр дэмжих, төрийн санхүүгийн сахилга, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах зорилгоо амжилттай хэрэгжүүллээ. Тайлант онд гүйцэтгэсэн аудитын сэдвийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, бодлогын хэрэгжилтийн чанарт нөлөөлөх гол эрсдэлийг илрүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэсэн аудитын чиглэлүүдийг тодорхойлж, гүйцэтгэсэнээр төрийн санхүүгийн хариуцлага, ил тод байдал, засаглалын соёлд эерэг өөрчлөлтийг бий болгоход анхаарч ажиллав.

Төрийн аудитын байгууллага 2025 онд нийт 3,954 аудит гүйцэтгэн, 20.3 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, 10.9 их наяд төгрөгийн алдааг залруулсан нь төрийн байгууллагуудын санхүүгийн сахилгыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан дүн боллоо. Түүнчлэн аудитын дүнд улсын болон орон нутгийн төсөвт 62.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, аудитад зарцуулсан нэг төгрөг тутамд 32.1 төгрөгийн үр өгөөж бий болгосон нь төрийн аудитын нийгэм, эдийн засагт үзүүлэх бодит нөлөөлөл өссөнийг илтгэж байна.

ҮАГ 2024 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог амжилттай баталгаажуулж байсан бол 2025 онд "Аудитын дээд байгууллагын чанарын удирдлага-АДБОУС 140" стандартыг баталснаар чанарын удирдлагын бодлого, дотоод үнэлгээ, хяналт-шинжилгээний тогтолцоо, аудитын мэргэжлийн стандарт, хариуцлагын түвшнийг олон улсын жишигтэй нийцүүлсэн бодит ахиц боллоо.

Дижитал шилжилтийн хүрээнд Power BI-д суурилсан эрсдэлийн болон гүйцэтгэлийн шинжилгээний аргачлал, audit.mn, topic.audit.mn зэрэг өгөгдөлд суурилсан платформуудыг ашиглан дижитал аудитын экосистемийг бүрдүүлж эхэлсэн нь аудитын нотолгоо, дүн шинжилгээний чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэв.

Төрийн аудитын байгууллага олон улсын хамтын ажиллагааны хүрээнд 2025 онд Олон улсын аудитын дээд байгууллагуудын XXV Конгресс (INCOSAI), Их өгөгдлийн ажлын хэсгийн чуулган, Монгол-Оросын хамтарсан аудит, Монгол-Лаос, Монгол-Киргиз, Монгол-Турк, Монгол-Бразилын хамтын ажиллагааны хүрээнд аудитын арга зүй, дижитал аудитын чиг хандлага, нөлөөллийн аудитын шинэчлэлийн талаар онцгой туршлага солилцож, байгууллагын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх боломжийг өргөжүүлсэн жил байв.

Төрийн аудитын хэрэгжүүлэх явцад илрүүлсэн зөрчил нь төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын удирдлага, худалдан авалт, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын тогтолцоонд тогтмол ажиглагддаг эрсдэлийг дахин баталгаажуулсан ч аудитын шийдвэрийн хэрэгжилт сайжирч, нийцлийн түвшин 74-88 хувьтай байсан нь төрийн байгууллагын хариуцлага, засаглалын соёлд эерэг өөрчлөлт гарсан гэж үзэж байна.

Төрийн аудитыг хэрэгжүүлсэн 2025 оны нөхцөл байдал нь илрүүлэлт төвтэй уламжлалт хандлагаас нөлөөлөлд суурилсан аудитын шинэ тогтолцоо руу шилжих суурь нөхцөл бүрдсэн гэдгийг харуулж байна. Чанарын удирдлага, дижитал шинэчлэл, олон улсын хамтын ажиллагаа, аудитын чадавхыг бэхжүүлэх дэмжих үйлчилгээнд гаргаж буй дэвшил нь 2026 онд төрийн аудитын байгууллага бодлогын шинэчлэл, нөлөөллийн үнэлгээний тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх үндэс болж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА-2026 ОНЫ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага 2025 онд гүйцэтгэсэн аудитын дүн, шийдвэрийн хэрэгжилтийн явц, дотоод болон гадаад орчны үнэлгээ, олон улсын аудитын дээд байгууллагуудын чиг хандлага, хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлсэн бодлогын саналыг үндэслэн 2026 онд төрийн аудитын үйл ажиллагаанд дараах бодлого, чиглэлийг баримтална. Үүнд:

Аудитын нөлөөллийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх: Аудитын үр дүнг зөвхөн биелэлтээр бус төрийн санхүү, бодлого, гүйцэтгэл, засаглалд үзүүлж буй бодит өөрчлөлтөөр хэмждэг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн системийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Энэ нь зөвлөмжийн чанар, аудитын шийдвэрийн үнэ цэнийг бодитой нэмэгдүүлэх явдал юм.

Эрсдэлд суурилсан, стратегийн ач холбогдол бүхий сэдвийн эзлэх хувийг нэмэгдүүлэх: Төсвийн хөрөнгө оруулалт, тусгай сан, ТӨҮГ, байгалийн баялгийн засаглал, салбарын томоохон бодлогын хөтөлбөрүүд зэрэг үндэсний хэмжээний эрсдэлтэй асуудлуудыг төрийн аудитын бодлогын төвд байршуулах бөгөөд өгөгдөлд суурилсан судалгаа шинжилгээг төлөвлөлтийн үндсэн хэрэгсэл болгоно.

Чанарын удирдлагын тогтолцоог олон улсын стандартын дагуу төлөвшүүлэх: АДБОУС 140 стандартыг бодит төвшинд хэрэгжүүлж, төлөвлөлт-гүйцэтгэл-тайлагналын үе шат бүрийг чанарын хяналт, баталгаажуулалт, дотоод үнэлгээгээр дэмжиж, аудитын мэргэжлийн стандартын нэгдмэл байдлыг хангана.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн чанар, нөлөөллийг нэмэгдүүлэх: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн чанар, хяналт-шинжилгээ, ил тод байдлыг сайжруулж, төрийн байгууллагуудын санхүүгийн сахилга, хариуцлагын түвшнийг бодитой өсгөх механизм бий болгоно.

Дижитал аудитын нэгдсэн экосистемийг бий болгох: Power BI, audit.mn, topic.audit.mn платформуудыг нэгтгэсэн дижитал экосистем болгон хөгжүүлж, аудитын нотолгоо, дүн шинжилгээ, автоматжуулсан хяналтыг шинэ шатанд хүргэнэ.

Аудиторын хараат бус байдал, мэргэжлийн ёс зүй, ур чадварыг чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогоор дэмжих: Аудиторын чадамжийн өсөлт, ёс зүй, хараат бус байдлыг хангах сургалт, үнэлгээ, мэргэшлийн тогтолцоог үе шаттай хөгжүүлж, төрийн аудитын байгууллагын чадамжийг бэхжүүлнэ.

Ил тод тайлагнал, олон нийтийн оролцоог тэлсэн нээлттэй аудитын орчныг төлөвшүүлэх: Иргэд, олон нийтэд ойлгомжтой тайлагналын шинэ загвар бий болгож, дижитал платформуор дамжуулан аудитын ил тод байдал, оролцоог бодитоор нэмэгдүүлнэ.

Төрийн аудитын байгууллагын хамт олон бид хууль дээдлэх, шударга ёсыг сахин хамгаалах, төрийн санхүүгийн хяналтыг бэхжүүлэх эрхэм зорилгодоо үнэнч байж, хуульд заасан чиг үүргийн хүрээнд чанарын болон эрсдэлийн удирдлагыг зүй зохистой хэрэгжүүлэх, эрсдэлд болон өгөгдөлд суурилсан дижитал шилжилтийг хурдасган иргэд, олон нийтийн итгэл, хүлээлтэд нийцсэн хараат бус аудитын байгууллага байх зорилгоо туйштай хэрэгжүүлж, "Төрийн аудитын үйл ажиллагааны нөлөөллийг тооцох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлнэ".

ТАВДУГААР БҮЛЭГ

ХАВСРАЛТ

- Хараат бус аудиторын дүгнэлт
- Үйл явдлын товчоон-2025 он
- Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилт
- Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэсэн аудит
- АНТАГ-ын тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлэлт



ХАВСРАЛТ 1

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ТАМГЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БУНДХОРОЛ ТАНАА

Ди Эй Би Жи Аудит ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Пиэрл тауэр, А блок, 501 тоот
Утас: 976-91910954, 99112793
И-мэйл: dabg.audit@gmail.com

Огноо 2026.02.25
№ 26/12-1

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн аудитын байгууллага E-Mongolia системээр “Аудитын сэдэвт санал авах” үйлчилгээг нэвтрүүлж, тухайн жилд гүйцэтгэх аудитын сэдвийг иргэд, олон нийтийн оролцоонд суурилан тодорхойлох боломжийг бүрдүүлсэн. Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөний дагуу санхүүгийн тайлангийн аудитад бүх шатны төсөв захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд бие даасан 3,677 дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн 94, нийцлийн 183, нийт 3,954 аудитыг гүйцэтгэж тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Аудитын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, мэргэшлийн бодлогыг системтэй хэрэгжүүлж, 2025 онд нийт 74 багц, 1,547 цагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 11,270 албан хаагчийг хамруулсан. Мөн аудитын хуулийн этгээдүүдийн аудиторуудыг чадавхжуулах 5 багц сургалтад 3,599 аудитор хамрагдсан нь сургалт, мэргэшлийн тогтолцоог хөгжүүлэхэд бодит хувь нэмэр болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 1,499,112.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Н.ДЭЛГЭРМАА

ХАВСРАЛТ 2

Үйл явдлын хураангуй-2025 он

Сар	Үйл явдлын товч агуулга
I	Монгол Улсын хөгжлийн 2021–2025 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийх гүйцэтгэлийн аудитын нээлтийн уулзалтыг зохион байгуулж, аудитын зорилт, чиглэл, шалгуур үзүүлэлтийг холбогдох байгууллагад танилцуулав.
I	Үндэсний аудитын газарт "Аудитор" ажлын байрны зар нийтэлж, сонгон шалгаруулалт зарлав.
II	"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын нээлтийг зохион байгуулж, яамдын ТНБД болон холбогдох этгээдүүдэд төлөвлөгөө, шалгуурыг танилцуулав.
III	"Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг УИХ-ын Төрийн байгуулалт, Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулав.
IV	"Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороонд Монгол Улсын Ерөнхий аудитор танилцууллаа.
V	Гамшгийн бэлэн байдлын тогтолцоо болон хууль, эрх зүйн хэрэгжилтэд хийх гүйцэтгэлийн аудитын нээлтийн хуралдаан болж, аудитын хүрээ, анхаарах асуудлыг салбарын байгууллагуудад танилцуулав.
V	"Ундны ус, ариун цэврийн байгууламж (ТХЗ6.1)" сэдэвт аудитын нээлт хийв.
V	УИХ-аас Монгол Улсын Ерөнхий аудитораар С.Магнайсүрэн томилогдож тамга гардуулах ёслол болов
V	УИХ-ын Төсвийн байнгын хороо "Засгийн газрын өрийн удирдлагын 2023–2025 стратеги"-ийн хэрэгжилтийн тайлангийн хэлэлцүүлэг хийсэнд ҮАГ оролцлоо.
VI	Төрийн байгууллагуудын оролцоотой "Parliament Cup 2025" арга хэмжээнд ҮАГ амжилттай оролцож, нийлбэр дүнгээр тэргүүн байр эзлэв.
VI	"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг УИХ-д танилцуулж, зөвлөмж хүргүүлэв.

VII	УИХ-ын Төсвийн байнгын хороонд "Төсвийн тодотгол"-ын хоёр дахь хэлэлцүүлэгт ҮАГ-аас гаргасан аудитын дүгнэлтийг танилцуулав.
VII	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шилдэг албан хаагчдад төрийн одон, салбарын шагнал гардуулав.
VII	ҮАГ-аас 2025 онд 6832 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын үр дүнг танилцуулж, илэрсэн зөрчил, хариуцлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.
IX	БНХАУ-ын Харбин хотод болсон АДБОУБ-ын "Их өгөгдлийн ажлын хэсэг IX чуулга"-д оролцож, 22 орны төлөөлөлтэй хамтран "Хиймэл оюун ухаан" сэдвээр туршлага солилцов.
X	"Гүйцэтгэлийн аудитын сайн туршлагыг бэхжүүлэх" хэлэлцүүлгийг ҮАГ, УИХ-ын Тамгын газар, Сангийн яам, мөн АДБОУБ-ын Хөгжлийн санаачилгын төлөөлөл зэрэг харилцагч талуудтай хамтран зохион байгуулж, хамтын ажиллагааны чиглэл тодорхойлсон.
X	"Enhancing the Impact of Performance Audit through Collaboration" сэдвээр олон улсын хэлэлцүүлэгт оролцож, гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг нэмэгдүүлэх арга зүйн талаар байр сууриа илэрхийллээ.
XI	ҮАГ-аас гэрээгээр санхүүгийн аудит гүйцэтгэдэг аудитын хуулийн этгээдүүдэд зориулсан үндэсний сургалт зохион байгуулав
XI	Киргизийн Бүгд Найрамдах Улсын Тооцооны танхимын төлөөлөгчид Үндэсний аудитын газарт айлчилж, хоёр байгууллагын хамтын ажиллагааны хүрээ, арга зүй, туршлага солилцох чиглэлийн талаар албан ёсны уулзалт хийж, санамж бичиг байгуулав.
XI	БНСУ-ын Аудит, хяналтын сургалтын хүрээлэнгийн ерөнхийлөгчийн айлчлал-олон улсын сургалт, чадавх бэхжүүлэх чиглэлд хамтын ажиллагааны уулзалт хийв.
XII	Монгол Улсын Ерөнхий аудитор Туркийн Аудитын Дээд байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар уулзалт зохион байгуулав.

ХАВСРАЛТ 3

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны
2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилт

		Аудитын гүйцэтгэл			
		Тайлан баталгаажиж, холбогдох байгууллагад хүргүүлсэн	УИХ-ын ТБХ-ны 2025.12.10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор хасагдсан	Гадаад томилолтын зардал хасагдсан	2026 онд үргэлжилж буй
1	2	3	4	5	6
Д.д	Аудитын нэр, сэдэв	36	3	1	2
	Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх аудит	17	0	1	0
1	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудит	1			
2	Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудит	1			
3	Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх	1			
4	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	1			
5	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	1			
6	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	1			
7	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	1			
8	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	1			
9	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	1			
10	Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит			1	
11	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх аудит	1			
12	Засгийн газрын өрийн удирдлагын 2023–2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт	1			
13	Монгол Улсын 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт	1			
14	Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн	1			

1	2	3	4	5	6
15	Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт	1			
16	Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	1			
17	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	1			
18	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	1			
Төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудит		19	3	0	2
1	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүн	1			
2	Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө	1			
3	Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн	1			
4	Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө	1			
5	Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн		1		
6	Уул уурхайн тусгай зөвшөөрөл олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт	1			
7	Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн	1			
8	Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн	1			
9	Гамшгийн бэлэн байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт	1			
10	Төрөөс аялал, жуулчлалыг хөгжүүлэхэд баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт	1			
11	Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүн	1			
12	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	1			
13	Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө	1			
14	Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах	1			

1	2	3	4	5	6
15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон "Хөдөө аж ахуйг корпорац" ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүн	1			
16	Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг, зардал	1			
17	Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрөөс баримталж буй бодлого болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн	1			
18	Хүү, торгуулийн бүрдүүлэлт, зарцуулалт	1			
19	"Оюутолгой" ХХК-ийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн		1		
20	Стратегийн ач холбогдол бүхий төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл		1		
21	Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө	1			
22	Арилжааны банкнуудад төсөв, Засгийн газрын тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс байршуулсан хөрөнгийн үр дүн				1
23	Үнэ тогтворжуулах зорилгоор төрөөс олгож буй татаас, нөхөн олговрын зарцуулалтын үр дүн				1
Өмнөх оноос үргэлжлүүлэн гүйцэтгэх аудит					
24	Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагааны нийгэм эдийн засагт үзүүлж буй үр нөлөө, үр ашиг	1			

ХАВСРАЛТ 4

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэсэн аудит (МУЕА-ын 2024 оны А/107 дугаар тушаалаар баталсан сэдэв)

Аудитын газар	Аудитын сэдэв
АНТАГ (Нэгдсэн удирдамж)	Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө
АНТАГ (Нэгдсэн удирдамж)	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Архангай	Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж
Баян-Өлгий	Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг
Баянхонгор	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн
Булган	Иргэн хуулийн этгээдэд эзэмшлийн зориулалтаар олгосон газар эзэмшилт, ашиглалтын үр дүн
Говь-Алтай	Уул уурхайн аж ахуйн нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн
Говьсүмбэр	Газар эзэмших эрх олголт, түүний үр дүн
Дархан-Уул	Халамжийн сангийн тухай хуулийн хэрэгжилт
Дундговь	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, үр дүн
Дорноговь	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн
Дорнод	Газар эзэмшилт, ашиглалтын үр дүн (Тус сэдвийг МУЕА-ын 2025 оны А/178 дугаар тушаалаар хассан)
Завхан	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт
Нийслэл	Нийслэлд хэрэгжсэн автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн (Тус сэдвийг МУЕА-ын 2025 оны А/178 дугаар тушаалаар 2026 онд шилжүүлсэн)
Сүхбаатар	Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн
Сэлэнгэ	Сумдын 100 жилийн ойн хандивын зарцуулалт, үр дүн
Орхон	Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүн
Өвөрхангай	Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүн
Өмнөговь	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал, үр дүн
Төв	Аймаг хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт зарцуулалт, үр дүн
Төв	Аймгийн ИТХ-ын 2020–2024 оны хөрөнгө шийдвэрлэх тогтоолын хэрэгжилт
Увс	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Хоёр живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд 2023–2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн
Ховд	Аймгийн нөөц бүрдүүлэлт зарцуулалтын үр дүн
Хөвсгөл	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн
Хэнтий	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт

ХАВСРАЛТ 5

АНТАГ-ын тайлант хугацаанд гүйцэтгэсэн
аудитын дүн, илрүүлэлт

	АНТАГ	Гүйцэтгэсэн аудитын тоо	Залруулсан алдаа дүн (сая төгрөг)	Илрүүлсэн зөрчлийн дүн (сая төгрөг)
1	Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	181	19,874.3	55,843.1
2	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	126	42,175.2	60,382.1
3	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	126	13,517.1	95,582.7
4	Булган аймаг дахь Төрийн аудитын газар	154	21,280.2	34,255.7
5	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар	149	66,899.2	57,698.9
6	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	69	3,412.7	11,164.7
7	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар	158	99,482.2	810,084.5
8	Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	152	74,711.6	49,925.7
9	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	127	7,070.0	65,708.8
10	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	107	11,091.5	30,540.4
11	Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	187	18,221.2	115,956.4

12	Нийслэл дэх Төрийн аудитын газар	421	411,554.2	1,313,857.6
13	Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	109	35,154.8	16,826.7
14	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар	169	25,289.2	90,331.5
15	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар	184	361,449.1	168,327.8
16	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар	83	4,335.6	13,578.6
17	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	151	278,983.4	72,118.0
18	Төв аймаг дахь Төрийн аудитын газар	180	273,089.6	174,019.7
19	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	196	3,449.1	70,743.0
20	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	144	23,336.2	64,145.6
21	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар	226	15,983.4	76,516.4
22	Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар	155	28,836.2	48,725.5
	НИЙТ	3554	1,839,195.8	3,496,333.4

**ТӨРИЙН АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫН
2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**



АГУУЛГА

128 ОРШИЛ

128 1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

140 2. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

142 3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

142 3.1. Төрийн аудитын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хүний нөөцийн талаар

145 3.2. Албан хаагчдын сургалт, хөгжлийн талаар

146 4. САНХҮҮ БУЮУ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ҮНЭЛГЭЭ

146 4.1. Төсвийн төлөвлөлт

147 4.2. Төсвийн гүйцэтгэл

149 ҮАГ-ын төсвийн гүйцэтгэлийн талаар

150 4.3. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл

151 4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

151 4.5. Худалдан авах ажиллагаа

152 5. ДҮГНЭЛТ

ХҮСНЭГТ

Хүснэгт-1	2025 оны аудитын сэдэв, түүний хэрэгжилт
Хүснэгт-2	2025 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /тоо, хувь/
Хүснэгт-3	2025 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /мөнгөн дүн, төрлөөр/
Хүснэгт-4	ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт-5	ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт-6	Үүрэг даалгаврын хэрэгжилт
Хүснэгт-7	ТАБ-ын албан хаагчдын ажилласан жил
Хүснэгт-8	ТАБ-ын албан хаагчдын боловсролын түвшний бүтэц
Хүснэгт-9	ТАБ-ын албан хаагчдын мэргэжлийн бүтэц
Хүснэгт-10	Сургалтын төрөл, хамрагдсан албан хаагчдын тоо
Хүснэгт-11	Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээ
Хүснэгт-12	ҮАГ-ын төсвийн гүйцэтгэл
Хүснэгт-13	ҮАГ-ын 2025 оны санхүүгийн тайлан

ДҮРСЛЭЛ

Дүрслэл-1	2025 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /тоо, төрлөөр/
Дүрслэл-2	2025 онд Төрд учруулсан хохирлыг төлүүлсэн байдал
Дүрслэл-3	ТАБ-ын албан хаагчдын нас, хүйсийн суварга
Дүрслэл-4	ТАБ-ын албан хаагчдын албан тушаал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБ	Аудитын дээд байгууллага
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
АШХГ	Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар
БТИГ	Бодлого, төлөвлөлт, инновацын газар
ДАГ	Дотоод аудитын газар
ЗББН	Зохион байгуулалтын бүтцийн нэгж
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МН	Маш нууц
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УШХ	Удирдлагын шуурхай хуралдаан
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧУЭГ	Чанарын удирдлага, эрсдэлийн газар
FAS	(Financial audit system) Санхүүгийн тайлангийн аудитын систем

ОРШИЛ

Төрийн аудитын байгууллагын 2025 оны зорилтыг "Чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх" гэж тодорхойлон баталсан. Дэвшүүлсэн зорилттой уялдуулан ТАБ-ын 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг (шинэчлэн) А/82 дугаар, гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөг А/08 дугаар тушаалаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоол, Хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээг дараах хүрээнд хийлээ. Үүнд:

Төрийн аудитын байгууллагын чиг үүргийн хэрэгжилт	Хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ
Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Санхүү буюу захиргааны зардлын үнэлгээ

Системчилсэн үнэлгээнд Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайлан, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, сургалт, хөгжлийн үйл ажиллагааны тайлан, УИХ-ын ТБХ-ны тогтоолоор баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн аудитын гүйцэтгэл, үр дүн, мөн тухайн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны тайлан болон бусад холбогдох баримт материалыг хамруулан системчилсэн үнэлгээг хийлээ.

1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагаас 2025 онд хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх 17, бодлогоор гүйцэтгэх 24, нийт 41 аудитын сэдэв баталсан байна.

Нийт 41 сэдвээс 2025 онд 35 аудитыг гүйцэтгэж, тайлан, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч буюу эрх бүхий албан тушаалтан, холбогдох байгууллага

болон УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлж, 1 аудит гадаад томилолтын зардал төсвийн тодотголоор хасагдсаны улмаас гүйцэтгэх боломжгүй, 3 аудитыг УИХ-ын ТБХ-ны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор хасаж шийдвэрлэсэн, 2 аудит төлөвлөсөн хугацааны дагуу 2026 онд үргэлжилж байна.

Түүнчлэн МУЕА-ын 2024 оны А/107 дугаар тушаалаар АНТАГ-ын 2025 онд бодлогоор гүйцэтгэх нийт 25 аудитын сэдэв, 2025 оны А/44 дүгээр тушаалаар 4, өмнөх оноос дамжин хийгдсэн 1 аудит, нийт 30 аудитаас 28 аудитыг аудитыг гүйцэтгэж, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн, 1 аудитыг 2026 онд гүйцэтгэх аудитын сэдэвт хамруулж, 1 аудитын хугацааг сунгасан байна.

Дараах хүснэгтээр УИХ-ын ТБХ-ны тогтоолоор баталсан 41 сэдвийн дагуу хийсэн аудитын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. 2025 оны аудитын сэдэв, түүний хэрэгжилт

д/д	Аудитын сэдэв (УИХ-ын ТБХ-ны 2024 оны 05 дугаар тогтоол)		Гүйцэтгэл	Хэрэгжсэн эсэх
	Сэдэв	хугацаа		
Нэг. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	2025.04.14 2025.06.10	Аудитын тайланг МУЕА-ын 2025 оны А/56, А/57 дугаар тушаалаар баталгаажуулж, УИХ-ын ТБХ-нд хүргүүлж, УИХ, Байнгын хороодоор хэлэлцүүлж УИХ-ын 2025.07.03-ны өдрийн 63 дугаар тогтоолоор баталгаажуулсан.	Бүрэн хэрэгжсэн
2	Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх	2025.04.17 2025.05.05	Аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж, "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгч аудитын тайланг МУЕА-ын 2025.05.05-ны 1706 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
3	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	2025.03.24 2025.04.25	Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан хуулийн хугацаанд Төсвийн 61 ерөнхийлөн захирагчдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд MNS 6817, АОУС, ТАБ-ын аудит хийх журам, заавар аргачлалын дагуу аудит хийж, өөрчлөлтгүй 31, хязгаарлалттай 29, сөрөг 1 дүгнэлт өгч, ТЕЗ нарт хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	2025.02.27 2025.03.25	Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасан хуулийн хугацаанд төсвийн 372 төвлөрүүлэн захирагчдын 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, өөрчлөлтгүй 231, хязгаарлалттай 133, сөрөг 5, санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан 3 дүгнэлт өгч, ТТЗ нарт албан бичгээр хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
5	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	2025.01.02 2025.02.25	Засгийн газрын 56 тусгай санд дүгнэлт гаргаж, 33 санд өөрчлөлтгүй, 21 санд хязгаарлалттай дүгнэлтийг тус тус гаргаж, шалгагдагч байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
6	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	2025.02.15 2025.03.15	Төрийн болон орон нутгийн өмчит 619 аж ахуйн нэгжээс 375 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 247 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 4 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Аудитаар 251 байгууллагад өөрчлөлтгүй, 113 байгууллагад хязгаарлалттай, 4 байгууллагад сөрөг дүгнэлтийг тус тус гаргаж, шалгагдагч байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн. 7 байгууллагад дүгнэлт гаргахаас татгалзсан байна.	Бүрэн хэрэгжсэн
7	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	2025.01.02 2025.02.25	Монгол Улсад гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй 202 төсөл, хөтөлбөрийн нэгжээс 51 нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 151 нэгжийн санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн байна. Аудитаар 41 нэгжид өөрчлөлтгүй, 10 нэгжид хязгаарлалттай дүгнэлтийг тус тус гаргаж, төсөл, хөтөлбөрийн нэгжийн удирдлагад хүргүүлжээ.	Бүрэн хэрэгжсэн
8	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	2025.01.02 2025.02.25	Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасан хугацаанд 5357 төсвийн шууд захирагчдын 2761 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2596 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн байна. Аудитаар 2312 байгууллагад өөрчлөлтгүй, 425 байгууллагад хязгаарлалттай, 14 байгууллагад сөрөг дүгнэлтийг тус тус гаргаж, 9 байгууллагад дүгнэлт гаргахаас татгалзсан байна.	Бүрэн хэрэгжсэн

9	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	2025.01.16 2025.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2025 оны А/173 дугаар тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороодод тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
10	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх	2025.01.16 2025.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2025 оны А/173 дугаар тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороодод тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
11	Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	2025.08.25 2025.10.15	Аудитын тайланг МУЕА-ын 2025 оны А/104 дүгээр тушаалаар баталгаажуулж, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурлын даргад 2025.09.12-ны өдрийн 2691, Ерөнхий сайдад 2690, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2692, Сангийн сайдад 2689 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
12	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн;	2025.01.02 2025.06.10	Аудитын тайланг МУЕА-ын 2025.06.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар баталгаажуулан УИХ-д хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

13	Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт	2025.01.03 2025.04.01	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.03.31-ний өдрийн А/35 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.03.31-ний өдөр шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
14	Монгол Улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт	2025.01.02 2025.03.15	Аудитын тайланг МҮЕА-т танилцуулан 2025.03.13-ны А/25 дугаар тушаалаар баталгаажуулан, тайланг 2025.03.13-ны өдөр өдөр шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
15	Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн	2025.01.02 2025.03.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.03.13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.03.14-ний өдөр шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
16	Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	2025.07.15 2025.11.10	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 330.0 сая төгрөгийн гадаад томилолтын зардал 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн төсвийн тодотголоор танагдсанаас шалтгаалан тус төлөвлөсөн аудитыг гүйцэтгэх боломжгүй болсон.	Аудит хийгдээгүй
17	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалтад хийх аудит	2025.02.10 2025.07.01	УИХ-ын Тусгай хяналтын дэд хороонд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн МН/64 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
ХОЁР. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, үр дүн	2025.04.07 2025.11.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.15-ны өдрийн А/152 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.12.15-ы өдөр шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
2	Гамшгийн бэлэн байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт	2025.04.01 2025.12.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.12-ны өдрийн МН/02 дугаар тушаалаар баталгаажуулж, Шадар сайдад 2025.12.12-ны өдрийн МН/89, Ерөнхий сайдад МН/88, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд МН/87, ОБЕГ-т МН/86 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

3	Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн	2025.04.06 2025.07.10	Аудитын тайланг МУЕА-ын 2025.07.09-ний өдрийн А/84 дүгээр тушаалаар баталгаажуулсан. 2025.07.09-ний өдөр шалгагдагч байгууллагууд болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
4	Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /"Тогтвортой хөгжлийн зорилт-2030"-ын 6.1/	2025.08.15 2025.12.17	Аудитын тайланг МУЕА-ын 2025.12.12-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар баталгаажуулан, 2025.12.12-ны өдөр шалгагдагч байгууллагууд болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
5	Засгийн газраас агаар, орчны бохирдлын бууруулах чиглэлээр 2021–2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн	2025.08.15 2025.12.15	Тус аудитын сэдвийг УИХ-ын ТБХ-ны 2025.12.10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвээс хассан	Хасагдсан
6	Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө	2025.04.04 2025.07.10	Аудитын тайланг МУЕА-ын 2025.07.09-ний А/83 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.07.09-ний өдрийн 2094 дугаар албан бичгээр УИХ-ын Төсвийн Байнгын хороо, шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
7	Төрөөс аялал, жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт	2025.08.15 2025.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2025.12.15-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар аудитын тайлан баталгаажуулж, УИХ-ын холбогдох байнгын хороо болон шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
8	Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн	2025.04.07 2025.12.10	Аудитын тайланг МУЕА-ын тушаалаар баталгаажуулж, 2025.12.12-ны өдөр УИХ-ын Төсвийн байнгын хороо, холбогдох бусад байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

9	Уул уурхайн тусгай зөвшөөрөл олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт	2025.04.16 2025.07.09	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.07.08-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар баталгаажуулан, 2025.07.09-ний өдөр УИХ-ын холбогдох байнгын хороо болон шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
10	Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөө, үр ашиг	2025.01.13 2025.06.30	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.05.06-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар баталгаажуулан, УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
11	"Оюу толгой" ХХК-ийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн	2025.04.16 2025.07.09	Тус аудитын сэдвийг УИХ-ын ТБХ-ны 2025.12.10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвээс хассан	Хасагдсан
12	Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн	2025.06.01 2025.09.01	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.10.15-ны өдрийн А/120 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.10.15-ны өдөр УИХ-ын байнгын хороо болон холбогдох байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
13	Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө	2025.09.15 2025.12.25	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.25-ны өдрийн А/163 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.12.25-ны өдөр УИХ-ын холбогдох байнгын хороо, шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
14	Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүн	2025.09.01 2025.11.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.11.14-ний өдрийн А/133 дугаар тушаалаар баталгаажуулан, 2025.11.18-ний өдөр УИХ-ын байнгын хороо, шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
15	Стратегийн ач холбогдол бүхий төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл	2025.08.15 2025.12.01	Тус аудитын сэдвийг УИХ-ын ТБХ-ны 2025.12.10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвээс хассан	Хасагдсан

16	Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө	2025.08.15 2025.11.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.22-ны өдрийн А/158 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.12.22-ны өдөр УИХ-ын байнгын хороо, шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
17	Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах	2025.08.15 2025.11.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.11.14-ний өдрийн А/132 дугаар тушаалаар баталгаажуулан, 2025.11.14-ний өдөр УИХ-ын холбогдох байнгын хороо, болон шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
18	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	2025.01.15 2025.06.20	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.06.20-ны өдрийн А/62 дугаар тушаалаар баталгаажуулж УИХ-ын холбогдох байнгын хороо, шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
19	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон "Хөдөө аж ахуйн корпорац" ТӨХХК үйл ажиллагаа, үр дүн	2025.08.15 2025.12.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.10.31-ний өдрийн А/130 дугаар тушаалаар баталгаажуулж, 2025.11.14-ний өдөр УИХ-ын холбогдох байнгын хороо, болон шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
20	Арилжааны банкуудад төсөв, Засгийн газрын тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс байршуулсан хөрөнгийн үр дүн	2025.12.15 2026.06.10	Аудитыг төлөвлөсөн хугацааны дагуу гүйцэтгэж байна. Тайланг 2026.06.10-нд УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлнэ.	Хэрэгжих шатанд
21	Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг, зардал	2025.01.15 2025.06.20	Аудитын тайланг МҮЕА-н 2025.06.19-ний өдрийн А/61 дүгээр тушаалаар баталгаажуулж, 2025.06.20-ны өдөр шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороонд тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

22	Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрөөс баримталж буй бодлого болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн	2025.08.15 2025.12.15	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.15-ны өдрийн А/153 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулж, 2025.12.15-ны өдөр УИХ-ын холбогдох байнгын хороо болон шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
23	Үнэ тогтворжуулах зорилгоор төрөөс олгож буй татаас, нөхөн олговрын зарцуулалтын үр дүн	2025.12.15 2026.06.10	Аудитыг төлөвлөсөн хугацааны дагуу гүйцэтгэж байна. Тайланг 2026.06.10-нд УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлнэ.	Хэрэгжих шатанд
24	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт;	2025.05.01 2025.09.30	Аудитын тайланг МҮЕА-ын 2025.12.31-ны өдрийн А/185 дугаар тушаалаар баталгаажуулж, УИХ-ын холбогдох байнгын хороо болон шалгагдагч байгууллагуудад тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны статистик мэдээ, гүйцэтгэлийн тайлан

Төрийн аудитын байгууллагаас 2025 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 31,257.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оны илрүүлэлтийн дүнтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.


Илэрсэн зөрчлийн 10,979.8 тэрбум төгрөгийг аудитын явцад 6,989 тохиолдолд залруулсан бөгөөд энэ нь аудитын үйл ажиллагааны явцад зөрчлийг шуурхай засаж залруулахад тодорхой үр дүн гарсныг харуулж байна.

Харин аудитын явцад залруулагдаагүй 20,277.4 тэрбум төгрөгийн зөрчилд аудитын шийдвэрлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд Үүнд:


- 57.4 тэрбум төгрөгийн дүнтэй 3,014 төлбөрийн акт,
- 14,369.3 тэрбум төгрөгийн дүнтэй 7,424 албан шаардлага,
- 5,357.0 тэрбум төгрөгийн дүнтэй 11,998 зөвлөмж,
- 437.9 тэрбум төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 296 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.
- Мөн 55.8 тэрбум төгрөгийн дүн бүхий 51 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар хүргүүлсэн байна.

Эдгээрээс харахад аудитын байгууллага нь илэрсэн зөрчлийг зөвхөн бүртгэн мэдээлэхээс гадна санхүүгийн хариуцлага тооцуулах, байгууллагын үйл ажиллагааг засаж сайжруулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлж зөрчлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шийдвэрлэлтийн ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл 1. 2025 оны аудитын шийдвэр



Аудитын төрлөөр



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны статистик мэдээ

Аудитаар илрүүлсэн нийт 20,277.4 тэрбум төгрөгийн зөрчлийн дийлэнхийг санхүүгийн аудитаар илрүүлсэн байна. Тухайлбал, нийт зөрчлийн 83.9 хувь буюу 17,019.5 тэрбум төгрөгийг санхүүгийн аудитаар, 8.5 хувь буюу 1,717.9 тэрбум төгрөгийг гүйцэтгэлийн аудитаар, 7.6 хувь буюу 1,540.0 тэрбум төгрөгийг нийцлийн аудитаар тус тус илрүүлсэн байна.

Тайлант онд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. 2025 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт (тоо, хувь)

Зөрчлийн төрөл	2025 онд өгсөн (тоо)	2025 онд хэрэгжсэн (тоо)	Хэрэгжилтийн хувь	Статистик мэдээнээс хасагдсан	Үлдэгдэл
Зөвлөмж	11,998	8,880	74.0%		3,118
Төлбөрийн акт	3,014	2,645	87.8%	6	363
Албан шаардлага	7,424	5,688	76.6%	3	1,733
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	296	242	81.8%		54
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	51	1	2.0%	30	39

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны статистик мэдээ

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант онд шинээр өгсөн 22,783 шийдвэрээс 17,456 нь хэрэгжсэн бөгөөд тоон үзүүлэлтээр авч үзвэл дундаж хэрэгжилтийн түвшин 76.6 хувьтай байна. Энэ нь аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийн дийлэнх хэсэг хэрэгжиж байгааг харуулж байна.

Хүснэгт 3. 2025 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт (дүн, төрөл)

Зөрчлийн төрөл	Илрүүлэлт (тэрбум төгрөг)	Хэрэгжилт (тэрбум төгрөг)	Хэрэгжилт хувь	Статистик мэдээнээс хасагдсан (тэрбум)	Үлдэгдэл (тэрбум төгрөг)
Зөвлөмж	5,357.0	1,426.7	26.6%	-	3,930.2
Төлбөрийн акт	57.4	31.3	54.5%	0.06	26.1
Албан шаардлага	14,369.3	3,244.4	22.6%	0.10	11,124.8
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	437.9	382.8	87.4%	-	55.1
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	55.8	15.8	0.03%	42.7	13.1
Нийт	20,277.4	5,101.0	25.1%	42.86	15,149.2


Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны статистик мэдээ

Мөнгөн дүнгээр тооцоход тайлант онд шинээр өгсөн 20,277.4 тэрбум төгрөгийн шийдвэрээс 5,085.3 тэрбум төгрөгийн дүн бүхий шийдвэр хэрэгжиж, 25.1 хувийн хэрэгжилттэй байна.

ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ТӨЛҮҮЛЭХ

Тайлант оны эхэнд төрийн албан тушаалтны төрд учруулсан 2.51 тэрбум төгрөгийн хохирлын үлдэгдэл бүртгэлтэй байсан бөгөөд уг үлдэгдлээс тайлант хугацаанд 0.07 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулж, 9 шийдвэр буюу 9.4 хувь нь хэрэгжсэн байна. Мөн тайлант онд 1.43 тэрбум төгрөгийн хохирлыг 33 төрийн албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэснээс 13 буюу 39.4 хувь нь хэрэгжиж, 0.22 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

Дүрслэл 2. 2025 онд Төрд учруулсан хохирлыг төлүүлсэн байдал



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны статистик мэдээ

Харин өмнөх оны үлдэгдэл 96 шийдвэрээс 87 буюу 90.6 хувь, тайлант онд шинээр тогтоосон 33 шийдвэрээс 20 буюу 60.6 хувь нь хэрэгжээгүй үлдсэн байна. Ийнхүү нийт 129 шийдвэрийн 107 буюу 83 хувь нь хэрэгжээгүй байгаа нь төрд учруулсан хохирлыг барагдуулах талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, өмнөх онуудаас шилжсэн шийдвэрийн хэрэгжилт удаашралтай байгааг харуулж байна.

АУДИТЫН ҮР ӨГӨӨЖ

Аудитын үр өгөөж нь төрийн аудитын байгууллага төсвөөс авсан санхүүжилтийн нэг төгрөг тутамд хэдий хэмжээний санхүүгийн болон чанарын өөрчлөлтийг бий болгосныг илэрхийлэх үр дүнгийн үзүүлэлт юм. Аудитын үр өгөөж санхүүгийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх, санхүүгийн бус үр өгөөж буюу мөнгөн дүнгээр хэмжигдэхгүй боловч байгууллагын үйл ажиллагаанд гарсан зохион байгуулалтын болон чанарын өөрчлөлтөөр илэрдэг.



Тайлант онд илрүүлэлтийн дүн өндөр, мөнгөн дүн ихтэй шийдвэрүүд давамгайлсан, зарим асуудал хууль, хяналтын байгууллагад шилжсэн, мөн урт хугацаанд хэрэгжих шинжтэй албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн баталгаажаагүй зэрэг нь үр өгөөжийн коэффициентэд нөлөөлж байна.

Тайлант хугацаанд улс, орон нутгийн төсөвт нийт 62.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүнээс 42.3 тэрбум төгрөг нь төлбөрийн актаар, 20.5 тэрбум төгрөг нь албан шаардлагын хэрэгжилтээр бүрджээ. Энэ нь аудитын дүнд бодит мөнгөн урсгал бий болж, төсвийн орлогын төвлөрүүлэлтэд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байна. Гэсэн хэдий ч нийт илрүүлсэн зөрчлийн дүнтэй харьцуулахад бодитоор төвлөрсөн мөнгөн дүн харьцангуй бага байгаа нь их дүнтэй шийдвэрүүдийн хэрэгжих хугацаа болоогүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд 1,521.1 тэрбум төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 967 арга хэмжээнд санхүүгийн бус үр өгөөж хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд улсын төсвөөс авсан 1 төгрөгийн санхүүжилт тутамд 32.1 төгрөгийн санхүүгийн үр өгөөжтэй ажилласан байна.

2. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/82 дугаар тушаалаар "ТАБ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г шинэчлэн 3 бүлэг 13 зорилтын хүрээнд 152 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 90.86 хувийн биелэлттэй гарчээ. Үүнд:

Хүснэгт 4. ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Зорилт	Гүйцэтгэлийн зорилт	Нийт арга хэмжээ	Эзлэх хувь	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Үнэлээ гүй
				Үнэлгээ	100	80.0	50.0	0.0	
Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	6	94	61.8%	92.60	58	33	-	-	3
Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	4	25	16.4%	79.60	11	5	8	-	1
Үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	3	33	21.7%	94.25	27	4	2	-	-
Нийт	13	152	100%	90.86	96	42	10	-	4

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

- "бүрэн хэрэгжсэн" – (90.0–100.0) – 96 арга хэмжээ
- "хэрэгжих шатанд" – (70.0–89.0) – 42 арга хэмжээ
- "хэрэгжилт хангалтгүй" – (50.0–65.0) – 10 арга хэмжээ
- "хэрэгжээгүй" – (0.0) – 0 арга хэмжээ
- "Үнэлээгүй" – 4 арга хэмжээ байна.

ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн 32 нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 1,197 арга хэмжээг тусган хэрэгжүүлжээ. 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр УАГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дундаж үнэлгээ 92.79, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дундаж үнэлгээ 92.21 хувьтай гарсан байна. Үүнээс:

- "бүрэн хэрэгжсэн" – 847 арга хэмжээ (70.76 хувь)
- "хэрэгжих шатанд" – 219 арга хэмжээ (18.29 хувь)
- "хэрэгжилт хангалтгүй" – 18 арга хэмжээ (1.50 хувь)
- "хэрэгжээгүй" – 0 арга хэмжээ (0 хувь)
- "үнэлээгүй" – 112 арга хэмжээ тус тус эзэлж байна.

ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

ЗББН	Нэгж	Үнэлгээ
Санхүүгийн аудитын газар, Гүйцэтгэлийн аудитын газар, Нийцлийн аудитын газар, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймаг дахь ТАГ	14	95.25–99.79
Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар, Тусгай чиг үүргийн аудитын газар, Дотоод аудитын газар, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Увс, Ховд, Нийслэл дэх ТАГ	11	93.16–94.87
Тамгын газар, Бодлого, төлөвлөлт, инновацын газар, Чанарын удирдлага, эрсдэлийн газар, Мэдээлэл, технологийн төв, Булган, Өмнөговь, Хөвсгөл аймаг дахь ТАГ	7	90.33–92.57

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд 2025 онд дараах 4 чиглэлээр нийт 395 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.19 хувьтай гарсан байна. Үүнд:

Хүснэгт 6. Үүрэг даалгаврын хэрэгжилт

Үүрэг даалгаврын төрөл	Шийдвэрийн тоо /Тушаал, хурал/		Үүрэг даалгаврын тоо (ЗББН)	Үнэлгээ
	Нийт	Үүнээс: Хяналтад авсан		
МУЕА-ын "А" тушаал /2025 оны 185 тушаалаас хяналтад 40 тушаал авсан/	40	Хяналтад авсан 40 тушаалын нийт 42 заалт	129	96.41
Удирдах ажилтны зөвлөгөөн		1 зөвлөгөөн	9	98.65
Удирдлагын зөвлөлийн хурал		4 хурал	36	88.64
Удирдлагын шуурхай хуралдаан		Тайлант хугацааны нийт 22 хурлаас нийт 221 үүрэг даалгавар	221	93.08

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

3.1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага нь Үндэсний аудитын газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас бүрдэж байна.


Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн "Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/63 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллага 586 орон тоотой байхаас Үндэсний аудитын газарт бүтцийн 10 нэгж, 191 орон тоотой, Аймаг, нийслэл дэх 22 Төрийн аудитын газарт 350 орон тоотойгоор тус тус баталсан байна.

Гэвч МУ-ын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Төрийн аудитын байгууллагын цалингийн зардал хасагдсан тул орон тоог 10 хүртэл хувиар бууруулах шаардлага үүссэн байна.

Албан хаагчдын нас, хүйс

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын 42 хувь нь эрэгтэй, 58 хувь нь эмэгтэй бол албан хаагчдын дундаж нас 41 байна. Нийт албан хаагчдын 44.5 хувь нь 40-өөс доош настай бол 55.5 хувь нь 40-өөс дээш настай байна.

Дүрслэл 3. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын нас, хүйсийн суварга



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн нас, хүйсийн бүтэц нь өнөөгийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад хангалттай боловч дунд хугацаанд (5–10 жил) тэтгэвэрт гарах албан хаагчдын тоо өсөх, туршлагатай албан хаагчид цөөрөх эрсдэлийг дагуулж болзошгүй байгаа тул залгамж халаа, менторшип, шаталсан мэргэшүүлэх бодлогыг стратегийн түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, тогтвортой байдал

Тайлант хугацаанд хууль тогтоомж, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн шатлан дэвших зарчмыг баримтлан Төрийн аудитын байгууллага дотроо албан тушаал дэвшүүлэн 26, бүтцийн нэгж дотроо ижил ангиллын албан тушаалд шилжүүлэн 37, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн 23, төрийн албан хаагчийн нөөцөөс 84, нийт 170 төрийн албан хаагчийг томилсон байна.

Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 101 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 6 удаа зохион байгуулж, шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн 132 иргэн, албан хаагчаас шалгалт хамгийн өндөр оноо авч тэнцсэн 84 иргэн, албан хаагчдыг нэр дэвшүүлэн томилсон байна.

Мөн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 45, байгууллага хооронд шилжсэн 14, тэтгэвэрт гарсан 14, нийт 73 албан хаагч чөлөөлөгдсөн, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 14 албан хаагч байна.

ТАБ-ын хэмжээнд бүтэц орон тоог шинэчлэн баталснаар аудитын чиг үүргийн албан хаагчид 80.2 хувь, аудитын бус чиг үүргийн албан хаагчид 19.8 хувь, удирдлагын тоо 46-аас 34 болон буурсан байна.

Нийт албан хаагчдын Төрийн аудитын байгууллагад ажилласан жил, туршлагын бүтцийг авч үзвэл дараах хувьтай байна.

Хүснэгт 7. Албан хаагчдын ТАБ-д ажилласан жилийн байдал

Байгууллага, нэгж	Нийт	0–5 жил	6–10 жил	11–15 жил	16-аас дээш жил
ҮАГ	191	110/57.5%	32/16.7%	25/13%	24/12.5%
АНТАГ	350	166/47.4%	72/20.5%	75/21.4%	37/10.5%
Нийт	541	276/51%	104/19.2%	100/18.4%	61/11.2%

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан

Албан хаагчдын ажилласан жилийн бүтэц болон шилжилт хөдөлгөөний зарим үзүүлэлтийг авч үзэхэд 0–5 жил ажилласан албан хаагч 51 хувь, харин 16 ба түүнээс дээш жил ажилласан албан хаагчид 11.2 хувийг тус тус эзэлж байна. Мөн шинээр орсон 103 албан хаагч нь нийт албан хаагчдын 19 хувийг бүрдүүлж байгаа нь хүний нөөцийн бүрэлдэхүүнд тодорхой хэмжээний өөрчлөлт орсныг илтгэж байна. Дээрх үзүүлэлтүүд нь байгууллагын ажиллах хүчний туршлагын бүтэц харьцангуй шинэчлэгдэж байгааг харуулахын зэрэгцээ цаашид залуу ажилтны эзлэх хувийн жин нэмэгдэх хандлагатай байгааг илэрхийлж байна.

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Албан хаагчдын боловсрол

Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчдын боловсролын байдлыг авч үзэхэд дээд боловсрол эзэмшсэн албан хаагчид зонхилж байгаа бөгөөд боловсролын түвшин болон мэргэжлийн чиглэлийн хувьд чиг үүргийг гүйцэтгэх бүтэц бүрэлдсэн байна.

Хүснэгт 8. Боловсролын түвшний бүтэц

Байгууллага, нэгж	Доктор	Магистр	Бакалавр	Тусгай мэргэжлийн	Техникийн, мэргэжлийн	Бүрэн дунд
ҮАГ	2	112	74	1	2	0
АНТАГ	1	157	177	4	4	7
Нийт	3/0.6%	269/49.7%	251/46.4%	5/0.9%	6/1.1%	7/1.3%

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан

Нийт албан хаагчдын боловсролын болон мэргэжлийн түвшнийг авч үзэхэд магистр болон түүнээс дээш зэрэгтэй 272 буюу 50.3 хувь, бакалаврын зэрэгтэй 251 буюу 46.4 хувь, тусгай мэргэжлийн, техник мэргэжлийн болон бүрэн дунд боловсролтой 18 буюу 3.3 хувьтай байна.

Хүснэгт 9. Мэргэжлийн бүтэц

Байгууллага, нэгж	Нягтлан бодогч	Санхүү	Эдийн засагч	Эрх зүйч	Инженер	Бусад
ҮАГ	69	16	28	34	9	35
АНТАГ	209	22	46	28	6	39
Нийт	278/51.4%	38/7%	74/13.7%	62/11.5%	15/2.8%	74/13.7%

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан


Мэргэжлийн бүтцийн хувьд нийт албан хаагчдын 72.1 хувь нь нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн бол үлдэх 27.9 хувь нь эрх зүй, инженер болон бусад төрлийн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгтэй уялдсан мэргэжлийн бүтэц зонхилж байгааг харуулж байна.

Дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэн үзэхэд Төрийн аудитын байгууллагын хүний нөөц нь дээд боловсролтой албан хаагчдаас бүрдсэн бөгөөд мэргэжлийн хувьд санхүү, эдийн засгийн чиглэл давамгайлсан бүтэцтэй байна. Үүний зэрэгцээ бусад мэргэжлийн оролцоо тодорхой хэмжээнд хадгалагдаж байгаа нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн олон талт мэргэжлийн бүрэлдэхүүн бүрдсэнийг илэрхийлж байна.

Албан хаагчдын албан тушаалын ангилал

Албан хаагчдад албан тушаалын зэрэг дэвийг "Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу МУЕА-ын тушаалаар жилд нэг удаа шинээр болон нэмэгдүүлэн олгодог.

Дүрслэл 4. ТАБ-ын албан хаагчдын албан тушаал



Мэргэжлийн суурь бүтцийн хувьд байгууллага гүйцэтгэх түвшний (аудитор) орон тоо давамгайлсан, үндсэн чиг үүрэгтээ төвлөрсөн бүтэцтэй байна. Энэ нь аудитын байгууллагын хувьд чиг үүргийн онцлогт нийцсэн бүтэцтэй байна.

3.2. АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Төрийн аудитын байгууллагын 2025 оны сургалт, хөгжлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлаар нийт 105 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 11,270 албан хаагч хамрагдсан байна. Үүнээс 99 сургалт зохион байгуулсанд 3,856 оролцогч YAAG-аас оролцсон байна. Нэг сургалтад ногдох оролцогчдын тоо дунджаар 107 байгаа нь сургалтын хүртээмж өргөн хүрээтэйг илтгэх бөгөөд сургалтад хамрагдсан албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар дундаж үзүүлэлт 85.6 хувьтай байна.

Хүснэгт 10. Сургалтын төрөл, хамрагдсан албан хаагчдын тоо

Д/д	Сургалтын хэлбэр, төрөл	Зохион байгуулсан сургалтын тоо	Хамрагдсан албан хаагчдын тоо
A	YAAG-аас зохион байгуулсан сургалт	67	10,655
1.	Цахим сургалт	44	7,659
1.1	Үндсэн	39	3,235
1.2	Хөгжлийн	5	4,424
2.	Танхимын сургалт	7	115
3.	Онлайн сургалт	14	2,167
4.	Хосолсон сургалт	2	714
Б	Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт	13	520
В	Гадаад сургалт	25	95
	Нийт	105	11,270

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан
Сургалтын хэлбэрийн дүн шинжилгээ

Сургалтын хэлбэрийн дүн шинжилгээ

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2025 онд үндсэн сургалтын талбараар нийт 32 сургалт зохион байгуулснаас сертификат олгох албан ёсны 12 цахим хичээлээр нийт 17 сургалтыг зохион байгуулж, 947 албан хаагчийг хамруулсан ба үүнээс 760 буюу 80.3 хувь албан хаагч нь сургалтаа бүрэн дуусгаж, 659 буюу 69.6 хувь албан хаагч нь сертификат авсан байна. Харин бусад 15 цахим хичээлийн сургалтыг өмнө нь судалж сертификат авсан 2288 албан хаагчдын ажлын хэрэгцээнд үндэслэн "Нээлттэй сургалтын хөтөлбөр" хэлбэрээр бүтэн жилийн хугацаанд зохион байгуулсан.

Хөгжлийн чиглэлийн нийт 5 төрлийн цахим сургалтад давхардсан тоогоор нийт 4,424 албан хаагч хамрагдсанаас "Аудитын 5 минут" хичээлийн 57 багц сургалтад 1983, "Сайн туршлагаа хуваалцъя" хичээлийн 27 багц сургалтад 1327, "Хувь хүний хөгжил" хичээлийн 55 багц сургалтад 704, "Гадаад сургалт" хичээлийн 53 багц сургалтад 410, "МООС/Бүх нийтэд нээлттэй сургалт" хичээлийн 1 багц буюу нийтдээ 193 багц сургалтад албан хаагчид тус бүр хамрагдсан байгаа нь нэг хөгжлийн сургалтад дунджаар 23 албан хаагч хамрагдсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд танхимын нийт 7 сургалтад 115 албан хаагч хамрагдсан нь нэг сургалтад дунджаар 16 оролцогч ногдож байгаа бол онлайн (вебинар) хэлбэрийн 14 сургалтад 2,167 оролцогч хамрагдсан бол хосолсон хэлбэрийн 2 сургалтад нийт 714 оролцогч хамрагдсан байна.

Харин бусад байгууллагаас зохион байгуулдаг сургалтуудын хувьд 2025 оны 6 дугаар сарын төсвийн тодотголын улмаас сүүлийн хагас жилд сургалтын зардал хасагдсан ч байгууллага хоорондын хамтын ажиллагаа, дэмжлэгийн хүрээнд нийт 13 сургалтад 520 албан хаагч хамрагдсан бол гадаад 25 сургалтад 95 оролцогч хамрагдсан байна.

4. САНХҮҮ БУЮУ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1. Төсвийн төлөвлөлт

ТАБ-ын 2025 оны төсвийг 56.8 тэрбум төгрөгөөр төлөвлөн Сангийн яам болон УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байна. ТЕЗ-ийн төсвийг хүргүүлсэн саналаас 2.4 тэрбум төгрөгөөр бууруулан 54.4 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн тодотголоор дахин 6.0 тэрбум төгрөгөөр бууруулж 48.4 тэрбум төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оноос 4.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

АДБ-уудын үндсэн хууль хэмээн үздэг Лимагийн тунхаглалын 7 дугаар зүйлийн 1-д "АДБ ажил үүргээ хэрэгжүүлэх боломж олгохуйц санхүүгийн хөрөнгөөр хангагдана" мөн Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т "Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана" гэж ТАБ-ын санхүүгийн хараат бус, бие даасан байдлыг тодорхойлсон байна.

Улмаар уг хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т "Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж ТАБ-ын гүйцэтгэх засаглалаас хараат бус байх байдлыг хангаж өгсөн байна.

Гэсэн хэдий ч ТАБ нь жил бүр төсвийн төслөө боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хянагдан, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг ба 2020 онд 1.4 тэрбум, 2021 онд 2.0 тэрбум, 2022 онд 1.1 тэрбум, 2023 онд 2.6 тэрбум, 2024 онд 1.2 тэрбум, 2025 онд 2.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

4.2. Төсвийн гүйцэтгэл

Төрийн аудитын байгууллагын төсөв 2025 онд 48.4 тэрбум төгрөгөөр батлагдаж, нийт 48.0 тэрбум төгрөг олгогдсоныг зарцуулж, гүйцэтгэл 99.0 хувьтай, 0.3 тэрбум төгрөгийг хэмнэсэн ба Сангийн яамнаас 0.1 тэрбум төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Нийт санхүүжилтийн 17.9 тэрбум төгрөг буюу 37.3 хувийг ҮАГ, 30.1 тэрбум төгрөг буюу 62.7 хувийг АНТАГ-т хуваарилжээ. Батлагдсан төсвийн 78.2 хувийг цалин, нэмэгдэл урамшуулалд, 9.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, бусад зардалд 12 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 11. Төрийн аудитын байгууллагын 2025 оны төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)

Д/д	Зардлын бүлэг	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Хэтрэлт (-) Хэмнэлт (+)
		Урсгал зардал	Эзлэх хувь	Урсгал зардал	Эзлэх хувь	
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	37,877.7	78.2	37,726.6	78.7	154.1
2	Нийгмийн даатгалын шимтгэл	4,753.8	9.8	4,727.6	9.9	26.2
3	Байр ашиглалттай холбоотой зардал	692.7	1.4	677.0	1.4	15.7
4	Хангамж, бараа материалын зардал	453.8	0.9	425.8	0.9	28.0
5	Эд хогшил, урсгал засварын зардал	272.3	0.6	270.1	0.6	2.2
6	Томилолт, зочны зардал	868.4	1.8	793.7	1.7	74.7
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр,	2,041.5	4.2	1,924.5	4.0	117.0
8	Бараа үйлчилгээний бусад зардал	196.8	0.4	174.5	0.4	22.3
9	Урсгал шилжүүлэг	1,258.9	2.6	1,224.0	2.6	31.9
10	Хөрөнгийн зардал	-	-	-	-	-
	НИЙТ ЗАРДАЛ	48,415.9	100.0	47,943.8	100.0	472.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.54¹ -д заасан цаглаварт хугацаа болоогүй байгаа тул ТЕЗ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд үнэлгээ хийгдээгүй болно.

Төрийн аудитын байгууллага нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын харьяа байгууллага юм.

ТАБ-ын хэмжээнд жилд дунджаар 6800 гаруй шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлан, 260 орчим гүйцэтгэл, нийцлийн аудитыг гүйцэтгэж байгаа бөгөөд 1 аудитад зарцуулах дундаж хугацаа 70 орчим (хуанлийн) хоног байгаа нь гүйцэтгэлийн аудитын 90–180 хоногт гүйцэтгэдэг олон улсын жишгээс 1.3–2.6 дахин богино хугацаанд аудитыг гүйцэтгэж байна.

УИХ-ын ТБХ-нд хүргүүлсэн 27 сэдэв, АНТАГ-ын бодлогоор гүйцэтгэх 41 сэдэв, нийт 68 сэдэвт аудитыг 2026 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн. Эдгээр аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай хүн өдрийн тооцооллыг гаргахад 70,752 хүн/өдөр зарцуулахаар гарч байгаа нь бодит нөөцөөс² 7,538 хүн/өдрөөр илүү байна.

Сүүлийн жилүүдэд Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, ажлаа тайлагнадаг байгууллагуудын албан тушаалтнуудын үндсэн цалин нэмэгдсэнтэй харьцуулахад Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээ харьцангуй доогуур түвшинд хэвээр байна.

Иймд Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, ажлаа тайлагнадаг байгууллагуудын ижил түвшний албан тушаалын цалингийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх нь мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой хадгалах, аудитын байгууллагын хараат бус байдал, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ҮАГ-ын хувьд Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан төрийн албан хаагчийн ажлын өрөөний талбайн хэмжээ болон ажлын байр хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 4 ЗББН (БТИГ, ЧУЭГ, ДАГ, АШХГ) хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн байранд түрээсийн төлбөр төлж үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10³ дахь заалттай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т "Төрийн алба

1 Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2 2026 онд ҮАГ (114 албан хаагч) 18,139 хүн/өдөр, АНТАГ (аймаг 236, нийслэл 49 албан хаагч) 45,075 хүн/өдөр, нийт 63,214 хүн/өдрийн бодит нөөц байна

3 Төрийн аудитын дээд байгууллагын байр төрийн хамгаалалтад байна.

хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:" гэсэн заалт ТАБ-ын хэмжээнд хэрэгжихгүй байна.

Цаашид холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар ТАБ-ын албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүр 1 хувиар нэмэгдүүлэн дээрх журмын дагуу олгуулдаг байхаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

ҮАГ-ын төсвийн гүйцэтгэлийн талаар

Зардлын бүтцэд тогтмол шинжтэй зардал давамгай (цалин, нэмэгдэл урамшуулал, НДШ) хэвээр ч, хувьсах шинжтэй зардлуудад (томилолт, хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил гэх мэт) хэмнэлтийн үр дүн гарсан ба 0.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 12. Үндэсний аудитын газрын 2025 оны төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)

Үзүүлэлт	2024		2025		Өмнөх оноос	Батлагдсан төл-гөөнөөс
	Төл-гөө	Гүйц-л	Төл-гөө	Гүйц-л		
Нийт зардлын дүн	18,033.5	16,814.0	19,897.75	19,550.70	2,736.70	(347.05)
Урсгал зардлын дүн	17,561.0	16,378.2	19,897.75	19,550.70	3,172.50	(347.05)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,813.5	10,800.9	14,400.79	14,311.78	3,510.88	(89.01)
Ажил олгогчоос төлөх НДШ	1,351.7	1,351.7	1,814.65	1,814.65	462.95	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302.4	298.2	367.60	360.34	62.14	(7.26)
Хангамж, бараа материалын зардал	208.4	203.3	155.29	141.09	(62.21)	(14.20)
Эд хогшил, урсгал засварын зардал	410.0	354.1	82.02	80.16	(273.94)	(1.86)
Томилолт, зочны зардал	1,148.5	1,093.2	487.44	414.19	(679.01)	(73.25)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	3,066.4	2,018.6	1,848.67	1,734.39	(284.21)	(114.28)
Бараа үйлчилгээний бусад зардал	260.0	258.3	120.40	101.95	(156.35)	(18.45)
Урсгал шилжүүлэг	472.6	435.7	614.88	592.16	156.46	(22.72)
Хөрөнгийн зардал	-	-	-	-	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	18,033.5	16,814.0	19,891.75	19,550.70	2,736.70	(341.05)
Улсын төсвөөс санхүүжих	18,033.5	16,814.0	19,891.75	19,550.70	2,736.70	(341.05)

Эх сурвалж: ҮАГ-ын 2025 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тамгын даргын 2025 оны А/55 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулж, 6 дугаар сард хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд нийт 0.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 953 ширхэг цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 404 нэр төрлийн 0.3 тэрбум төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган дахин үнэлэх, мөн 2 автомашиныг балансаас баланст шилжүүлэх саналуудыг ТӨБЗГт хүргүүлж, холбогдох шийдвэрийн дагуу хэрэгжилтийг ханган ажилласан байна.

4.3. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ҮАГ-ын буюу ТШЗ-ын 2025 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1⁴ -д заасан цаглаварт хугацаанд гаргаж, УИХ-ын даргын захирамжаар томилогдсон "Ди Эй Би Жи аудит" ХХК-иар санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлгэж, "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.7 тэрбум төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 13. Үндэсний аудитын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (сая төгрөг)

Балансын зүйл	2024 он	2025 он	Өмнөх онтой харьцуулахад
Мөнгөн хөрөнгө	190.99	7.49	-183.5
Авлага	1,158.40	2,197.75	1,039.35
Урьдчилгаа	74.41	287.61	213.2
Бараа материал	1,109.09	778.47	-330.62
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,532.92	3,271.32	738.4
Биет хөрөнгө	2,390.22	2,154.64	-235.58
Биет бус хөрөнгө	107.93	364.49	256.56
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,498.15	2,519.13	20.98
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,031.07	5,790.45	759.38
Богино хугацаат өр төлбөр	1,104.20	1,243.07	138.87
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,104.20	1,243.07	138.87
Засгийн газрын хувь оролцоо	3926.87	4,547.38	620.51
Засгийн газрын оруулсан капитал	553.23	553.23	0
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	553.23	553.23	0
Хуримтлагдсан үр дүн	3,183.00	3,994.15	811.15
Өмнөх үеийн үр дүн	2,193.42	3,373.63	1,180.21
Тайлант үеийн үр дүн	989.57	620.51	-369.06
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190.64	0	-190.64
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	5,031.07	5,790.45	759.38

Эх сурвалж: ҮАГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

⁴ Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

Хөрөнгийн өсөлтөд авлагын үлдэгдэл өмнөх оноос 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж, авлагын үлдэгдлийг бууруулж ажиллах шаардлагатай байна.

4.4. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.1, 3.2-т заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг шалгуур үзүүлэлт болгон үнэллээ.

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, тайлант хугацаанд байршуулбал зохих 89 мэдээллийг 100 хувь цахим хуудсанд байршуулсан байна.

4.5. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 15-ны өдөр баталж, хэрэгжилтийн явцад холбогдох хууль, журмын дагуу нийт 3 удаа шинэчилж, хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант онд нийт 1,979.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 худалдан авах ажиллагааг төлөвлөснөөс 748.6 сая төгрөгийн 6 ажиллагааг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 85.7 хувьтай биелсэн байна.

МУЕА-ын 2025 оны "Жагсаалт шинэчлэн батлах тухай" А/53 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Суурин болон зөөврийн компьютер, техник хэрэгсэл худалдан авах" тендер шалгаруулалтын багцын жагсаалтыг 1,178.8 сая төгрөгөөр тусган батлуулснаас 1,102.4 сая төгрөгөөр худалдан авалт хийх сонгон шалгаруулалт амжилттай болсон байна.

Гэвч МУЗГ-ын 2025 оны «Төсвийн хэмнэлтэд тооцох тухай» 02 дугаар тогтоолоор дээрх арга хэмжээг төсвийн хэмнэлтэд тооцох болсон мөн 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр МУИХ-аас МУ-ын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталснаар тус арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тул гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн байна.

5. ДҮГНЭЛТ

Системчилсэн үнэлгээний явцад цуглуулсан нотлох зүйл, үнэлгээний дүнд үндэслэн Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

- ТАБ нь 2025 онд "Чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх" зорилтыг дэвшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилт 90.86 хувьтай үнэлэгдсэн нь ТАБ-ын бодлого, төлөвлөлт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө нэмэгдэж, хариуцлага сайжирч буйг харуулж байна.
- УИХ-ын ТБХ-ны тогтоол болон МУЕА-ын тушаалаар 2025 онд 63 аудитын сэдэв батлагдсанаас 61 аудитыг гүйцэтгэж Улсын төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилт тутамд ногдох аудитын үр өгөөж 32.1 төгрөг болсон байна.
- Аудитаар өгсөн 22,783 шийдвэрээс 17,456 нь буюу 76.6 хувь нь хэрэгжиж, 23.4 хувийн шийдвэр хэрэгжээгүй нь зарим шийдвэрүүдийн хэрэгжих хугацаа нь харилцан адилгүй төлөвлөгдсөн, өндөр дүнтэй шийдвэрүүд урт хугацаанд хэсэгчлэн хэрэгжих зэргээс шалтгаалсан байна.





- Албан хаагчдын чадамжийг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан шинэ ажилтны болон тасралтгүй сургалтын цахим хичээлийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа нь цаг хэмнэсэн ололттой сайн туршлага болж байна.
- Төсвийг жил бүр төлөвлөснөөс бууруулан баталж байгаа нь холбогдох хууль зөрчигдөж, хараат бус байдал алдагдах эрсдэлтэй байна.
- ТАБ-ын нэг жилд гүйцэтгэж буй аудитын тоо, ажлын ачаалал, хүний нөөцийн нөхцөл байдалд харгалзуулан үзэхэд одоогийн үндсэн цалин нь бодит шаардлагад нийцэхгүй байна. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг ижил түвшний байгууллагын цалингийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх нь мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой хадгалах, аудитын байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой.

